



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН НЭГДСЭН
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2026 он

АГУУЛГА

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.....	2
ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	2
ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2-3
ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	4-8
4.1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт...	4
4.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.....	4-6
4.3.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	6
4.4.Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт.....	6-7
4.5.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл.....	7-8
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	8-10
5.1.Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.....	8-9
5.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.....	9-10
ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ.....	10-14
6.1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.....	10-14
ДОЛОО. ХӨНДЛӨНГИЙН БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ.....	14-16
7.1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ.....	14-16
7.1.1. Ил тод байдал.....	14-15
7.1.2. Шилэн дансны үнэлгээ.....	15
7.2. Шударга байдлын түвшний үнэлгээ.....	16
НАЙМ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	16-22
7.1. Нэгдсэн дүгнэлт.....	16-21
7.2. Нэгдсэн санал, зөвлөмж.....	21-22
ЕС.ХАВСРАЛТУУД.....	23-129
8.1. Шинэ сэргэлтийн бодлого.....	23-37
8.2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	37-44
8.3.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан	44-108
8.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.....	108-129

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН
НЭГДСЭН ТАЙЛАН**

2026.02.04

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, 3-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын тус тус үндэслэл хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж өгч ажиллалаа.

ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2025 оны 06-р сарын 25-ны өдөр баталсан 07 дугаар тогтоолын дагуу яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн 6 тэргүүлэх чиглэлээр боловсруулсан баталж ажиллаж байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлага
2. Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалт
3. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалт
4. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалт
5. Санхүү, хөрөнгө оруулалт
6. Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

Дээрх чиглэлийн хүрээнд яамны стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичиг, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2025 оны 43

дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 5 багц, 14 үзүүлэлтээс 3 багцын 5 үзүүлэлт болон нэмэлт бодлогын болон холбогдох баримт бичгийн биелэлтийг гарган тайланг хүргүүлж байна. Үлдсэн 3 багцын 9 үзүүлэлтийг дээд шатны холбогдох байгууллагаас гаргана. Үүнд:

Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт- ТАЗ

Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээ- ТАЗ

Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт- ЯАГ

Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт- ЗГХХГ

Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн- ЗГХХГ

Шударга байдлын түвшний үнэлгээ- АТГ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (ил тод байдал, шилэн дансны үнэлгээ)-

ХЗДХ яамны дэргэдэх орон тооны бус зөвлөл, СЯ

Хэрэглэгчийн үнэлгээ- ЗГХХГ.

Яамнаас гаргах үзүүлэлтийн үнэлгээний хувийг тавьсан.

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН ДУНДАЖ ДҮН

"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 4 дүгээр хавсралт

Үзүүлэлт		Хэрэгжилтийн хувь	Жин
1	2	3	4
Бодлогын үр дүн	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн	83.8	
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	91.0	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	93.7	
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	94.5	
Байгууллагын чадамжийн үнэлгээ	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт	-	
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	100	
	Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээ	-	
	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	-	
	Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт	-	
Хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ	Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн	-	
	Байгууллагын шударга байдлын үнэлгээ	80.9	
	Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (ил тод байдал, шилэн дансны үнэлгээ)	-	
	Хэрэглэгчийн үнэлгээний дүн	-	
Нэмэлт оноо	Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий дүнгийн өөрчлөлт (+ оноо)	x	
Ерөнхий дүн:		-	

ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах **10** зорилтын хүрээнд **42** арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 83,8 хувь, “Хангалттай” гэж үнэллээ.

Бодлогын баримт бичигт тусгагдсан нийт 42 арга хэмжээнээс 100%-тай 16; 90%-тай 6; 70%-тай 19; 50%-тай 1 арга хэмжээ байна.

Хэрэгжилтийн гүйцэтгэлийг харуулбал:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв.

хүснэгт-1

№	Гэрээнд туссан арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь				Биелэлт /хувиар/
			85%-иас дээш	70-85% хүртэлх	70 хүртэлх	ХБ	
1	Нийт арга хэмжээ	42	22	19	1	-	83.8

хүснэгт-1.1

№	Бодлого											
	2	88.9	3	83.1	4	80.0	5	100.0	6	83.0	9	81.7
	Хүний хөгжил	Гүйцэтгэлийн хувь	Амьдралын чанар ба дундаж давхарга	Гүйцэтгэлийн хувь	Эдийн засаг	Гүйцэтгэлийн хувь	Засаглал	Гүйцэтгэлийн хувь	Ногоон хөгжил	Гүйцэтгэлийн хувь	Улаанбаатар ба дагуул хот	Гүйцэтгэлийн хувь
1	2.5.1	100	3.2.1	100	4.2.7	70	5.3.5	100	6.3.14	90	9.2.33	70
2	2.5.2	70	3.2.2	70	4.2.8	70			6.4.7	70	9.3.1	70
3	2.5.3	100	3.2.3	100	4.2.19	100			6.4.10	100	9.3.3	70
4	2.5.5	70	3.2.4	70					6.4.21	50	9.3.4	90
5	2.5.6	100	3.2.5	70					6.4.22	70	9.3.38	90
6	2.5.10	100	3.2.6	70					6.4.23	90	9.5.2	100
7	2.5.11	70	3.2.7	70							9.5.3	90
8	2.5.12	100	3.2.8	100								
9	2.2.32	90	3.2.9	100								
10			3.2.10	100								
11			3.2.11	70								
12			3.2.12	70								
13			3.2.13	70								
14			3.2.14	100								
15			3.2.15	70								

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn

Үнэлгээний тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /www.unelgee.gov.mn./-д баталгаажуулсан.

4.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12-р сарын 18-ний өдрийн 218 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны чиг үүргийн хүрээнд 4 бодлогын 82 зорилтын 121 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 онд хангуулж ажиллаж байна. Үүнээс үндсэн хэрэгжүүлэгч 61 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 60 арга хэмжээ байна. Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийхэд 85 хувиас дээш буюу “үр дүнтэй” хэрэгжилттэй 64 арга хэмжээ, 60-84 хувийн буюу “үр дүн хүлээгдэж байгаа” хэрэгжилттэй 14 арга хэмжээ, 30-59 хувийн буюу “Үр дүн хангалтгүй” хэрэгжилттэй 13 арга хэмжээ, 0-29 хувийн буюу “үр дүн гараагүй” хэрэгжилттэй 27 арга хэмжээ, хугацаа болоогүй /ХБ/ 3 арга хэмжээ үнэлэгдэж, 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл “Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 67,4 хувьтай, өссөн дүнгээр 35,6 хувьтай үнэлэгдлээ.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг харуулбал:

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс				ХБ	Тухайн жилийн дүн %	Өссөн дүн %
				85 хувиас дээш	60-84 хувьтай	30-59 хувьтай	0-29 хувьтай			
1	Үндсэн хэрэгжүүлэгч арга хэмжээ	40	61	32	13	4	12	-	69,83	38.81
2	Хамтран хэрэгжүүлэгч арга хэмжээ	42	60	32	1	9	15	3	63.51	33.25
Нийт дүн		82	121	64	14	13	27	3	67.4	35.6

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Хүснэгт-1.1

№	Бодлого															
	1				2				3				4			
	БҮСЧЛӨСӨН ХӨРГЖИЛТНИЙ БОДЛОГО	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	БҮСЧЛӨСӨН ХӨРГЖИЛТНИЙ БОДЛОГО	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	ХҮНИЙ ХӨРГЖИЛТНИЙ БОДЛОГО	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	ХҮНИЙ ЭРХИЙТ ДЭЭДЭЙН ЗАСГИЙН БОДЛОГО
1	1.1.1.1.1	50	50	1.2.1.1.71	100	100	2.1.1.24.206	10	0	2.4.2.1.445	80	40	3.1.3.8.496	30	0	4.2.3.9.1153
2	1.1.1.1.2	30	30	1.2.1.2.75	100	10.5	2.1.1.24.207	100	25	2.4.2.2.446	0	0	3.2.2.11.540	100	5	4.2.4.3.1169
3	1.1.1.1.3	30	30	1.2.1.2.76	0	0	2.1.1.35.224	60	30	2.4.2.3.447	100	50	3.2.2.12.542	100	5	4.2.4.3.1170
4	1.1.1.2.5	100	100	1.2.1.2.78	100	100	2.1.3.1.251	100	100	2.4.2.4.449	60	23.1	3.2.2.12.547	100	30	
5	1.1.3.2.29	0	0	1.2.1.3.79	0	20	2.2.1.7.316	100	100	2.4.2.5.450	100	100	3.3.1.6.577	0	0	
6	1.1.3.2.30	100	71.8	1.2.1.3.80	0	10	2.2.1.7.319	100	100	2.4.2.5.451	100	100	3.3.1.6.578	ХБ	ХБ	
7	1.1.3.4.31	0	0	1.2.1.3.81	100	20	2.2.3.3.369	100	10	2.4.2.6.452	100	100	3.3.3.3.705	0	0	
8	1.1.3.4.32	100	15	1.2.1.3.82	0	5	2.3.2.1.402	100	100	2.4.2.8.454	100	25	3.3.3.19.730	80	40	
9	1.1.3.4.33	0	0	1.2.2.1.84	50	50	2.3.2.1.404	100	5	2.4.2.8.455	0	0	3.3.3.38.756	50	50	
10	1.1.3.4.34	0	0	1.2.2.2.85	100	31.3	2.3.2.1.405	100	5	2.4.3.1.456	71.4	50	3.3.4.35.873	100	100	
11	1.1.3.4.35	75	21.4	1.2.2.3.86	0	0	2.4.1.1.433	60	30	2.4.3.2.457	100	30	3.3.5.7.889	0	0	
12	1.1.3.5.36	30	30	1.2.2.3.87	0	0	2.4.1.2.435	98.2	22.7	2.4.3.2.458	100	30	3.3.5.8.890	100	100	
13	1.1.3.6.38	ХБ	ХБ	1.2.2.3.88	0	0	2.4.1.2.436	66.7	20	2.4.3.3.459	33.3	10	3.3.5.9.892	0	0	
14	1.1.3.7.39	100	25	1.3.1.1.96	83.3	55.6	2.4.1.2.437	67.6	16.9	2.4.3.4.460	20	10	3.3.6.3.904	30	0	
15	1.1.3.7.40	70	20	1.3.1.2.97	100	100	2.4.1.4.439	100	100	2.4.3.4.461	100	97.8	3.3.6.5.912	ХБ	ХБ	
16	1.1.3.7.41	100	100	1.3.5.4.131	50	0	2.4.1.4.440	0	0	2.4.3.4.462	84.2	84.2	3.3.6.7.915	100	10	
17	1.1.3.8.42	100	40	1.3.5.4.132	50	0	2.4.1.6.442	100	50	2.4.3.4.463	90.8	90.8	3.4.1.7.968	90	90	
18	1.1.4.1.43	75	21.4	1.4.1.5.144	93.3	31.1	2.4.1.7.443	0	0	2.4.3.4.464	93.3	28				
19	1.1.4.6.55	100	100	1.4.1.6.145	100	50	2.4.1.8.444	100	41.1	2.4.3.7.468	100	15				
20	1.1.4.7.58	100	5	1.4.1.8.147	0	0										
21	1.1.5.3.63	100	5	1.4.1.8.148	100	30										
22	1.1.5.3.66	100	0	1.4.2.6.160	0	0										
23	1.2.1.1.70	83.3	71.4													
				58.4	30.7					76.2	43.1				67.7	33.5
																83.3
																35.2

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn

Үнэлгээний тайланг яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гаргуулж, тайланг 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 01/4754 тоот албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-

шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [/www.unelgee.gov.mn/](http://www.unelgee.gov.mn)-д баталгаажуулсан.

4.3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 25 тэргүүлэх чиглэл, 26 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийхэд тэргүүлэх чиглэл 93 хувьтай, төсөл арга хэмжээний хэрэгжилт 91 хувьтай, “үр дүн гарсан” гэж үнэллээ.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 26 төсөл арга хэмжээнээс хэрэгжилт 85-100 хувьтай буюу үр дүн гарсан 20 арга хэмжээ, 85-аас доош хувьтай буюу үр дүнгүй 6 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1-д үзүүлэв.

хүснэгт-1

№	Үзүүлэлт	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс				ХБ	Тухайн жилийн дүн %
				85 хувиас дээш	60-84 хувьтай	30-59 хувьтай	0-29 хувьтай		
	Нийт дүн	7	26	20	-	3	3	-	91.0

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn

Үнэлгээний тайланг яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гаргуулж, тайланг 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 02/4954 тоот албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [/www.unelgee.gov.mn/](http://www.unelgee.gov.mn)-д баталгаажуулсан.

4.4. Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 6 зорилтын хүрээнд 22 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилт 85.0 хувьтай, “Бүрэн хангалттай” гэж үнэллээ.

Хэрэгжилтийн гүйцэтгэлийг харуулбал:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв.

хүснэгт-1

№	Ажил үйлчилгээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь				Биелэлт /хувиар/
			85%-иас дээш	70-85% хүртэлх	70 хүртэлх	ХБ	
1	Нийт арга хэмжээ	22	13	3	6	-	85.0

хүснэгт-1.1

№	Үндсэн чиг үүрэг	Зорилт тоо	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь			Дундаж хувь
				85%-иас дээш	70-85% хүртэлх	70 хүртэлх	
1	Зорилго. 1.1. Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч	1	2	1	-	1	85.0

	нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.						
2	Зорилго. 2.1. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн хэрэгжилтийн тайлан	1	3	2	1	-	93.3
3	Зорилго. 3.1. Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтай болон 2025 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн хэрэгжилт	1	4	2	-	2	75.0
4	Зорилго. 4.2. Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.	2	7	5	-	2	89.2
5	Зорилго. 5.2. Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.	3	3	1	1	1	80.0
6	Зорилго. 6.3. Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.	2	3	2	1	-	87.5
Нийт дүн		10	22	13	3	6	85.0

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn.

Үнэлгээний тайланг яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гаргуулж, тайланг 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн 08/3281 тоот албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. /Хавсралт 1./

4.5. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д туссан 9 зорилтын хүрээнд 19 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2025 оны 2 дугаар улирлын байдлаар **88.42** хувьтай, **"үр дүн гарсан"** гэж үнэлэв.

Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 19 арга хэмжээнээс 100 хувьтай 5 арга хэмжээ, 90 хувьтай 10 арга хэмжээ, 70 хувьтай 4 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв

№	Ажил үйлчилгээ	Хэрэгжилтийн хувь
---	----------------	-------------------

		Арга хэмжээний тоо	85%-иас дээш	70-85% хүртэлх	70 хүртэлх	ХБ	Биелэлт /хувиар/
1	Нийт арга хэмжээ	22	13	3	6	-	85.0

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn.

Үнэлгээний тайланг яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гаргуулж, тайланг 2025 оны 07 дүгээр сарын 08-ны өдрийн 01/2669 тоот албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [/www.unelgee.gov.mn/](http://www.unelgee.gov.mn)-д баталгаажуулсан.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө загварын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж баталсан байна.

“Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2025 оны 06-р сарын 25-ны өдөр баталсан 07 дугаар тогтоолын дагуу яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн 6 тэргүүлэх чиглэлээр боловсруулсан баталж ажиллаж байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлага
2. Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалт
3. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалт
4. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалт
5. Санхүү, хөрөнгө оруулалт
6. Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

Дээрх чиглэлийн хүрээнд яамны стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нийт 31 зорилтын 306 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 93.7%-ийн гүйцэтгэлтэй буюу "бүрэн хангалттай" гэж үнэлж байна. Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 270 арга хэмжээ, 70-85% хүртэлх хэрэгжсэн 21 арга хэмжээ, 70 хүртэлх хэрэгжсэн 14 арга хэмжээ, хугацаа болоогүй /ХБ/ 1 арга хэмжээ байна.

Хүснэгт 1. ХББОСЯ-ны ТШЗ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /газар тус бүрээр/

№	Чиглэл	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар			ХБ	%
				85 буюу түүнээс дээш "бүрэн хангалттай"	70-85 хангалттай	70 хүртэл хангалтгүй		

1	Төрийн захиргааны удирдлага	4	82	74	3	4	1	95.0%
	Санхүү, хөрөнгө оруулалт	4	21	20	1			94.1%
2	Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалт	8	55	45	7	3		93.4%
4	Нийтийн аж ахуйн бодлого хэрэгжилтийг зохицуулах	4	30	26	1	3		92.9%
5	Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалт	7	64	51	9	4		91.0%
6	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит	4	54	54				96.0%
Дүн		31	306	270	21	14	1	93.7%

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn

Тайлбар: Барилга, хот байгуулалтын яамны 2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсаргав. /Хавсралт-2/

5.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2025 оны жилийн эцсийн байдлаар байршуулсан яамны үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, УИХ болон Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, тэмдэглэл нийлсэн нийт 216 хууль, тогтоол, шийдвэрийн 429 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналтад авсан 429 заалтын 360 заалт-100%, 50 хувьтай-44, хугацаа болоогүй-19, хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй-1, нийт хэрэгжилтийн дундаж 94,5 хувьтай үнэлэгдэв.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн

Бүгд			Шийдвэрийн төрлөөр									
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо		216	10	33	11	4	69	75	7	2	4	1
Заалтын тоо		429	18	67	21	5	92	139	78	2	5	1
Үнэлгээ	50 хувьтай	44	1	17	1	-	6	4	14	-	1	-
	Хугацаа болоогүй	19	3	4	-	-	2	5	5	-	-	-
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	5	-	1	-	-	1	3	-	-	-	-

Үнэлгээ /хувь/	94,5	96,6	86,2	97,6	100	96,6	98,4	90,4	100	91,6	100
-------------------	------	------	------	------	-----	------	------	------	-----	------	-----

Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn.

Үнэлгээний тайланг яамны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гаргуулж, тайланг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02/71 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [/www.unelgee.gov.mn/](http://www.unelgee.gov.mn)-д баталгаажуулсан.

ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

6.1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот	Хүрсэн	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт)	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-	5	Сертификат олгох сургалт: 1. Удирдлагын академийн ахлах түшмэлийн сургалтад /Чинбат, Сүхбат, Мөнхбаяр/ 2. Жендерийн сургагч багш сургах 2 өдрийн Ж-1 сертификаттай сургалтад 1 албан хаагч, /эмэгтэй/ 3. Хүний эрхийн магадлалын сургагч багш бэлтгэх 2 өдрийн сургалтад 3 албан хаагч, /3 эмэгтэй/ 4. Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтад 10 албан хаагч, 5. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт /Содономпэл/ 6. Хөрөнгийн үнэлгээний боловсрол олгох 30 багц сургалт хувийн зардлаар /2 албан хаагч/ 7. Газрын кадастрын зөвлөх инженерийн зэрэг горилох 15 багц сургалт /1 албан хаагч/ 8. Хот байгуулалтын мэргэшсэн архитекторын зэрэг сунгах /1 албан хаагч/ 9. Удирдлагын академи-Төрийн албаны “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сургалт /1 албан хаагч/ 10. Барилгын салбарт "Барилгын мэдээлэлтэй загварчлал" (BIM) технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаа сэдэвт сургалт
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	-	
			Мэргэшүүлэх сургалт	-	-	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	-	
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
		1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	-	-	

2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт)	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	21	2.Гадаад улс орон, хилийн чанадад хамрагдсан сургалтыг тайлагнана. (холбогдох материалыг хавсаргах)
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	46	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	24	
			Эрэгтэй албан хаагч	-	22	
			Удирдах албан тушаалтан	-	18	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	28	
2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал:	10-аас дээш	-			
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Төрийн хэмнэлтийн тухай хуулиар зардал тавигдаагүй.		
4	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	4.1	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)	Чөлөөлөгдсөн албан хаагч 34		
		4.2	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо	-	20	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	8	
			Эрэгтэй албан хаагч	-	12	
			Удирдах албан тушаалтан	-	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	18	
		4.3	Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	-	16	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	10	
			Эрэгтэй албан хаагч	-	6	
			Удирдах албан тушаалтан	-	3	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	13	
		Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ				

5.	Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг		-	Тайлант оны гүйцэтгэлээр
	5.1.Улирлын урамшуулал олгосон байдал	Нийт албан хаагчийн тоо	-	90
		Урамшуулал олгосон албан хаагчийн тоо	-	96
		Үүнээс удирдах гүйцэтгэх	-	18
			-	77
		Нийт олгосон урамшууллын хэмжээ	-	322,289,834
		Үүнээс I улирал II улирал III улирал IV улирал	-	-
			-	164,096,610
			-	-
			-	158,193,224
		Цалингийн нийт санд эзлэх хувь	-	8%
	5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	албан хаагчийн тоо	-	55
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	47,420,000
	5.2.1.албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2)	албан хаагчийн тоо	-	53
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	34,730,000
	5.2.2.албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.2)	албан хаагчийн тоо	-	1
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	5,781,888
	5.2.3.төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 5.1, 5.2)	албан хаагчийн тоо	-	0
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	0
	5.2.4.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 7.1)	албан хаагчийн тоо	-	1
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	6,903,000
	5.2.5.гадаад улс болон орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 4.1)	албан хаагчийн тоо	-	0
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	0
	5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр ("Төрийн	албан хаагчийн тоо	--	0

албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 6.1)	нөхөх төлбөрийн хэмжээ	-	0
5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	албан хаагчийн тоо	-	136
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	602,647,078
5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4)	албан хаагчийн тоо	-	126
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	546,176,078
5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3)	албан хаагчийн тоо	-	1
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	500,000
5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.5)	албан хаагчийн тоо	-	9
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	55,971,000
5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.6)	албан хаагчийн тоо	-	0
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	0
5.4.Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:	албан хаагчийн тоо	-	1
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	46,282,248
5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож	албан хаагчийн тоо	-	0

чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	нөхөх төлбөрийн хэмжээ	-	0
5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	албан хаагчийн тоо	-	0
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	0
5.5.төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:	албан хаагчийн тоо	-	2
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	6,733,500
5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон	албан хаагчийн тоо	-	2
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	6,733,500
5.5.2.орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг	албан хаагчийн тоо	-	Байхгүй
	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	
5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	Ажлын байрны нөхцөлийг хэрхэн сайжруулсан тухай мэдээллийг товч тайлагнах
5.5.4.албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш	албан хаагчийн тоо	-	Хийгдээгүй, албан хаагчдаас саналыг авсан.

Үнэлгээний тайланг “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3-р хавсралтад заасан хүснэгтийн дагуу гаргаж, 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02/429 тоот албан бичиг болон monitoring@ags.gov.mn цахим хаягаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

ДОЛОО.ХӨНДЛӨНГИЙН БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

7.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

7.1.1. Ил тод байдал

Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-аар үнэлсэн.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангах нийт 45 шалгуур үзүүлэлтийн 42 хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай бүрэн хэрэгжсэн байна. Шалгуур үзүүлэлтийн 5.7, 5.12, 5.13 дахь 3 үзүүлэлт тус яамны хэрэгжүүлэх асуудалд хамаарахгүй болно.

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт /хувиар/
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	100
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	100
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	100

4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	100
Нэгдсэн үнэлгээ		42	100

Үнэлгээний тайланг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02/407 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх орон тооны бус зөвлөлд хүргүүлсэн.

7.1.2. Шилэн дансны үнэлгээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9.8-д “Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ. Уг үнэлгээ нь захиргааны байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэг үзүүлэлт болно” гэж заасны дагуу Сангийн яамнаас нэгдсэн үнэлгээ хийгдэх ч төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын шилэн дансны хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас үнэлсэн үнэлгээг оруулж тооцсон болно.

Хот байгуулалт, байрилга, орон сууцжуулалтын сайдын багцын харьяа байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, тайлан, мэдээг хуулийн хугацаанд үнэн, зөв, иж бүрэн байршуулж байгаад болон хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ”-ний нэгтгэлийн дундаж 97.35 хувийн үзүүлэлттэй байна.

Төсвийн ерөнхий захирагч, түүний харьяа байгууллагуудын шилэн дансны нэгдсэн мэдээлэлд өгсөн үнэлгээ/2025 жилийн эцсийн байдлаар/

2026.02.09

дд	Байгууллагын нэр	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо		Мэдээлээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжилт хувь /%
			Хугацаандаа	Хугацаа хоцроосон			
1	Сайд /төсвийн ерөнхий захирагч/	145	141	4	0	0	97.24
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	171	155	13	1	2	91.81
3	Барилгын хөгжлийн төв ТӨҮГ	158	156	0	0	2	100.00
4	Төрийн орон сууцны корпораци	158	152	4	0	2	97.47
5	20 Минутын хот хөгжлийн төв	171	168	1	0	2	98.25
6	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо	171	165	3	0	3	98.25
7	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл	159	151	2	0	5	98.00
8	Ногоон нуур 1008 айлын Орон Сууцны Төсөл	159	150	4	0	5	94.34
9	Солонго-2	159	146	9	0	4	94.34
10	Солонго-1	159	147	8	0	4	94.97
11	Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл	159	155	0	0	4	100.00
12	Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл	159	153	1	0	5	99.37
Нийт		1928	1839	49	1	38	97.35


/Жич: Хугацаа болоогүй тайланг хугацаанд илгээсэнд тооцон үнэлэв/

7.2.Шударга байдлын түвшний үнэлгээ

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу төрийн байгууллагуудын 2024 оны шударга байдлын үнэлгээг хийсэн байна.

Шударга байдлын үнэлгээ нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээ юм.

График 8. Яамдын ШБҮ, 2023 он болон 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр



Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт /Барилга, хот байгуулалт/-ын яам 2024 онд 80.9 оноогоор 16 яамнаас 4-р байрт орсон нь улсын дунджаас 8.3 оноогоор өндөр үзүүлэлттэй байна.

НАЙМ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

8.1. Нэгдсэн дүгнэлт

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь 2025 оны бодлогын баримт бичгүүдийн 5 баримт бичиг, байгууллагын чиг үүргийн 2 баримт бичиг, байгууллагын чадамжийн үнэлгээ 1 бичиг баримт, хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ 2 баримт бичиг, нийт 10 баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, журамд заагдсан хугацаанд нь Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn баталгаажуулан, албан тоотоор холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Дээрх 10 баримт бичгийн жилийн эцсийн тайлангийн үнэлгээг тайлагналаа.

“Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4-р хавсралтад заасан хүснэгтийн дагуу байгууллагын дундаж оноог гаргах боломжгүй байна.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй /5/ төслүүдийн хэрэгжилт, аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан /22/ гэрээний биелэлтүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Тайланг хавсаргав. /Хавсралт 3, 4/

3. Монгол Улсын барилгын салбарын статистик, тоон мэдээлэл 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах түвшинд хэрэгжсэн байна. Үүнд:

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2024 онд 9.2 их наяд төгрөг болж, 8.1 (88.8%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 1.0 (11.2%) их наяд төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна. Барилга угсралт, их засварын ажил 2024 онд өмнөх оноос 1.2 (14.8%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 733.3 (9.9%) тэрбум төгрөг, гадаадын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 447.2 (77.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ, 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 80.0 их наяд төгрөгт хүрсний 2.6 (3.3%) их наяд төгрөгийг Барилгын салбар бүрдүүлж байна. Салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 оны мөн үеэс 1.2 (90.5%) их наяд төгрөгөөр, 2022 оны мөн үеэс 821.8 (46.0%), өмнөх оны мөн үеэс 335.8 (14.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2 605.6 тэрбум төгрөг, зэрэгцүүлэх үнээр 1 016.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 95.9 (10.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ажиллах хүчний судалгааны 2024 оны 4 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд Барилгын салбарт 96.1 мянган ажиллагчид ажиллаж байна. Үүнээс: Улаанбаатар хотод 73.6 (76.5%), баруун бүс 7.0 (7.3%), хангайн бүс 8.5 (8.8%), төвийн бүс 5.2 (5.4%), зүүн бүс 1.7 (1.8%) мянган ажиллагчид тус тус ажиллаж байна.

Барилгын салбарын нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 2237.1 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 360.9 (19.2%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 4.7 (0.2%) мянган төгрөгөөр буурчээ.

4. Яамны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын “Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 02/747 тоот албан бичгийн хүрээнд яамны Төрийн нарийн бичгийн даргын “Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай” 2025 оны 02/3983 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

5. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь 2025 оны жилийн эцсийн байдлаар дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Төрийн захиргааны удирдлага

1. Бодлогын яамны зүгээс Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж байна.

2. “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох дүрэм”, “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн дүрэм”, “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилох, сунгах, шалгалтын журам”-уудыг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/133 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

3. ШУТИС-ын Барилга, архитектурын сургуультай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж эрэлттэй ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр орон нутгаас сургах нэмэлт гэрээнд 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр яамны Төрийн нарийн бичгийн дарга, ШУТИС-ийн БАС-ийн захирал нар гарын үсэг зурсан. Боловсролын зээлийн сан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам хоорондын санамж бичгийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр, сургалтын төлбөрийн нөхцөлт тэтгэлгийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2025/25 дугаар гэрээг тус тус үзэглэсэн. Тус ажлын хүрээнд Сайдын нэрэмжит тэтгэлгийг 11 дүгээр сарын 05-ны өдөр шилжүүлж 15 аймгийн суралцагч ШУТИС-ийн БАС-д суралцах эрхээ авч суралцаж байна.

4. Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн 2024 оны тайлан, мэдээг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/111 тоот албан бичгээр Жендэрийн Үндэсний хороонд хүргүүлсэн. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хэг/1561 тоот албан бичгээр ирүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд танилцуулагдах Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн Монгол Улсын Засгийн газрын тайланд тус яам 60.5 хувийн үнэлгээтэйгээр үнэлэгдсэн болно.

5. “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд МСС-ын төлөөллийг Жендэрийн орон тооны бус зөвлөлд оролцуулан ажиллаж байна. Жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин бүрдүүлэхийг уриалж РИЙЛ танилцуулга хийхэд МССантай хамтран ажилласан. 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй барилгын салбар” хэлэлцүүлгийг МСС, Азийн хөгжлийн банк, Монгол дахь GIZ “Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлтэй хамтран зохион байгуулж ТББ, аж ахуйн нэгжийн төлөөлөл 80 гаруй хүн оролцсон.

6. Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамны урилгаар Сөүл хотод 2025 оны 09 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулах “К-Гео Феста” арга хэмжээнд оролцсон. Энэ үеэр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.

Санхүү, хөрөнгө оруулалт

1. Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээнүүдийн урьдчилсан үнэлгээг аймгууд болон чиг үүргийн газруудаас ирүүлсэн саналд үндэслэн боловсруулснаар нийт 734,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 385.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 62 төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/574 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр мөн илгээсэн.

2. Сангийн яамнаас ирүүлсэн 2025 оны 02/7190 дугаартай албан бичгийн дагуу Засгийн газрын 2024 оны 93 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-д зааснаар ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдөр танхимаар, 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд яамны цахим хуудсаар тус хэлэлцүүлэн санал асуулга авч нийт 106 хуудас бүхий хэлэлцүүлгийн тайланг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02/3050 дугаартай албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.

3. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 8 төслийн хүрээнд гадаад зээл, тусламжаас 183,589.74 сая төгрөг, Улсын төсөв /Монголын талын хөрөнгө/-т 25,318.21 сая төгрөгийн саналыг холбогдох төслийн танилцуулгын хамт 2026 оны төсвийн хязгаарт хүргүүлсэн. Гадаадын зээл тусламжаар хэрэгжих нийт 9 төслийн 2026 төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 01/1057 дугаартай албан бичгийн 3 дугаар хавсралтаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

1. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувьд Сайдын багцын нийт 57 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа 100 хувь зохион байгуулагдсан ба 40 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан буюу гэрээ байгуулсан төслөөр авч үзвэл 70 хувьтай хэрэгжсэн. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд зохион байгуулсан 38 ажлаас 38 ажлын тендер зарласан буюу хэрэгжилт 100 хувь. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжин хэрэгжихээр батлагдсан, 2025 онд тус яаманд гэрээтэй нийт 40 төсөл,

арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар 28 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаад байна. Үлдсэн 12 төслөөс 60 хувьтай-4, 65 хувьтай-1, 70 хувьтай-2, 85 хувьтай-5 төсөл, арга хэмжээ байна.

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалт

1. 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар орон нутагт 2,464 зээлдэгчид нийт 305.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авснаас 843 зээлдэгчид нийт 98.3 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл олгосон байна. Мөн 274 зээлдэгч зээлийн батлан даалтын сангаар урьдчилгаа төлбөрийн 5.85 тэрбум төгрөгийн баталгаа гаргуулсан байна.

2. “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2025.01.08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан.

3. “Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 09 дүгээр тогтоолоор батлуулсан.

4. ХБОСБЗГ-аас 2025 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан, Дорнод, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймгийн 26 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 11 сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 5 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаврыг хянаж, батлуулсан.

5. “БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн “Ногоон нуур” 1008 айлын орон сууцны цогцолборын барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангагдсан.

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалт

1. Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц 99.9% хувьтай хэрэгжиж, туршилт тохируулгын ажил хүлээгдэж байна.

2. Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн хүрээнд 17 байршлын 13,3 км хоолойн шинэчлэлийн угсралтын ажил бүрэн дууссан бөгөөд барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс ажиллах бэлтгэл ажлыг хангаж ХББОС-ын сайдын 2025.11.11-ний өдрийн 01/4162 дугаар албан бичгээр Дархан-Уул аймгийн Засаг даргад Улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүргүүлсэн.

3. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга угсралт, цахилгаан хангамж, дэд станц, ус, дулааны шугам, УДДТ, холбооны шугам зэрэг дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний ажил бүрэн дууссан. Дэд бүтцийн ажлуудыг улсын комисс хүлээн авсан. Төслийн барилга угсралтын ажил 98%-тай, 2025.07.24-ний өдөр хаягдал усыг хүлээн авч туршилт тохируулгын ажлыг эхлүүлэн өдөрт 50000 м.куб усыг MNS 4349-2015 стандартад нийцүүлэн цэвэрлэж байна. Техникийн комисс ажилласан.

4. “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төслийн хүрээнд Баян-Өлгий, Завхан, Увс, Говьсүмбэр, нийт 4 аймгийн цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон.

5. Төслийн хаягдал ус хүлээн авах худгийн барилга-100%, шахуургын станц №1 99.9%, тогтворжуулах сан 99.6%, хөдөлгөөнт био реакторын байгууламж 99.2%, ламелла тунгаагуурын байгууламж 99.3%, ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилга-99.5%, халдваргүйжүүлэх сан-99.5%, шахуургын станц №2-99.5%, ус зайлуулах сангийн барилга-99.9%, хлор бэлтгэлийн барилга 98.3-тай. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр 2025.11.18-ны өдөр цэвэрлэсэн ус хүлээн авч, зүгшрүүлэх, туршилт, тохируулын ажлыг эхлүүлсэн.

Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалт

1. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт боловсруулагдан батлагдлаа.

2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэж баталсан.

3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.02.10-ний өдрийн 36 дугаар тушаалаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн эзэмшигчдэд тавих нөхцөл шаардлагыг батлуулсан. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс барилгын үйл ажиллагаа, зураг төсөл боловсруулах, өргөх байгууламжийн тусгай зөвшөөрлийг төрийн нэгдсэн системд бүрэн шилжүүлснээр үйл ажиллагаа бүрэн цахимжиж, ил тод, шуурхай боллоо.

4. “Амины орон сууцны мэдээллийн төв /ЧД, СБД, БЗД/-ийг байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, “Монголын амины орон сууцны инноваци хөгжлийн төв” НҮТББ -тай гэрээ байгуулж, тус тусын үйл ажиллагааг жигдрүүлсэн. Дээрх амины орон сууцны мэдээллийн төвөөр нийт 5-н аж ахуй нэгж, 30,000 иргэн үйлчлүүлж, мэдээлэл, үйлчилгээ авсан байна. Үүнээс нийт 5 удаагийн сургалтаар өөрийн гэр болон байшингаа дулаалах болон шинээр амины орон сууц барихад чиглэсэн зөвлөгөө мэдээллийн сургалтад 2,500 иргэн хамрагдсан байна.

5. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 108 дугаар тушаалаар “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал” /БД 25-102-24/ барилгын дүрэм, 2024.оны 153 дугаар тушаалаар “Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам”-ыг тус тус баталсан. Ногоон барилгын аудитор бэлтгэх анхны сургалтыг 2025.05.19-27-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 53 ИТА хамрагдаж, шалгалтад тэнцсэн, 17 аудиторт гэрчилгээ олгосон. Хоёр дахь сургалтыг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 11 аудиторт тус яамны ТНБД-ын А/158 дугаар тушаалаар гэрчилгээ олгосон.

6. Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалтын хамт дагаж мөрдөх 12 стандартын Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025.09.10-ны өдрийн С/32 дугаар тушаалаар батлагдсан.

7. Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтын барилгын материалын сорил шинжилгээний түргэвчилсэн лабораторийг үйл ажиллагаанд оруулах тоног төхөөрөмжийг хүлээн авсан.

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын хавсралтаар батлагдсан журмын цагалбараар Салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д тайлганасан.

2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 2025 оны хяналт шалгалтын жилийн гүйцэтгэл, үр дүнг тооцож 97.1 хувьтай хэрэгжүүлсэн.

3. ХҮҮХ-ны 2024 оны 02 дугаар тогтоол, ХББОСС-ын 2024 оны 119 дүгээр тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02-00/04 дүгээр удирдамжийн дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 18 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 18 барилга байгууламжийг хяналт шалгалтад 100 хувьтай хамруулж, 138 зөрчил дутагдал илэрснээс 126 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 133 заалт бүхий 13 албан шаардлага, 5 дүгнэлт, 15 заалт бүхий 1 зөвлөмжийг хүргүүлэн 3 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 88 хувьтай.

4. Улсын хэмжээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 312 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 303 барилга байгууламжийг хяналт шалгалтад 97.1 хувьтай хамруулж, 1509 зөрчил дутагдал илэрснээс 1223 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 697 заалт бүхий 177 албан шаардлага, 18 заалт бүхий 5 дүгнэлт, 2 акт, 1440 заалт бүхий 105 зөвлөмжийг хүргүүлэн 12 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч 42.0 сая төгрөгийн торгууль шийтгэл ногдуулж, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 87 хувьтай, 301 барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулсан.

5. Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02-00/06 дугаар удирдамжийн дагуу улсын хэмжээнд 1027 объектод хяналт шалгалтыг хийсэн. Улсын хэмжээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжуудын дагуу 155 иргэн 870 аж ахуй нэгжийг байгууллагын 1025 барилга байгууламжийг хяналт шалгалтад хамруулж 4595 зөрчил илрүүлснээс 2552 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 874 заалт бүхий 170 албан шаардлага, 50 акт, 127 дүгнэлт, 3609 заалт бүхий 259 зөвлөмж, 731.550.0 сая

төгрөгийн торгууль ногдуулж, 60 барилга байгууламж, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зогсоож, эрх бүхий албан тушаалтны албан даалгаврыг өгч, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 86 хувьтай хэрэгжиж, 668 барилгын чанар аюулгүй байдлын хангуулж ажилласан.

6. Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02-00/07 дугаар удирдамжийн дагуу улсын хэмжээнд Бетон зуурмаг, бетон эдлэлийн 105 үйлдвэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 17 албан шаардлага өгч, 14 ААН-д 79.5 сая төгрөгийн торгууль оногдуулж, барагдуулан, 14 эрх бүхий албан тушаалтын даалгаврыг хүргүүлж, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 87 хувьтай, бүтээгдэхүүний технологийн шаардлагыг хангуулсан.

7. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 83 дугаартай тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025.01.15-ны өдрийн “Цамхагт краны техникийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-00/08 дугаартай удирдамж, 2025.04.11-ний өдрийн “Цамхагт краны техникийн аюулгүй байдлыг хангуулах тухай” 02-00/01, 02-00/02 дугаар албан даалгаврын хүрээнд 138 аж ахуйн нэгжийн 158 цамхагт краны техникийн аюулгүй байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 105 дүгнэлт, 31 албан шаардлага, 1 акт, 2 зөвлөмж хүргүүлж, илэрсэн зөрчилд 101 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, бүрэн барагдуулж, хэрэгжилтийг хангуулан, ашиглалтын шаардлага хангахгүй 20 краныг буулгасан, Аяны хүрээнд 10 удаагийн танхимын сургалтыг зохин байгуулж, 320 ИТА хамрагдсан. Улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 89 хувьтай, 139 цамхагт краны техникийн аюулгүй байдлыг хангуулсан.

8. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 557 иргэн, 4333 аж ахуйн нэгж, байгууллагын 4907 барилга байгууламжид хийж гүйцэтгэн 12621 зөрчлийг илрүүлснээс 10510 зөрчлийг арилгуулж, эрсдэлийн түвшин 5.7 хувиар буурсан бөгөөд улсын байцаагчийн 582 заалт бүхий 3662 албан шаардлага, 25 акт, 915 дүгнэлт, 6268 заалт бүхий 2316 зөвлөмжийг хүргүүлэн 17 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч 612.850.0 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, 25 иргэн, ААНБ-д эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 96.5 хувьтай байна.

9. ХББОСЯ-ны салбарын хяналтаас 2025 онд нийт 36 зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хялбаршуулсан журмаар 27, зөрчлийн хэрэг нээсэн 2, гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан 4, харьяаллын дагуу шилжүүлсэн 3 хэрэг бүртгэгдсэн. 4 иргэн, 30 аж ахуйн нэгжийн 21 барилга, 15 краны үйл ажиллагааг эрх бүхий албан тушаалтны даалгавраар зогсоож, 207.8 сая төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулсан. Улсын хэмжээнд 177 барилга байгууламжийн үйл ажиллагааг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр зогсоож, 1.433.500.000 төгрөгийн торгууль ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн.

8.2. Нэгдсэн санал, зөвлөмж

1. Орон сууцны тухай хуулийн төсөл, Барилгын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын төсөл/, Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж дуусган Улсын Их Хуралд өргөн барьж, чуулганаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг яаралтай зохион байгуулах, 2026 оны төлөвлөгөөнд тусгах;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 2026 онд төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг зөв төлөвлөж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын хүрээнд хүрэх буюу зорилтот түвшин, суурь түвшнийг чанар, тоогоор илэрхийлж төлөвлөгөөндөө тусгах;;

3. Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд туссан хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг батлагдсан тухайн жилийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх түвшнээр 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөж биелэлтийг ханган ажиллах;


4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хүрээнд 5.1.7. дахь арга хэмжээ болох “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх, Ажлын хэсэг байгуулах, хэлэлцүүлэх, санал авах, батлуулах ажлыг 2026 оны эхний улиралд багтаан хэрэгжүүлэх;

5. Шилэн дансны тухай хуулийн хугацаанд багтаан шаардлага хангасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт даалгах;

6. Бодлогын баримт бичигт туссан арга хэмжээнүүдэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43, дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 7.1.Хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжиж байгаа бодлогын баримт бичиг "үр дүн гараагүй" болон "үр дүн хангалтгүй" үнэлэгдсэн тохиолдолд бодлого хэрэгжүүлэгч нь хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн дараах арга хэмжээнээс аль тохирохыг авч хэрэгжүүлнэ гэж заасны дагуу 2, 3, 4 дүгээр зөвлөмжөөр өгсөн арга хэмжээнүүдэд тодотгол хийж, саналыг журмын 7.2.-д заасны дагуу хүргүүлж ажиллахыг холбогдох газруудтай хамтран хэрэгжүүлэхийг Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газар /О.Одбаяр/-т даалгасугай.


7. Газар, нэгжүүд орон тоо дутуу, ачаалалтай ажиллаж байгаад дүгнэлт хийж, дутуу орон тоог нөхөж албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөлийг хангах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/-д зөвлөж байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч



М.Баяраа

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга



Б.Найрамдал

ЕС. ХАВСРАЛТУУД

9.1. Хавсралт-1

“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫН БИЕЛЭЛТЭД 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025.07.28

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-т туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг үндэслэн “Шинэ сэргэлтийн бодлого”-т тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлж байна.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 6 зорилтын хүрээнд 22 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилт 85.0 хувьтай, “Бүрэн хангалттай” гэж үнэллээ.

Хэрэгжилтийн гүйцэтгэлийг харуулбал:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв.

хүснэгт-1

№	Ажил үйлчилгээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь				Биелэлт /хувиар/
			85%-иас дээш	70-85% хүртэлх	70 хүртэлх	ХБ	
1	Нийт арга хэмжээ	22	13	3	6	-	85.0

хүснэгт-1.1

№	Үндсэн чиг үүрэг	Зорилт тоо	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь			Дундаж хувь
				85%-иас дээш	70-85% хүртэлх	70 хүртэлх	
1	Зорилго. 1.1. Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.	1	2	1	-	1	85.0
2	Зорилго. 2.1. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн хэрэгжилтийн тайлан	1	3	2	1	-	93.3
3	Зорилго. 3.1. Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтай болон 2025 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн хэрэгжилт	1	4	2	-	2	75.0

4	Зорилго. 4.2. Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.	2	7	5	-	2	89.2
5	Зорилго. 5.2. Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.	3	3	1	1	1	80.0
6	Зорилго. 6.3. Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.	2	3	2	1	-	87.5
Нийт дүн		10	22	13	3	6	85.0

Хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ түс бүрээр харуулбал:

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжилтийн явц	Хувь
1. "ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ			
Зорилт Нэг. Боомтын сэргэлт:			
1.1. Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.			
1.	1.1.1. Боомтуудыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинээр нэмж боловсруулах замаар боомтуудын хөгжлийг хөрш орнуудын боомттой ижил түвшинд хүргэж, дэд бүтэц, тээвэр зохион байгуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх,	1.Тус яамны 2024 оны 01/1542 дугаар албан бичгээр Байтаг, Даян, Булганы хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах саналыг Боомтын сэргэлтийн үндэсний хороонд хүргүүлсэн. Мөн БНХАУ, МУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний Э/З-ийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” хэлэлцээрийн хоёр талын чөлөөт бүсийн ажлын явцын талаар харилцан мэдээлэл солилцох, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг уялдуулан шинэчлэн боловсруулах асуудлыг шийдвэрлэхээр Монголын талаас ЭЗХЯ-ны ХОБГ-ын дарга Б.Анараар ахлуулсан баг, БНХАУ-ын талаас ӨМӨЗО-ны Худалдааны танхимын орлогч дарга Гоу Жөүминаар ахлуулсан ажлын хэсэг хамтран 2024.04.08-10-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүдийн чөлөөт бүс, БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүсэд тусгай хөтөлбөрийн дагуу ажиллаж, харилцан зөвлөлдөж “Замын-Үүд, Эрээний Э/З-ийн хамтын ажиллагааны бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад шуурхай хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. ЭЗХЯ, АХБ хамтран хэрэгжүүлж байгаа “АХБ 3936-МОН: Э/З-ийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-өөр Замын-Үүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахаар 98 мянган ам.доллар тусгагдсан бөгөөд ЭЗХЯ-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төсөлд өгөх саналыг ерөнхий төлөвлөгөө боловсруулах үнийн тооцооллын хамт	70

		боловсруулж, тус яамны 2024 оны 03/1250 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. 2. Алтанбулаг боомтыг хөгжүүлэх хүрээд тус боомтын асуудлыг Алтанбулагийн чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан үзэж Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг "Идеал групп" ХХК боловсруулж байгаа бөгөөд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гэрээт ажлын хугацааг 2024.10.31-ийг хүртэлх хугацаагаар сунгасан. Ажлын явц 70 хувьтай байна.	
2.	1.1.5. Боомтуудын үндсэн байгууламж /эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интернэтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал/-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аялах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх,	1. Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсэд зориулсан дулааны станц, ус хангамжийн эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. 2. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх төсөл-МОН3936 төслийн хүрээнд "Замын-Үүд" чөлөөт бүсийн 1-р үе шатны дэд бүтэц, гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барилга байгууламжийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөхөөр шалгарсан "Сонголт Дизайн" ХХК-тай гэрээ байгуулан, инженерийн зураг төсөл боловсруулах ажлын хуваарь, бүтээгдэхүүн хүргэлтийн хуваарь, гүйцэтгэх ажлууд болон ЗҮЧБ-д өмнө баригдсан инженерийн шугам сүлжээний өнөөгийн нөхцөл байдал, байр зүйн зургийн судалгааг хүлээн авсан. "Сонголт дизайн" ХХК-ийн санхүүжилтийн хүсэлтийг АХБ-нд уламжилсан. Төслийн явцыг эрчимжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар, АХБ хооронд 2022.08.19-нд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулаад байна. Биелэлт 100%. 3. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Эдийн засгийн чөлөөт бүсийн ариутгах татуургын шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан "Нягт холбоос" ХХК-тай гэрээ байгуулж, ажиллах талаар Барилгын хөгжлийн төвд 2022.03.30-ны 3/1346 дугаар албан бичгийг хүргүүлж, гэрээ байгуулсан. Захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төв хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100%-тай. 2024 оны улсын төсөвт Замын-Үүдийн лабораторийн тоног төхөөрөмжийн санхүүжилтэд нийт 16,753.8 сая.төгрөг, Алтанбулаг хилийн боомтын лабораторийн тоног төхөөрөмжийн санхүүжилтэд нийт 6,470.0 сая төгрөг тус тусгагдсан. Үүний дагуу 2025 онд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг хүлээн авахаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Б/98 дугаараар ажлын хэсэг байгуулагдан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнээс: Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтод байрлалтай Барилгын материалын сорилт, шинжилгээний түргэвчилсэн лабораторийн 2025 оны эхний ээлжид нийлүүлэгдэх /керамик эдлэхүүн, цемент, цонх, хаалга, хуванцар болон цахаилгаан утас/ лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээн авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-07-ын өдрүүдэд ажилласан. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод байрлалтай Хими, будгийн лабораторийн	100

		тоног төхөөрөмжийг 2025 суурилуулан хүлээн авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
Зорилт. Дөрөв. Хот, хөдөөгийн сэргэлт: 4.2. Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.			
3.	4.2.1. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, суурь дэд бүтцийг барьж байгуулах,	АХБ-ны санхүүжилтээр "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийг 10 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад дэд төвүүдийг шинээр барихаар нийт 79 ажил төлөвлөсөн. Үүнээс 2016-2021 онд 34 төсөл, 2022 онд 13 төсөл, 2023 онд 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд 2024-2025 онд шинээр 4 ажлын гэрээ байгуулж, нийт 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц 2025 оны 6 сарын 30-ны байдлаар 69.8% байна. - Төслийн 2 дугаар үе шатны хүрээнд: Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд зураг төслийн ажлын явц 93.2%-тай байна. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 99.7%. Худалдан авах ажиллагааны явц 76.6%. Дэд төвүүдийн нийт барилга угсралтын ажлын явц 44.7% байна. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 64.2%-тай байна. - Төслийн 3 дугаар үе шатны хүрээнд: Шархад, Толгойт дэд төвүүдийн газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 96.1%. Худалдан авах ажиллагааны явц 46.9%. Зураг төсөл боловсруулалтын ажлын явц 78.6% -тай байна. Барилга угсралтын ажлын явц 19.2%. Энэ үе шатны хэрэгжилтийн явц 43.9%-тай байна.	70
4.	4.2.2. Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	1. "Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль"-ийг УИХ-аар 2025.01.24-ний өдөр батлуулсан. Хүннү хотын төлөвлөлтийн үзэл баримтлалын баримт бичиг боловсруулах олон улсын уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ХББОС-ын сайд, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2025 оны 66/ А/394 дүгээр тушаал, захирамжаар байгуулсан. ОУ-ын уралдаант шалгаруулалтын Ажлын даалгаврыг НЗД бөгөөд УБ хотын захирагч Х.Нямбаатараар батлуулсан. 2. "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. Засгийн газрын 2025 оны 83 дугаар тогтоолоор "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц /4 хэлтэс/, орон тооны хязгаарыг /30хүн/ тус тус баталсан. ЖАЙКА-ын "Төв аймгийн Хөшгийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс, шинэ хотын хөрөнгө оруулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх төсөл"-ийн хүрээнд Япон улсад 2025.04.16-04.23-ны өдрүүдэд боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад нийт 16 хүн оролцов.	100

		Нийслэлийн 2025 оны төсөвт Хүннү хотын 127.4км авто замын зураг төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн. -“Шинэ Зуунмод” хотын төв, засаг захиргааны бүсийн ТЭЗҮ, ХЕТ боловсруулах ажлын даалгаврын төслийг НУБХАЗТБҮХ-той хамтран батлуулсан. 3.Агросити дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар нийслэлийн төсөвт 2332,0 төг тусгагдсан. Тус дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 2025 оны 2025/01 дугаартай ажлын даалгаврыг батлуулах ажлын гүйцэтгэгчээр "Гобитрэвэл" ХХК шалгаран ажиллаж байна. 4. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 03 дугаар тушаалаар иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, ногоон дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй дулааны тогтвортой эх үүсвэр болох газрын гүний дулааны нөөцийг Улаанбаатар хот орчимд тодорхойлох урьдчилсан суурь судалгааг хийх, дулаан хангамжийн системд ашиглах арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулж бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийн НБД-аар ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: - Ажлын хэсгийн 4 удаагийн хурлыг зохион байгуулж, тэмдэглэл хөтөлж, шийдвэрийг албажуулах, гаргасан шийдвэрийн дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулах. - Ажлын хэсгийн 01 дүгээр хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн тус хүрээлэнтэй 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 2025/25 дугаартай 3 талт /ХББОСЯ, Нийслэлийн ЗДТГ/ гэрээг байгуулах ажлыг зохион байгуулсан. - Захиалагчийн техник хяналтын 7 удаагийн уулзалтыг ШУА-ийн ООГФХ-дээр зохион байгуулж, холбогдож арга хэмжээг авах ажлуудыг зохион байгуулсан, - Эхний болон дунд шатны ажлын тайланг актаар хүлээн авах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан, - АХБ-ны зөвлөхүүдийн 2 удаагийн уулзалтад оролцсон.	
5.	4.2.6. Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын төвлөрлийг бий болгохын тулд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор батлагдан 2022 оноос эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд 5 төсөл арга хэмжээний хөрөнгө батлагдаж хэрэгжиж байна. Үүнд: 1. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Архангай, Их тамир/-71%, 2. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Говь-Алтай, Алтай/-51%, 3. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Дундговь, Луус/-70%, 4. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Өвөрхангай, Бат-Өлзий/-85%, 5. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Өвөрхангай, Уянга/- 60% тус тус ажил үргэлжилж байна. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Төв, Дэлгэрхаан/ угсралтын ажил 80%-тай 2025 онд хөрөнгө батлагдаагүй.	70

		Дараах төсөл, арга хэмжээнүүд 100% ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Үүнд: 1. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Дорнод аймгийн Дашбалбар сум/ 2. Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Өвөрхангай, Хужирт сум/	
6.	4.2.7. Орон нутагт шилжсэн болон суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгчдийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх	Тус яам нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татааст шаардлагатай 63.5 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2025 оны төсвийн хуульд манай сайдын багцад тусгагдан баталснаар Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 68 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д зөвлөж,” гэсний дараа “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /Ж.Батсуурь/,” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. “Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г ХББОС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай байгуулан 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталсан. Тайлант оны 06 дугаар сарын байдлаар орон нутагт 208.43 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 1,801 зээлдэгч зээл авсан байна. Үүнээс 362 зээлдэгч 42.1 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл авч, зээлийн батлан даалтын сангаар 111 зээлдэгч, 2.33 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байна.	100
7.	4.3.1. Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах хүрээнд Хангайн бүсийн тулгуур төв болон томоохон уул уурхайг түшиглэсэн говийн бүсийн хот, сууринг хөгжүүлэх	1. Эдийн засаг, хөгжлийн яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар болон “Нью-Урбанизм” ХХК-ний хооронд 2024.12.06-ны өдөр байгуулсан УТ2406600094021/ЭЗХЯ202451 дугаартай гэрээний дагуу “Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” /Орхон аймаг, Баян-Өндөр сум/-г боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж дэмжлэг, зохицуулалтаар хангах болон санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/43 тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлыг 2025.03.25-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэгч “Нью Урбанизм” ХХК-ний боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийн төслийг хэлэлцэж, холбогдох үүрэг даалгаврыг өгч ажиллаж байна. “Нью Урбанизм” ХХК-иас эхлэлийн тайланг Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, ажлын гүйцэтгэлийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн. 2. Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2022 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Ханбогд сумын төвийн холимог бүс, хөнгөн үйлдвэрийн бүс, хуваарьт эдлэнд хувийн	100

		сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын төслүүдтэй танилцаад, холбогдох саналыг боловсруулан 2025 оны 02 дугаар сард хүргүүлсэн.	
8.	4.3.2. Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хэрэглэгчдэд иж бүрэн, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх	Засгийн газрын 2021 оны 161-р тогтоолоор баталсан “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төслийн хүрээнд 8 төсөл, арга хэмжээг 2022 оноос хэрэгжүүлж эхэлснээс одоогийн байдлаар 2 төсөл, арга хэмжээ ашиглалтад хүлээн авч, 6 төсөл, арга хэмжээний угсралтын ажил үргэлжилж байна. Мөн Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд XVIII.1.1 дугаар 213.19 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2025 онд санхүүжих дүн 52.9 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/” төсөл, арга хэмжээ батлагдаж, 29 төсөл, арга хэмжээнд задарч хэрэгжиж эхлээд байна. Түүнчлэн энэ үйл ажиллагааны хүрээнд Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрийн дагуу төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд түргэн шуурхай, чанартай, найдвартай хүргэхийн зорилгоор салбарын боловсон хүчнийг чадавхжуулахаар салбарын хэмжээнд нийт 32 удаагийн сургалтад 1431 ажилтан хамруулсан. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын 2024 оны санхүү, эдийн засгийн нэгдсэн тайланд тусгаснаар нийт 125 тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБайгууллага 739,228 хэрэглэгчид нийт аж ахуйн үйлчилгээг хүргэж ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 23,150-аар хэрэглэгчийн тоо өссөн үзүүлэлтэй гарсан. Тайланд хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч 19 байгууллага цэвэр, бохир усны үйлчилгээний тарифт зохицуулалт хийлгэсэн байна.	90
9.	4.3.3. Инженерийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангах	Инженерийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангах зорилгоор Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд шинээр 213.19 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2025 онд санхүүжих дүн 52.9 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/” төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд үүний хүрээнд 29 сум, суурин газрын инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний хангалтыг нэмэгдүүлэх боломжийг бий болгож чадсан. 2024 онд хэрэгжиж байсан дараах төсөл, арга хэмжээнүүд хэвийн үргэлжилж байна. Тухайлбал, 1. Дархан хотод цэвэр усны 12.3 км шугамын угсралтын ажил гүйцэтгэсэн. 10000ш цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулаад байна. 2. БНХАУ, АХБ, БНПУ-ын зээлээр УБ хот болон аймгийн төвүүд, сумдад бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслүүд амжилттай хэрэгжиж байна.	90
Зорилт Тав. Ногоон хөгжлийн сэргэлт: 5.2. Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.			

10.	5.2.2. Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах,	Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 31%-тай үргэлжилж байна. Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпораци хооронд Мянганы сорилтын хоёр дахь (Компакт гэрээ)-ний хүрээнд “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг АНУ-ын Засгийн газрын 350.0 сая ам. долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.7 сая ам. долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд: 1. Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл; 2. Хаягдал ус дахин боловсруулах төсөл; 3. Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийг тус тус амжилттай хэрэгжүүлж байна. Үүнээс 2. Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усыг дахин боловсруулж, Дулааны цахилгаан станц III, IV-т үйлдвэрийн зориулалтаар дахин ашиглах Хаягдал ус дахин боловсруулж нийлүүлэх үйлдвэрийг барьж, дахин боловсруулсан ус дамжуулах шугам хоолой, нөөцлөх сав, өргөлтийн насос станцын холбогдох дэд бүтцийн хамт барьж байгуулж байна. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90%-ийн хэрэгжилттэй байна. Уг үйлдвэрээс гарах ус дамжуулах шугам хоолойн угсралт, ДЦС-уудын тохируулга, өөрчлөлтийн ажлын гүйцэтгэл 82%-тай байна.	70
5.3. Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.			
11.	5.3.1. Нийслэл хот болон аймгийн төвүүдэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжиж, хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах,	1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оноос эхлэн Хог ангилах төвийн барилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 24-р хороо/ төсөл, арга хэмжээ УБ хотын БЗД-ийн нутаг дэвсгэрт байрлах Цагаан даваанд хэрэгжсэн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар Барилга угсралтын ажил бүрэн дуусаж, дотор суурилуулах тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэлтэй 95 хувьтай, барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Улсын комисс 2025.08.20-ны өдөр ажиллах төлөвлөгөөтэй байна. 2. Ядуурлыг бууруулах Япон сангийн 2.0 сая ам долларын буцалтгүй тусламжаар "Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн G9206 төсөл"-ийг Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвд 2020-2022 онд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Говь-Алтай, Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай аймгийн төвд хог хаягдлын төвлөрсөн байгууламжийг шинээр барьсан, дахивар хүлээн авах, хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүүний ажлыг бүрэн гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан, 100%-тай. Улсын их хурлын гишүүн С.Цэнгүүнд барилгын материалын үйлдвэрлэлд дулааны цахилгаан станцуудын үнсийг ашиглахтай холбоотой зохицуулалт, журам, эдийн засгийн	90

		тооцоолол зэрэг холбогдох мэдээллийг 2025.01.24-ний өдөр 01/260 дугаар албан бичгээр хүргүүлэв. • БОУАӨ-ийн сайд ын А/105 дугаар тушаалаар байгуулсан Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд тус яамнаас БМХ-ийн ахлах шинжээч А.Энхтүвшинг ажиллуулахаар 2025.05.13-ны өдөр 03/1747 дугаар албан бичгээр нэр хүргүүлсэн. • “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”-ийн зорилтуудыг шинэчилж байгаатай холбогдуулан Аж үйлдвэрийн салбарын болон Хог хаягдлын салбарын зорилтын хүрээнд “барилгын материалын ногоон үйлдвэрлэл”, “хог хаягдлыг БМУ-лэлд хэрэглэх хэрэгцээ шаардлага”-ын талаар танилцуулга /PPT/ боловсруулан бэлтгэж, NDC боловсруулах Ажлын хэсгийн хуралд 2025.04.03-ны өдөр танилцуулж, ҮТХНЗ-т уг асуудлыг тусгах санал гаргасан. • “Блүүм пластик” ХХК-ийн хуванцар хог хаягдлыг ашиглан барилгын материал үйлдвэрлэх тухай хүсэлтийг дэмжиж, 2025.05.16-ны өдөр 07/1807 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлэв. • “Эрчим хүчний салбарын хаягдлыг барилгын салбарт ашиглах боломж” сэдвээр илтгэл боловсруулж, УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос 2025.06.04-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан төр хувийн хэвшлийн хамтарсан “Хаягдал үнс” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэгт танилцуулсан.	
5.4. Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.			
12.	5.4.3 Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий бага ялгаруулдаг, эрчим хүч, цэвэр усны хэмнэлттэй ногоон төсөл хэрэгжүүлэх, бараа бүтээгдэхүүн худалдан авахад хөнгөлөлттэй зээл, урамшуулал олгох,	“Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, тус ажлын хэсгийн 2025.01.29-ний хуралд оролцож, салбар салбарын эко, органик, био бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тэдгээрт тавигддаг шаардлагын талаар санал солилцов. BestGER үнэлгээний системийн шалгуур үзүүлэлтэд туссан Барилгын материалын шалгуурт нийцсэн үнэлгээг хийх зорилгоор Барилгын материалыг үнэлж “ногоон” сертификат олгох талаар санал боловсруулах Ажлын хэсэг байгуулахаар Сайдын тушаалын төслийг боловсруулаад байна.	80
Зорилт. Зургаа. Төрийн бүтээмжийн сэргэлт: 6.1. Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна. 6.3. Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.			
13.	6.3.1. Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоог 2 дахин цөөрүүлж, цахимаар олгох,	Тусгай зөвшөөрлийн цахим систем /www.mcis.gov.mn/-ээр дамжуулан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 4078 хүсэлтийг хүлээн авч, давхардсан тоогоор барилгын ажил гүйцэтгэх 1343, зураг төсөл боловсруулах 242, өргөх байгууламжийн 28, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх 94 тусгай зөвшөөрөл олгоод байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр өмнө 30-45 хоног зарцуулдаг байсан хугацааг 10-15 хоногт багтаан шийдвэрлэдэг болсон ба шат дамжлага, зардал, цаг хугацааг хэмнэхээс гадна авлига, хүнд суртлыг бууруулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 233	90

	сунгах боломжийг бүрдүүлэх,	дугаар “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор энгийн болон тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох ажлыг даалгасан. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-д заасан “цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой, газрын тосны боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох” энгийн зөвшөөрлийг цахимжуулж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-д холбох ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлж, үйлчилгээг нэвтрүүлсэн. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.02.10–ны өдрийн 36 тушаалаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг шинэчлэн баталсан. Мөн тусгай зөвшөөрлийн шийдвэрлэлт ил тод, нээлттэй болж QR code бүхий нууцлалтай цахим гэрчилгээг тус системээр дамжуулан авах боломжтой болсон. Хүсэлт өгсөн, шийдвэрлэсэн төлөв, шат бүрийг иргэн өөрөө хянах боломжтой. Цахим систем нь 24/7 ажиллах тул хүссэн цагтаа үйлчилгээ авах боломжтой болсон зэрэг асуудал шийдвэрлэгдсэн.	
14.	6.3.2. Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах,	Энэ оны 1 дүгээр сараас 2025.06.02-ны өдрийн байдлаар 22 удаагийн баталгаажуулалтаар БҮАТЗ хүссэн нийт 1613 ААНБ-ын өргөдөл материал хянагдаж, баталгаажуулалт хийв. Үүнээс сунгалтаар 78, шинээр 1108, нэмэлтээр 411, дахин олголтоор 16 ААНБ-д БҮАТЗ олгов. -Сунгалтаар 78 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар 68, Зураг төсөл боловсруулахаар 8, өргөх байгууламжаар 2, Шинээр 1108 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар 940, Зураг төсөл боловсруулахаар 148, өргөх байгууламжаар 20, Нэмэлтээр 411 ААНБ-д БҮАТЗ-ийн ажилбар нэмж олгосноос: Барилга угсралтаар 321, Зураг төсөл боловсруулахаар 84, өргөх байгууламжаар 6 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан байна. Дахин олголтоор 16 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар 14, Зураг төсөл боловсруулахаар 2, өргөх байгууламжаар ААНБ-д БҮАТЗ-ийн гэрчилгээг дахин олгов. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг E-mongolia буюу license.mn сайтаар авах, Төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэх зорилгоор 8 дугаар сараас эхлэн тус систем руу шилжүүлэх ажлын хөгжүүлэлт хийгдэж байна.	80
6.4. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.			
15.	6.4.3. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцогч нь нийслэл, дүүргээс бусад орон	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад тусгагдан 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулах нийт 57 төсөл, арга хэмжээнээс тус яаманд зохион байгуулсан 38, Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулсан 8, Аймаг нийслэлд эрх шилжүүлсэн 11 төсөл, арга хэмжээ тус тус байна. Тендер зарлагдсан 57 төсөл, арга хэмжээнүүд нь Сангийн сайдын 2023 оны А/259 дугаар тушаалаар баталсан ажил гүйцэтгүүлэх тендер	90

	нутагт, эсхүл орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, татвар төлдөг кластер бүхий аж ахуйн нэгж бол тендерийн үнэлгээ хийхэд давуу эрх үзүүлэх	шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу зохион байгуулагдсан ба тус жишиг баримт бичгийн зааварчилгааны 31, өгөгдлийн хүснэгтийн 31.1-д тус тус заасны дагуу давуу эрх олгохоор боломжтой байхаар заасан. Тус яаманд зохион байгуулсан 38 төсөл, арга хэмжээнээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1-ийн дагуу нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотоос бусад харьяалалтай орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зарласан тендер шалгаруулалтад оролцогч сүүлийн хоёроос доошгүй жилийн хугацаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж, ажлын байр бий болгосон бол түүний тендерийн үнийн дотоодын бараанаас бусад хэсгийн үнийн таван хувиар хийсвэрээр бууруулж тооцох заалтаар давуу эрх тооцуулах хүсэлт 2 ажлын тендерт санал ирүүлсэн ба холбогдох журмын дагуу шийдвэрлэсэн.	
2.1. "ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН			
16.	2.1.1. Хөшигийн хөндийд эдийн засгийн бүс байгуулах	""Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2025.01.08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. Засгийн газрын 2025.02.12-ны өдрийн 83 дугаар тогтоолоор "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн ""Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс""-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц /4 хэлтэс/, орон тооны хязгаарыг /30хүн/ тус тус баталсан. Чөлөөт бүсийн захирагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Б.Саранчимэг томилогдон ажиллаж байна. ХББОС-ын сайд Ж.Батсуурь, ХББЗГ-ын дарга Ц.Баярбат нар Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн Захирагчтай 2025.05.14-ний өдөр уулзалт хийж, хамтын ажиллагаа болон бүтээн байгуулалтын ажлын талаар санал солилцож, зөвлөмж өгсөн. Тус яамнаас Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй "Төв аймгийн Хөшгийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс, шинэ хотын хөрөнгө оруулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх төсөл"-ийн хүрээнд Япон улсад 2025.04.16-04.23-ны өдрүүдэд зохион байгуулсан боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад Хөшигийн хөндийн ЭЗЧБ-ийн захирагч болон холбогдох мэргэжилтэнг оролцуулав. Нийслэлийн 2025 оны төсөвт Хүннү хотын 127.4км авто замын зураг төслийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтаар тус ажлыг "ХЗТ-Автозам" ХХК шалгарч НЗХГазартай гэрээ байгуулан боловсруулах ажлыг эхлүүлсэн.	100
17.	2.1.2. Залуус-1 хороолол	Төслийн гадна дулааны шугам сүлжээний барилга угсралтын ажлыг улсын төсвийн санхүүжилтээр Одкон холдинг ХХК үргэлжлүүлэн 85% гүйцэтгэлтэй, 2025 онд ашиглалтад оруулна. Би Эс Би ХХК-ийн гүйцэтгэж байгаа гадна цахилгааны шугам сүлжээний барилга угсралт 2025 онд хүлээлгэж өгөхөөр төлөвлөгөөний дагуу 85%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.	100

		Алтайн үндэс ХХК-ийн гүйцэтгэж байгаа гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний угсралтын ажлын 2 ш насос суурилуулах ажил үргэлжилж байна. гүйцэтгэл 85% Биг монголиа бюлдинг ХХК ИШС-ний хонгилын системийн барилга угсралт 2025 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй 85%-ийн гүйцэтгэлтэй ажил үргэлжилж байна. Орон сууцны “Залуус” хорооллын эхний ээлжийн 936 айлын орон сууцны төслийг гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарт танилцуулах, санал авах ажлын хүрээнд Турк, Хятад улсын барилгын төсөл хэрэгжүүлэгч 3 байгууллагатай ХББОС-ын сайдын хийх уулзалт зохион байгуулсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны барилгын 3 аж ахуйн нэгжийн хамтарсан нэгдэлтэй уулзалт хийж санал солилцсон. Залуус төслийг нийслэлийн замын сүлжээтэй холбохтой холбоотой санал, тодотголыг 2025.03.21-ний 04/1001 албан бичгээр нийслэлийн ХБХСГ, ЗХГ-т тус тус хүргүүлж нийслэлийн замын ажлын даалгаварт оруулсан. Засгийн газрын 2025.05.21-ний өдрийн хуралдаанд “Залуус-1” төслийн хэрэгжилтийн талаар танилцуулж, хуралдааны тэмдэглэлээр төслийг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн саналыг судалж, хамгийн үр ашигтай санал ирүүлсэн хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж төслийг эхлүүлэх арга хэмжээг авахыг тэмдэглэлээр даалгасан.	
18.	2.1.3. Боомт болон орон нутагт суурьшлын бүс хөгжүүлэх төслүүд	Дорноговь аймгийн “Ханги боомт” орчмын суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг “Ланд овнер” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд зураг төслийн баримт бичигт экспертиз хийх “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг”-ийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 114 дүгээр тушаалаар байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яам, Боомтын сэргэлтийн Үндэсний хороотой 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хамтран байгуулсан УТ2406600094004/ЭЗХЯ202438 дугаартай гэрээний дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших “Гашуунсухайт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг “Нью-Урбанизм” ХХК гүйцэтгэж байна. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших “Шивээхүрэн хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг”-ийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 111 дүгээр тушаалаар байгуулсан.	80
3.1. Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтай болон 2025 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн хэрэгжилт			
19.	3.1.1. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга,	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 79 дүгээр тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Хууль зүйн бичигт хүрээлэн” НҮҮТББ шалгарч, 2024.12.02-ны өдөр зөвлөх үйлчилгээний 2024/192 тоот гэрээг байгуулсан. Зөвлөх багаас тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, давхардал, хийдэл, зөрчлийн шинэчилсэн судалгаа, хот байгуулалт, түүний эрх	70

		зүйн орчны SWOT, PESTLE шинжилгээ, гадаадын улс орнуудын хот байгуулалт, төлөвлөлтийн талаарх эрх зүйн зохицуулалтын тойм судалгаа, хуулийн үзэл баримтлалын анхдагч төсөл, танилцуулга зэргийг боловсруулж, 2025.02.19-ний өдөр дундын шатны тайланг хүлээлгэн өгсөн. Эцсийн шатны тайлангийн хүрээнд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажил хийгдэж байна. Тус яамнаас Монголын хуульчдын холбоотой хамтран “Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2025.04.25-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “20 минутын хот” Үндэсний хороо, “20 минутын хот” хөгжлийн төв, НЗДТГ, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, нийслэлийн Ерөнхий архитекторын ажлын алба, Барилгын хөгжлийн төв, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх зэрэг байгууллагуудын 45 гаруй төлөөлөл оролцсон. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2025.07.01-ний өдөр зохион байгуулж, хуулийн төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын явцын талаар хэлэлцүүлж АХ-ийн гишүүдээс санал авсан.	
20.	3.1.2. Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль,	Засгийн газрын “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 483 дугаар тогтоолын /2.1-д Үндэсний орон сууцны санхүүжилтийн корпорацийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх/ хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан. Орон сууцжуулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайд, Хууль зүйн, дотоод хэргийн сайд нараар батлуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу “Үндэсний орон сууцжуулалтын тухай” хуулийн төсөл, түүний хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, үзэл баримтлал, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ, дагах хуулийн төсөл зэргийг боловсруулан Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр өргөн барьж Эдийн засгийн байнгын хороогоор 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн дэмжигдсэн. “Үндэсний орон сууцжуулалтын тухай” хуулийн төсөл, түүнийг даган гарах хуулийн төсөл”-ийг хэлэлцэх эсэх талаар Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэн дэмжигдэж анхны хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангахаар Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараар ахлуулсан ажлын хэсэгт шилжүүлсэн. 2025 оны эхний хагас жилд: Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг нийт 4 удаа хуралдаж, “Хуулийн төсөлд авах зөвлөх үйлчилгээ”-ний гэрээт ажлын гүйцэтгэгч "Легал Инновейшн Хааб" ХХК-ний боловсруулсан “Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл”,	30

		“Хуулийн төсөл”, ажлын тайланг хэлэлцэн санал, дүгнэлт өгч ажилласан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу санал авч батлуулахаар ХЗДХ-ийн сайд, ГБХНХ-ын сайд нарт хүргүүлснээс ХЗДХ-ийн яамнаас дэмжсэн хариуг өгсөн. ГБХНХ-ын Сайдаас “Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо”-гоор хэлэлцүүлсний дараа хариу ирүүлэхээр шийдвэрлэсэн. Хуулийн төслийг байгууллагын цахим хаягт байршуулж олон нийтээс санал авч байна.	
21.	3.1.3. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2024.05.01-нд УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-ын 2024.06.05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. МУ-ын сайд, 20 минутын хот ҮХ-ны даргын 2024.09.02-ны өдрийн 02 дугаар тушаалаар байгуулагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангах, нийслэл УБ хотын Засаг захиргааны шинэчлэлийг санал, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлангаар ахлуулсан ажлын хэсгийн хуралд нийт 3 удаа ХББЗГ-ын дарга Ц.Баярбат, ахлах шинжээч Д.Бэлэгсайхан нар оролцож ажилласан. Ажлын хэсгээс хуулийг 2025.06.01-ний өдрөөс эхлэн мөрдөж хэлэлцэх хугацааг хойшлуулах санал гаргасан бөгөөд, асуудлыг УИХ-ын 2025.05.14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн.	100
22.	3.1.4. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль	Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт орж “Хүннү хотын эрх зүйн байдлын тухай” хуулийг УИХ-ын 2025.01.24-ний өдрийн хурлаар хэлэлцэж баталсан. Хууль 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн	100
Хэрэгжилтийн хувь			85.0

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 22 арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 85.0 хувьтай, “Бүрэн хангалттай” гэж дүгнэж байна.

Шинэ сэргэлтийн бодлогын 2025 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилтээс дараах 6 ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. 1.1.1. Боомтуудыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинээр нэмж боловсруулах замаар боомтуудын хөгжлийг хөрш орнуудын боомттой ижил түвшинд хүргэж, дэд бүтэц, тээвэр зохион байгуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх;

2. 4.2.1. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, суурь дэд бүтцийг барьж байгуулах;

3. 4.2.6. Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын төвлөрлийг бий болгохын тулд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах

4. 5.2.2. Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах;

5. 3.1.1. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга;

6. 3.1.2. Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль;

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Шинэ сэргэлтийн бодлогод туссан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч, 2025 оны 3-р улиралд Сайдын Зөвлөлд эргэж танилцуулахыг бүх газар, хэлтсүүдэд үүрэг болгох;

2. Яамны бүх газар, хэлтсүүд төлөвлөлтөө сайжруулан, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, санхүү, хөрөнгийн тооцоог үндэслэлтэй, бодит, зөв гаргаж хэвших, яамны газар, хэлтсүүд мэдээллээ солилцон хамтран ажиллах;

3. Тайлангийн боловсруулалтад анхаарч, 2000 тэмдэгтэд багтаан, хавсралт материалын хамт тогтоосон хугацаанд ирүүлж хэвшихийг яамны бүх газар, хэлтсүүдэд зөвлөмж болгож байна.

9.2. Хавсралт-2

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.19

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө загварын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж баталсан байна.

“Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2025 оны 06-р сарын 25-ны өдөр баталсан 07 дугаар тогтоолын дагуу яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн 6 тэргүүлэх чиглэлээр боловсруулсан баталж ажиллаж байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлага

1. Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалт

2. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалт

3. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалт

4. Санхүү, хөрөнгө оруулалт

5. Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

Дээрх чиглэлийн хүрээнд яамны стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон байна.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь тухайн хугацааны хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, мэдээллийн үнэн, зөв байдлыг нягтлах зорилгоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг баримталсан.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь нийт 31 зорилтын 306 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 93.7%-ийн

гүйцэтгэлтэй буюу "бүрэн хангалттай" гэж үнэлж байна. Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 270 арга хэмжээ, 70-85% хүртэлх хэрэгжсэн 21 арга хэмжээ, 70 хүртэлх хэрэгжсэн 14 арга хэмжээ, хугацаа болоогүй /ХБ/ 1 арга хэмжээ байна.

Хүснэгт 1. ХББОСЯ-ны ТШЗ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /газар тус бүрээр/

№	Чиглэл	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар			ХБ	%
				85 буюу түүнээс дээш "бүрэн хангалттай"	70-85 хангалттай	70 хүртэл хангалтгүй		
1	Төрийн захиргааны удирдлага	4	82	74	3	4	1	95.0
2	Санхүү, хөрөнгө оруулалт	4	21	20	1			94.1
3	Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалт	8	55	45	7	3		93.4
4	Нийтийн аж ахуйн бодлого хэрэгжилтийг зохицуулах	4	30	26	1	3		92.9
5	Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалт	7	64	51	9	4		91.0
6	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит	4	54	54				96.0
Дүн		31	306	270	21	14	1	93.7

ТШЗ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт зорилт бүрээр харуулбал:

Стратегийн зорилт		Зорилго	Арга хэмжээ тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ
Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр				
1	Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, хууль зүйн зөвлөгөө өгөх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, гамшгаас хамгаалах асуудлыг хариуцах, салбарын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	5.1. төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх болон салбарын хүний эрхийн асуудал болон яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл болон аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах	82	95.0
	Дундаж оноо		82	95.0
Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр				
1	Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, төсөл, хөтөлбөрийг	2.1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын багцын төсвийн хязгаар, төсвийн төслийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих	5	100

2	хэрэгжүүлэх, салбарын гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих	2.2. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах	6	91.8
3		2.3 Төрийн сангийн гүйлгээ гүйцэтгэх, тайлан, баланс гаргах.	5	94
4		2.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах.	5	94
		Дундаж оноо	21	94.8
Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын чиглэлээр				
1		3.1. Хот байгуулалт, хот дахин төлөвлөлтийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, хот, тосгон, суурин газрыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.сайдын эрхлэх асуудлын хүрээний нэгдсэн бодлого, төлөвлөлт, бодлогын нэгдсэн удирдамжаар хангах	9	100
2	Хот байгуулалт, хот дахин төлөвлөлтийг хөгжүүлэх, салбарын хууль тогтоомж, бодлого, зохицуулалт, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл боловсруулах, удирдамж,	3.2. Үндэсний баялгийн сангаар дамжуулан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, орон сууцжуулалтыг эрчимжүүлэх	2	100
3	зохицуулалтаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах	3.3. Өрхийн төлбөрийн чадварт нийцүүлж ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх	7	97.6
4		3.4. "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг өмчлөх хэлбэрийн орон сууцны төслүүдийг хэрэгжүүлэх	2	87.2
5		3.5. Хот байгуулалт, хот дахин төлөвлөлтийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, хот, тосгон, суурин газрыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	36	88.6
		Дундаж оноо	55	93.4
Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын чиглэлээр				
1	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалтаар хангах, төлөвлөлтийг	4.1.нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах,	10	91.8

	хэрэгжүүлэх, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, салбарын хууль тогтоомж, бодлого, зохицуулалт, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.		
2		4.2. хот, тосгон, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, халаалтын шугам сүлжээ, эх үүсвэр, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжийн системийг төлөвлөх, байгуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалтаар хангах.	11	96.7
3		4.3. Орон сууцны ашиглалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	2	58.3
4		4.4.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэх, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.	7	98.4
Дундаж оноо			30	92.9
Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын чиглэлээр				
1	“Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;”	5.1. Барилга, барилгын материалын салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	5	90.0
2		5.2. Барилга, барилгын материалын салбарын төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	14	93.6
3		5.3. Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэх	2	95.0
4		5.4. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	9	88.3
5		5.5. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, газар хөдлөлтийн чиглэлээр норм, дүрэм, журмыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	14	90.7
6		5.6. Барилгын материалын үйлдвэрлэлийн хяналт, шинжилгээний лабораторийн нэгдсэн сүлжээг бий болгох, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	5	92
7		5.7. Салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох, цахимжуулах ажлыг зохион байгуулах	4	90
Дундаж оноо			64	91.01
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр				
1	Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлыг хангах	6.1. Хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг	6	91.7

		хангуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах		
2		6.2. Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, шийдвэрийн биелэлтэд хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн тайлан зөвлөмж, гаргах	18	97.8
3		6.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	4	92.5
4		6.4. Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зарцуулалтад дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	4	95
5	Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүл	6.5. Салбарын хяналтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн ангиллыг тогтоох ажлыг нэгдсэн арга зүй, зохион байгуулалтаар хангана	7	97.1
6		6.6. Салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	15	95.9
			54	96.0
		НИЙТ ОНОО	309	91,9

Хэрэгжилт хангалтгүй ажлууд:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай "хангалтгүй" хэрэгжсэн 14 арга хэмжээ байна. Үүнд:

1. 1.1.12. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулна;

2. 1.1.17. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг яамны газар, хэлтсүүд, ТББ-тай хамтран зохион байгуулна;

3. 1.1.24. Яамны “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах;

4. 1.1.70. Монгол Улсын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, БНСИУ-ын Хамтын ажиллагааны байгууллагатай “Хот байгуулалтын хамтын ажиллагааны санамж бичиг” –ийг эрчимжүүлэх, мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллана

5. 3.1.23. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулна.

6. 3.1.28. Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг ЭЗХЯ, Орхон аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулна,

7. 3.1.48. Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартыг нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

8. 4.1.3. “Ус хангамж. Барилгын гадна систем ба ус хангамжийн ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулна;

9. 4.3.1. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл боловсруулна.

10. 4.3.2. “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууцны барилгын менежмент. Орон сууцны барилгын дундын өмчлөлийн засвар үйлчилгээ. Ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулна.

11. 5.1.7. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг шинэчлэн боловсруулна;

12. 5.1.8. "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам"-ийг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.3.479/

13. 5.2.14. Үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж, хөгжүүлэх /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1011/

14. 5.5.9. Барилгын салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангуулах Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын албан даалгавар батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.


ДӨРӨВ. ДҮГНЭЛТ


1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТШЗ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан нийт 31 зорилтын 306 арга хэмжээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үнэлгээ 93,7 хувьтай "бүрэн хангалттай" үнэлэгдсэн байна.

2. Газар, нэгжүүд дутуу орон тоогоор ажиллаж байгаа нь ажлын гүйцэтгэл удаашрах, ажил цалгардах байдлаар гүйцэтгэлийн үр дүнд шууд нөлөөлж байна.

3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь жилийн эцсийн байдлаар дараах бүтцийн хүрээнд төлөвлөгдсөн байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТШЗ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жилийн эцсийн байдлаар тусгагдсан арга хэмжээ чиглэл тус бүрээр графикаар үзүүлэв.





ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 2026 онд төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг зөв төлөвлөж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын хүрээнд хүрэх буюу зорилтот түвшин, суурь түвшнийг чанар, тоогоор илэрхийлж төлөвлөгөөндөө тусгах;
2. Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд туссан хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг батлагдсан тухайн жилийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх түвшнээр 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөж биелэлтийг ханган ажиллах;
3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний "хангалтгүй" хэрэгжсэн 1.1.12, 1.1.17, 1.1.24, 1.1.70, 3.1.23, 3.1.28, 3.1.48, 4.1.3, 4.3.1, 4.3.2, 5.1.7, 5.1.8, 5.2.14, 5.5.9 дэх 14 арга хэмжээ, хугацаа болоогүй /ХБ/ 1.1.66 дахь 1 арга хэмжээнүүдийн биелэлтийг ханган ажиллах;
4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хүрээнд 5.1.7. дахь арга хэмжээ болох "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх, Ажлын хэсэг байгуулах, хэлэлцүүлэх, санал авах, батлуулах ажлыг 2026 оны эхний улиралд багтаан хэрэгжүүлэх;

5. Шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроохгүй хуулийн хугацаанд иж бүрэн байршуулах;

6. Газар, нэгжүүд орон тоо дутуу, ачаалалтай ажиллаж байгаад дүгнэлт хийж, дутуу орон тоог нөхөж албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөлийг хангах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/-д зөвлөж байна.

9.3. Хавсралт-3

Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

“АЙМГУУДЫН БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ, ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.24

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Бүгд найрамдах Польш Улсын нөхцөлт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлэлт.

Төслийн зорилго: Баян-Өлгий, Завхан, Увс, Говь-Сүмбэр, Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчилж, шинээр барих замаар өсөн нэмэгдэж буй дэд бүтцийн хэрэгцээг хангаж, байгаль орчныг бохирдлоос хамгаалж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Төслийн хүрээнд:

- ТЕЗҮ, зураг төсөл боловсруулах, батлуулах;
- Батлагдсан зураг төслийн дагуу ахуйн бохир усыг цэвэршүүлэх байгууламжийг инженерийн шугам сүлжээ болон дагалдах барилга байгууламжийн хамт барьж ашиглалтад оруулах;
- Хяналт шинжилгээний лабораторийг барьж тоноглон хяналт, удирдлага, компьютерын нэгдсэн сүлжээг нэвтрүүлэх;
- Бохир усыг цэвэршүүлэн, халдваргүйжүүлж дахин ашиглах, лаг, тунадсыг боловсруулах технологи нэвтрүүлэх;
- Төслийн аймгуудын нийтийн аж ахуйн байгууллага болон шинэ технологийн цэвэрлэх байгууламж, лабораторид ажиллах хүний нөөцийн чадавхыг дээшлүүлсэн байна.
- Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, БХБЯ
- Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Увс, Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Дорнод аймгийн ЗДТГ
- Гүйцэтгэгч байгууллага: “АБИ ба СВТ” түншлэл, “Мелиорекс” ХХК
- Төсөл хэрэгжих хугацаа: 2022-2024 он, 2025 он хүртэл сунгагдсан.

Төслийн хүрэх үр дүн:

Үр дүн 1: Бохир ус цэвэрлэх байгууламж шинэчлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.

- Бохир ус цэвэрлэх байгууламжууд орчин үеийн дэвшилтэд техник технологид шилжинэ.
- Бохир усны цэвэрлэгээнд шинжилгээ хийх лабораторитой болно.
- Инженер, техникийн ажилчдын мэргэжлийн ур чадвар дээшилж, ашиглалт, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
- Аймгийн төвийн 150,0 гаруй мянган хүний ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015 стандартад заасан нөхцөл шаардлагыг хангахаас гадна цэвэрлэх байгууламжид

үйлдвэрлэлийн зориулалтаар болон ногоон байгууламжийн хэрэгцээнд дахин ашиглаж болохуйц хэмжээнд хүртэл бохир усыг цэвэршүүлнэ.

- Лаг тунадсыг боловсруулан, ногоон байгууламжид ашиглагдах бордоо болгоно.
- Байгаль орчны тэнцвэртэй байдал хадгалагдаж, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулахад голлох үүрэг гүйцэтгэх болно.

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн 2025 оны төлөвлөгөөний 11 зорилт, 61 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төслийн хэрэгжилтийн нийт түвшин 84.28 хувь, 2025 оны төлөвлөгөөний биелэлт 87.4 хувь, төслийн хэрэгжилтийг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Арга хэмжээний нэр	Нийт хувь
	Ажлын нийт түвшин	84.28%
	2025 оны төлөвлөгөөний биелэлт	87.4%

Төслийн хүрээнд 2025 онд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 87.4 буюу “бүрэн хангалттай” гэж үнэлж байна. Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 48 арга хэмжээ, 70-85% хүртэлх хэрэгжсэн 5 арга хэмжээ, 70 хүртэлх хэрэгжсэн 8 арга хэмжээ байна.

2025 оны төлөвлөгөөний биелэлтийн нэгдсэн дүн

№	Ажил үйлчилгээ	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар			%
				85 буюу түүнээс дээш "бүрэн хангалттай"	70-85 хангалттай	70 хүртэл хангалтгүй	
1	Арга хэмжээний тоо	11	61	48	5	8	87.4%

2025 оны төлөвлөгөөний биелэлтийн гүйцэтгэл 61 арга хэмжээ тус бүрээр

Дугаар	Гүйцэтгэл хувь	Дугаар	Гүйцэтгэл хувь	Дугаар	Гүйцэтгэл хувь	Дугаар	Гүйцэтгэл хувь
1.1	97.5	2.1	74.7	2.2	90.0	3.1	98.7
1.1.1	100.0	2.1.1	100.0	2.2.1	100.0	3.1.1	98.7
1.1.2	100.0	2.1.2	83.3	2.2.2	90.0	3.2	100.0
1.1.3	100.0	2.1.3	100.0	2.2.3	80.0	3.2.1	100.0
1.1.4	90.0	2.1.4	100.0	2.3	96.7	4.1	83.3
1.1.5	100.0	2.1.5	100.0	2.3.1	80.0	4.1.1	33.3
1.1.6	90.0	2.1.6	100.0	2.3.2	100.0	4.1.2	100.0
1.1.7	100.0	2.1.7	100.0	2.3.3	100.0	4.1.3	100.0
1.1.8	100.0	2.1.8	100.0	2.3.4	100.0	4.1.4	100.0
1.2	96.4	2.1.9	100.0	2.3.5	100.0	4.2	81.5
1.2.1	100.0	2.1.10	80.0	2.3.6	100.0	4.2.1	100.0
1.2.2	100.0	2.1.11	100.0	2.4	97.5	4.2.2	44.4
1.2.3	100.0	2.1.12	100.0	2.4.1	100.0	4.2.3	100.0
1.2.4	100.0	2.1.13	100.0	2.4.2	90.0		
1.2.5	75.0	2.1.14	50.0	2.4.3	100.0		
1.2.6	100.0	2.1.15	25.0	2.4.4	100.0		
1.2.7	100.0	2.1.16	100.0				
1.3	96.7	2.1.17	0.0				
1.3.1	100.0	2.1.18	100.0				
1.3.2	90.0	2.1.19	0.0				
1.3.3	100.0	2.1.20	0.0				
		2.1.21	0.0				

Төлөвлөгөөний биелэлтийг арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Биелэлт	%
1	2	6	9	
1.1.1	Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төслийн удирдах хорооны тогтоолоор батлуулах	2025 оны төлөвлөгөө-1; ТУХ-ны тогтоол-1	Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төслийн удирдах хорооны 2024.12.16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн “Төслийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай” 2025.02.28-ны өдрийн №5 дугаар тогтоолоор баталсан.	100
1.1.2	Төслийн Удирдах Хороог төлөвлөгөөт болон цаг үеийн шаардлагаар хуралдуулах, хурлыг зохион байгуулахад шаардлагатай холбогдох баримт материалыг бэлтгэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлэх	ТУХ-ны зөвлөмжийн биелэлт -100%	Төслийн удирдах хорооны 2025.03.20-ны өдрийн хурлыг хэлэлцэх асуудлын жагсаалт, танилцуулга болон холбогдох материалыг бэлтгэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтэст хүргүүлэн холбогдох саналыг тусган Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 25 дугаар тушаалаар батлагдсан Удирдах хорооны бүрэлдэхүүнд цахимаар илгээсэн. Төслийн удирдах хорооны хурал 2025.03.20-ны өдрийн 09.00 цагт ХББОСЯ-ны хурлын зааланд хуралдаж Төслийн удирдах хорооны 2025.03.20-ны өдрийн №8 дугаар зөвлөмж гарсан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.08.12-ны өдрийн 182 дугаар тушаалаар ТУХ-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан бөгөөд ТУХ-ны хурлын тов гарснаар төслийн ерөнхий төлөвлөгөө, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээг хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	100
1.1.3	Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны холбогдох газруудад тайлагнах	2025 оны төлөвлөгөөний биелэлт -4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТУХ-ны 2025.02.28-ны өдрийн №5 дугаар тогтоолоор баталсан Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний I улирлын биелэлтийг 2025.04.08-ний өдрийн а/59 тоотой ERP системээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтэст хүргүүлсэн. Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний II улирлын биелэлтийг, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлангийн хамт 2025.06.16-ны өдрийн 109 тоотой, III улирлын биелэлтийг 2025.09.25-ны өдрийн 166 тоотой ERP системээр ХББОСЯ-ны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтэст хүргүүлсэн бөгөөд 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, биелэлтийг 2025.12.10-ны дотор хүргүүлнэ.	100

1.1.4	Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг ТУХ-ны хурлаар хэлэлцүүлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээ-2; Гүйцэтгэлийн тайлан-2; ТУХ-ны зөвлөмж-1	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны хүрээнд 4 зорилгын хүрээнд 11 зорилтын 61 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг II дугаар улирлын байдлаар гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, гүйцэтгэлийн тайлангийн хамт боловсруулан 2025.06.16-ны өдрийн 109 тоотой Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөл хөтөлбөрийн хэлтэст хүргүүлсэн. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 90,3 хувьтай байна. 2025 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2025 оны 12 дугаар сард ХББОСЯ-ны ТУХ-ны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Хурлын тов гараагүй байна.	90
1.1.5	Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын дагуу гаргах төслийн хэрэгжилтийн явцын тайланг гаргах	Хавсралт13-12; Хавсралт14-1	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс/” төслийн 2025 оны хэрэгжилтийн явцын 01 дүгээр сарын тайланг 2025.04.07-ны өдөр а/51 тоотой ERP системээр дахин илгээсэн; 02 дугаар сарын тайланг 2025.03.27-ны өдрийн а/42 тоотой; 03 дугаар сарын тайланг 2025.04.11-ний өдрийн а/63 тоотой; I улирлын тайланг 2025.04.11-ний өдрийн а/65 тоотой; 04 дүгээр сарын тайланг 2025.05.05-ны өдрийн а/83 тоотой; 05 дугаар сарын тайланг 2025.06.03-ны өдрийн №101 тоотой; 06 дугаар сарын тайланг 2025.07.04-ний өдрийн №120 тоотой; II улирлын тайланг 2025.07.07-ны өдрийн 121 тоотой; 07 дугаар сарын тайланг 2025.08.01-ний өдрийн №140 тоотой; 08 дугаар сарын тайланг 2025.09.03-ны өдрийн №155 тоотой, 09 дүгээр сарын тайланг 2025.10.01-ны өдрийн №173 тоот, III улирлын тайланг 2025.10.10-ны өдрийн №182 тоот, 10 дугаар сарын тайланг 2025.11.04-ны өдрийн №190 тоот, 11 дүгээр сарын тайланг 2025.12.04-ний өдрийн №208 тоот албан бичгээр тус тус ERP системээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.	100
1.1.6	ТХН-ийн ажилтнуудын “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг жилийн эцэст үнэлэх, сунгуулах	Үнэлэх хуудас-9, Сунгалт-9	Сангийн сайдын 2025.10.01-ний өдрийн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц орон тоог батлах тухай 174 дугаар тушаалын дагуу Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдахтай холбогдуулан НТХН-ийн ажилтнуудын сонгон шалгаруулалт зохион байгуулагдсан тул НТХН-ийн сонгон шалгарсан ажилтан бүрийн Хөлсөөр	90

			ажиллах гэрээг холбогдох шийдвэрийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор шинэчлэн байгуулна.	
1.1.7	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан бүрийн Хөлсөөр ажиллах гэрээний хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гаргуулах, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэрэгжилтийг сар бүр гаргуулах, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим PIMIS системд тайлагнах	PIMIS системд тайлагнах ажилтнууд-9	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын Хөлсөөр ажиллах гэрээний 2025 оны баталгаажуулалт Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим PIMIS систем хөгжүүлэлтийн явцаас шалтгаалан 2025.03.25-ны өдөр гэрээнүүдийг баталгаажуулсан бөгөөд PIMIS системд ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэрэгжилтийг тайлагнах ажил хийгдэж байна. Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэрэгжилтийг сар бүр гаргуулан авч цаасаар баталгаажуулж байна.	100
1.1.8	Иргэд ААН, байгууллагаас ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг шийдвэрлэх	Хүлээн авч шийдвэрлэсэн албан бичгийн шийдвэрлэлт-100%	2025 онд Төсөл хэрэгжүүлэх нэгжид ААН, байгууллагаас ирсэн албан бичигт тухай бүр хариу өгч, холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлж ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар ААН, байгууллагаас нийт 180 албан бичиг, 257 цахим шуудан хүлээн авч, төслийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох ААН, байгууллагад Төсөл хэрэгжүүлэх нэгжээс нийт 204 албан бичиг, 245 удаагийн цахим шуудан хүргүүлсэн. 2025 оны 1-р улиралд иргэд ААН, байгууллагаас 54 бичиг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. Холбогдох ААН, байгууллага руу 55 албан бичиг хүргүүлсэн. Хүлээн авсан цахим шуудан -88, илгээсэн цахим шуудан -81 байна. 2025 оны 2-р улиралд иргэд ААН, байгууллагаас 53 бичиг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. Холбогдох ААН, байгууллага руу 69 албан бичиг хүргүүлсэн. Хүлээн авсан цахим шуудан -84, илгээсэн цахим шуудан -90 байна. 2025 оны 3-р улиралд иргэд ААН, байгууллагаас 29 бичиг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. Холбогдох ААН, байгууллага руу 45 албан бичиг хүргүүлсэн. Хүлээн авсан цахим шуудан -336, илгээсэн цахим шуудан -45 байна. 2025 оны 4-р улиралд иргэд ААН, байгууллагаас 44 бичиг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. Холбогдох ААН, байгууллага руу 35 албан бичиг хүргүүлсэн. Хүлээн авсан цахим шуудан -49, илгээсэн цахим шуудан -29 байна.	100
1.2.1	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн	2025 үйл ажиллагааны урсгал зардлын	Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалын 11.8-д заасан "Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг улирал бүр энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу тайлагнан дараа улирлын үйл ажиллагааны төсвийн хамт Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн	100

	2025 үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг төлөвлөн улирал бүр батлуулах	батлагдсан төлөвлөгөө-4	захиргааны төв байгууллагад ирүүлнэ” гэж заасныг үндэслэн “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн 2025 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг 2025.01.15-ны өдрийн а/06 тоот, 02 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг 2025.04.01-ний өдрийн а/50 тоот, 03 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг 2025.06.24-ний өдрийн а/116 тоот, 04 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг 2025.09.26-ны өдрийн а/168 тоот албан бичгээр хэрэгжүүлэгч яаманд хүргүүлэн Сангийн яаманд уламжилсан бөгөөд Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газраас Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 01 дүгээр улирлын урсгал зардлын төсвийг 186,086,375 төгрөгөөр; 02 дугаар улирлын урсгал зардлын төсвийг 191,319,125 төгрөгөөр; 03 дугаар улирлын урсгал зардлын төсвийг 217,981,125 төгрөгөөр; 04 дүгээр улирлын урсгал зардлын төсвийг 194,923,875 төгрөгөөр тус тус баталсан.	
1.2.2	Төслийн хүрээний 2025 гадаад зээлийн ашиглалтын хөрөнгө оруулалтын төсвийн саналыг боловсруулж Төсвийн тухай хуулийн дагуу цаг хугацаанд нь ТХБ-д хүргүүлэн ажиллах	ТХН хянасан гадаад зээлийн хөрөнгө оруулалтын төсвийн санал-2 шийдвэрлүүлэлт-100%	Төслийн хүрээний 2025 оны гадаад зээл ашиглалтын төсвийн саналыг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хэрэгжүүлэгч яаманд хүргүүлсэн ба Монгол Улсын Сангийн Сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот албан бичгийн хавсралтад заасны дагуу нийт 19,396.5 сая төгрөгийн дүнтэйгээр батлагдан хэрэгжүүлэгч яаманд ирүүлсэн.	100
1.2.3	Санхүүгийн тайлан тэнцлийг хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах, аудитын дүгнэлт хийлгэн баталгаажуулах, 2024 оны санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргуулж баталгаажуулах	Санхүүгийн тайлан: 2025 он-2; Аудитын дүгнэлт -1	2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын багцын хүрээнд Үндэсний аудитын газрын түүвэр аудитад хамрагдаж зөрчилгүй шалгагдсан. 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэн боловсруулж хуулийн хугацаанд нь Сангийн яамны цахим системд шивж баталгаажуулсан. 2025 оны жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн боловсруулж байгаа ба хуулийн хугацаанд нь буюу 2026 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.	100
1.2.4	Татварын болон нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Татварын тайлан: 2025 он-4 Нийгмийн даатгалын тайлан: 2025 он-12	2025 оны 1-12 дугаар саруудын нийгмийн даатгалын тайланг хуульд заасан хугацаанд нь харьяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст цаасаар болон цахим системд тайлагнан баталгаажуулсан ба ажилтнаас суутган тооцсон болон ажил олгогчийн хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг хуулийн хугацаанд нь буюу сар бүр төлж барагдуулсан. 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын ХАОАТ-ын тайланг бэлтгэн боловсруулж хуулийн хугацаанд etax.mta цахим системд шивж баталгаажуулсан ба 2026 он гарснаар 2025 оны 4 дүгээр улирлын ХАОАТ-ын тайланг шивэх эрх нээгдэх тул тухайн хуулийн хугацаанд цахим	100

			системд шивэхэд бэлэн бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.	
1.2.5	Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу тухайн жилийн санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянан батлуулах, бүртгэх, тайлагнах	2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө-1; хэрэгжилт-100%	2025 оны төслийн хүрээний санхүүжилтийн ерөнхий төлөвлөгөөг ТУХ-ны хурлын хэлэлцэх асуудлын хүрээнд танилцуулан ТУХ-ны 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлуулсан.	75
1.2.6	Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг хянан баталгаажуулж ХББОСЯ-нд хүргүүлэх, Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлэх	Гадаад зээл ашиглалтын тооцоо нийлсэн акт 2025 он-1	2025 онд Баян-Өлгий аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил болон тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэлд нийт 601,229.62 евро, Говьсүмбэр аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэлд 561,125.98 евро, Завхан аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэлд 680,450.33 евро, Увс аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэлд 633,572.76 евро буюу нийт 2,476,378.69 еврогийн санхүүжилтийг хянан баталгаажуулж хэрэгжүүлэгч яам болон Сангийн яаманд уламжлан шийдвэрлүүлсэн.	100
1.2.7	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлийг хөтлөх	2025 он: Багц1; Багц2; Багц3; Багц4; Багц5	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлийг Багц1; Багц2; Багц3; Багц4 ангиллын хүрээнд бүртгэн хөтөлж байна. ТӨБЗГ-ын мэргэжилтэн Баясгалангийн өгсөн чиглэлийн хүрээнд ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгөх хөрөнгийн хүрээнд дамжуулан зээлийн гэрээ байгуулагдсан байх гэсэн шаардлагын дагуу Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэст хандан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас орон нутгийн ашиглагч байгууллагуудтай дамжуулан зээлийн гэрээг албажуулах гэрээний драфтыг дахин боловсруулж 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 02/10036 тоот албан бичгээр Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн Засаг даргын тамгын газруудад хүргүүлээд байна.	100
1.3.1	Төсөл хэрэгжүүлэх нэгж хүлээн авсан болон илгээсэн албан бичгийг Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу бүртгэл үүсгэж нэгдсэн санг бий болгох	2025 оны албан бичгийн бүртгэл -1	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүлээн авсан болон илгээсэн албан бичгийг Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу бүртгэл үүсгэж хадгалсан. Мөн Drive.Google-ийн санд файл хэлбэрээр хадгалж нэгдсэн сан бий болгосон. 2025 оны 1-р улиралд хүлээн авсан болон илгээсэн албан бичиг нийт 109 файлыг үүсгэж нэгдсэн санд хадгалсан. 2025 оны 2-р улиралд хүлээн авсан болон илгээсэн албан бичиг нийт 122 файлыг үүсгэж нэгдсэн санд хадгалсан. 2025 оны 3-р улиралд хүлээн авсан болон илгээсэн албан бичиг нийт 74 файлыг үүсгэж нэгдсэн санд хадгалсан. 2025 оны 4-р улиралд хүлээн авсан болон илгээсэн албан бичиг нийт 89 файлыг үүсгэж нэгдсэн санд хадгалсан.	100
1.3.2	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн архивын нэгжийг тухайн онд бүрдүүлэн ажиллах	2025 он: 2 нэгж	2025 онд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны архивын нийт 8 нэгж бичиг, 2022, 2023, 2024 оны нийт 4 нэгж бичиг дээр тус тус хүлээн авсан огноо, боловсруулсан хянасан, баримт бичгийн	90

2.4.3	Цэвэрлэх байгууламжид лаборатори болон лаг усгүйжүүлэх байгууламжид ашиглагдах химийн бодис, урвалжийг нийлүүлэх, хадгалалтын талаар судалгаа хийх, лагийг байгалийн шохойгоор боловсруулах арга норм дүрэм, гарын авлага боловсруулах ажлыг зохион байгуулах холбогдох судалгааг хийх	Судалгааны явц-100%; Гарын авлага боловсруулалт-100%; Заавар боловсруулалт 100%	Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын цэвэрлэх байгууламжийн лаборатори болон лаг усгүйжүүлэх байгууламжид ашиглагдах химийн бодис, урвалжийг нийлүүлэх, хадгалалтын талаар судалгаа, лаг усгүйжүүлэх полимер, лагийг байгалийн шохойгоор халдваргүйжүүлэх, боловсруулах, цэвэрлэгдсэн хаягдал усыг халдваргүйжүүлэх электролизийн станцын давсыг ханган нийлүүлэх, хадгалах гарын авлага, зааврыг боловсруулсан.	100
2.4.4	Бүгд найрамдах Польш улсаас нийлүүлэгдэх Цэвэрлэх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын норм, стандартад нийцлийн талаар холбогдох судалгааг хийх, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулах	Судалгааны явц-100%; Гарын авлага боловсруулалт-100%;	Төслийн гэрээний хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын бохир цэвэрлэх байгууламжуудын импортоор оруулж ирсэн тоног төхөөрөмжүүдийг Монгол улсын стандартад нийцэж байгаа эсэх талаар үйлдвэрлэгч болон гүйцэтгэгч компанийн зүгээс тодорхойлолт гаргаж тоног төхөөрөмж бүрийг паспортжуулах ажлыг хүрээнд БНХАУ-аас оруулж ирсэн: 1. Баян-Өлгий аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн-Техник ашиглалтын паспорт №1-Электролизийн станц; №6- Дизель хөдөлгүүрийн генераторын нэгж; №241011; №241012-Хяналтын самбар; Усан халаалтын зуух; 2. Увс аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн- /Техник ашиглалтын паспорт №2-Электролизийн станц; №5-Дизель хөдөлгүүрийн генераторын нэгж; №241021; №241022-Хяналтын самбар; Усан халаалтын зуух; 3. Завхан аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн- /Техник ашиглалтын паспорт №3-Электролизийн станц; №7-Дизель хөдөлгүүрийн генераторын нэгж; №241041; №241042-Хяналтын самбар; Усан халаалтын зуух; 4. Говьсүмбэр аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн- /Техник ашиглалтын паспорт №4-Электролизийн станц; №8-Дизель хөдөлгүүрийн генераторын нэгж; №241031; №241032-Хяналтын самбар; Усан халаалтын зуухыг тус тус ерөнхий гүцэтгэгч "Smart Waste	100

			Technologies sp. z o.o.”-компанийн зүгээс паспортжуулаад байна. Мөн эхний ээлжид импортоор оруулж ирсэн M-Comby маркын хосолсон механик цэвэрлэгээний төхөөрөмж, APKV маркын хоолой хэлбэрийн агааржуулалтын диффузер, MOw маркын лаг, тунадас холигч төхөөрөмж, SEEPEX маркын шурган насос, GRs маркын элс ялгагч, MDQ-C, CL маркын Олон дискт, шурган усгүйжүүлэгч, пресслэгч зэрэг тоног төхөөрөмжүүдийг угсрах, ажиллуулах ашиглалтын гарын авлагыг орчуулж дуусгасан.	
3.1.1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тухай бүр оруулах, баталгаажуулах	2025 он: тайлан-4; мэдээ-155	2025 оны 1-12 дугаар сарын шилэн дансны мэдээллийг “Шилэн дансны тухай хууль”-ийн 6.1.2 дугаарт заасан хугацаанд шилэн дансны системд хуулийн хугацаанд оруулан нийтэд ил тодоор тайлагнан ажилласан. 2025 оны 4 дүгээр улирлын шилэн дансны тайлан мэдээг хуульд заасан хугацаа буюу 2026 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн дотор тайлагнаж баталгаажуулахаар холбогдох мэдээллүүдийг бэлтгэн ажиллаж байна.	98.7
3.2.1	Төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системд цаг тухайд нь оруулах	2025 он:13	Тайлант хугацаанд “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн ТУХ-ны 2024.01.05-ны өдрийн 06/2024 дугаар тогтоол, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийн тайланг жилийн эцсийн байдлаар; ТУХ-ны 2024.12.20-ны өдрийн 44 дугаар зөвлөмжийн хамт; ТУХ-ны 2025.02.28-ны өдрийн “Төслийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай” 05 дугаар тогтоол; Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын Хавсралт 14-ийн дагуу боловсруулсан 2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан; Хавсралт 13-ын дагуу “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн 2025 оны 01-р, 02-р, 03-р, 04-р, 05-р, 06-р, 07-р, 08-р, 09-р, 10-р, 11-р сарын хэрэгжилтийн явцын тайлан; 2025 оны I, II, III улирлын хэрэгжилтийн явцын тайлан; ерөнхий гүйцэтгэгч "Smart Waste Technologies" sp. z o.o компанитай байгуулсан 2021/221, 2021/222, 2021/223, 2021/224 тоот гэрээний 2024/31; 2024/32; 2024/33; 2024/34 тоот нэмэлт өөрчлөлт №3; ТУХ-ны 2025.03.20-ны өдрийн №7 дугаар тогтоолоор батлагдсан Төслийн 2025 оны худалдан авах төлөвлөгөө; ТУХ-ны 2025.03.20-ны өдрийн №8 дугаар зөвлөмж; төслийн Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын 2025 оны Барилга угсралтын нэгдсэн төлөвлөгөө; “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын цэвэрлэх байгууламжийн ерөнхий гүйцэтгэгч Smart Waste Technologies Sp. z o.o.	100

			компанитай байгуулсан 2021/221, 2021/222, 2021/223, 2021/224 тоот түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээний хүрээнд батлагдсан тоног төхөөрөмжийн 1,2 дугаар ээлжийн жагсаалт; Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдах ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах 2025.05.22-ны өдрийн 2025/12 дугаартай ажлын даалгавар; Баян-Өлгий аймгийн №2025/132; Говьсүмбэр аймгийн 2025/131; Завхан аймгийн 2025/133 дугаартай гэрээний нэмэлт өөрчлөлт №4-ийг тус тус; Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн зураг төслийн 2025.06.17-ны өдрийн Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдах 10,000 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн гадна шугам сүлжээний ажлын зураг, төсвийн 0982/2025 дугаартай Магадлалын нэгдсэн дүгнэлтийн нэгтгэл; Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн зураг төслийн 2025.09.02-ны өдрийн Дорнод аймгийн 10,000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг, төсвийн 1551/2025 дугаартай магадлалын дүгнэлтийн нэгтгэл; Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын гэрээгээр хүлээсэн ажил үүргийн биелэлтийн 2025 оны сар, улирлын тайланг тус тус оруулсан.	
4.1.1	Төслийн аймгуудын НАА байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг чадавхижуулах болон цэвэрлэх байгууламж дээрх технологийн болон дотоод сургалт	Сургалт -3; ИТА-36	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн Баян-Өлгий аймгийн “СУАТ” ХХК; Говьсүмбэр аймгийн “УС ДУ” ОНӨААТҮГ; Завхан аймгийн “АМЬ-УС” ХХК; Увс аймгийн “ЧАНДМАНЬ-УВС” ХХК-ийн НАА байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг чадавхижуулах болон цэвэрлэх байгууламж дээрх технологийн болон дотоод сургалтыг ерөнхий гүйцэтгэгч “Смарт Вест Технолоджис” компанийн 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 312/2025 дугаартай албан бичгээр ирүүлсэн хөтөлбөрийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 03-наас 06-ны өдрүүдэд аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах Нийтийн аж ахуйн байгууллагын дарга, ерөнхий инженер, цахилгаан автоматикийн инженер, лабораторийн ажилтныг чадавхижуулах сургалтыг Баян-Өлгий аймагт зохион байгуулсан.	33.3
4.1.2	Төслийн хүрээнд аймгуудын НАА байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг дотоодын их, дээд сургуулиудад сургах ажлыг зохион байгуулах	ИТА-4	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагад шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий аймгийн “СУАТ” ХХК; Говьсүмбэр аймгийн “УС ДУ” ОНӨААТҮГ; Завхан аймгийн “АМЬ-УС” ХХК; Увс аймгийн “ЧАНДМАНЬ-УВС” ХХК-ийн 4 боловсон хүчнийг холбогдох дотоодын их, дээд сургуулиудад сургахаар гурвалсан гэрээг	100

			байгуулсан. Гэрээнд заагдсаны дагуу сургалтын төлбөрийн 50% нь холбогдох сургуулиудын дансанд шилжигдсэн болно. ИТА нарын сургалтын хөтөлбөр 2025 оны 2-р сард эхэлсэн.	
4.1.3	БНПУ-д орон нутгийн нийтийн аж ахуйн инженер, техникийн ажилчдыг БНПУ-д дадлагажуулах сургалтыг зохион байгуулах	Сургалт -1; ИТА-8	Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн нийтийн аж ахуйн байгууллагын инженер, лаборантуудыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 19 хооронд буюу 14 хоног ХББОСЯ-ны НААБХЗГ-ын Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Магсаржаваар ахлуулан тус төслийн хүрээнд баригдаж буй АО технологийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг Монгол орны уур амьсгал, цаг агаарын нөхцөлд тохируулан амжилттай нутагшуулах. Польш улсад үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг газар дээр нь үзэж танилцаж туршлага судлах сургалт зохион байгуулагдаж нийт 10 хүн хамрагдав.	100
4.1.4	БНПУ-д Орон нутгийн НАА байгууллагын удирдлагын менежментийн сургалт зохион байгуулах	Сургалт -1 Удирдлага-4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.02.18-ны өдрийн Б/29 дугаар тушаалын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас хэрэгжүүлж байгаа “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 02-10-ны өдрүүдэд цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч болон ашиглалт, засвар үйлчилгээний байгууллагатай танилцах сургалтын арга хэмжээ Бүгд Найрамдах Польш Улсад зохион байгуулагдаж нийт 7 хүн хамрагдсан.	100
4.2.1	Төслийн хүрээнд бий болсон өмч хөрөнгийн өмчлөгч болон ашиглагч байгууллагыг тодорхой болгон, төсөл хэрэгжүүлэх нэгжийн данс бүртгэл, санхүүгийн тайланд бүртгэлтэй зээл, тусламжийн хөрөнгөөр бий болсон өмч, хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх, нэгтгэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, тайлагнах	ТӨБЗГ-ын тогтоолын төсөл-4	Төслийн хүрээнд бий болсон өмч хөрөнгийг ашиглагч байгууллага болох аймгуудийн нийтийн аж ахуйн удирдах газруудад ТӨБЗГ-ыг тогтоолын дагуу хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хийгдэж байна. ТӨБЗГ-ын зүгээс ТӨБЗГ-ын тогтоол гаргуулах бэлтгэл ажилд Сангийн яам, аймгуудын Засаг даргын тамгын газар хооронд дамжуулан зээлийн гэрээг албажуулсан байх шаардлага тавьсны дагуу Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Гүнбилэгтэй холбогдон 2024 оны 8 дугаар сарын 27-ний өдрийн 03/7111 тоот албан бичгээр Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын засаг дарга нарт хүргүүлсэн дамжуулан зээлийн гэрээний төслийг шинэчлэн дахин хүргүүлэхээр болсон. Засгийн газрын 2025 оны 113 дугаар тогтоолоор төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэсэнтэй холбоотойгоор Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.11.10-ны өдрийн №02/10036 тоот албан бичгээр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний төслийг дахин Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газарт, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газарт, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газарт, Увс аймгийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн.	100

4.2.2	Төсөл дуусгавар болохоос өмнө төслийн хүрээнд бий болох үр дүн болон бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн тогтвортой, үр ашигтай ашиглах төлөвлөгөө (удирдлага, хуний нөөц, санхүүгийн чадавх), түүнд шаардагдах төсвийн тооцоог гүйцэтгэгчээс гаргуулах, хаалтын төлөвлөгөөг боловсруулах	Төлөвлөгөө-4 Төсвийн тооцоо-4 Хаалтын төлөвлөгөө-1	Төслийн аймгуудын нийтийн аж ахуйн байгууллагыг чадавхжуулах, хүний нөөцийг бэхжүүлэх зорилтын хүрээнд техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан үйл ажиллагааны схем болон бизнес моделийг өнөөгийн өрхийн болон ААНБ-ын холболтын нөхцөл байдалтай уялдуулан цэвэрлэх байгууламжийн ашигт ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн зөвлөх үйлчилгээг авч, түүнд шаардагдах төсвийн тооцоог өнөөгийн бохир усны үнэ, тарифын бодит судалгаанд тулгуурлан төслийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн тогтвортой, үр ашигтай ашиглахад ашиглагч байгууллагад дэмжлэг үзүүлэхийг; туршилт тохируулгын ажилтай уялдуулан зохион байгуулагдах дотоод сургалтыг мэргэжил дээшлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхийг ТХН-ийн 2025.08.12-ны өдрийн 146 тоот албан бичгээр ерөнхий гүйцэтгэгч Smart Waste technologies sp z.o о-д хүргүүлсэн. Ерөнхий гүйцэтгэгчээс лабораторийн химийн бодис, цахилгаан эрчим хүч, халаалтын зуухны нүүрс, ажиллах хүч /цэвэрлэх байгууламжийн бүтэц орон тоог үйлдвэрийн менежер, технологийн инженер, механик инженер, тоног төхөөрөмж, суурилуулалт, ашиглалт, засвар үйлчилгээ хариуцсан сантехникийн техникч-4, лабораторийн техникч буюу химич, лаборант, сантехникийн туслах ажилтан-2, хамгаалалтын ажилтан буюу харуул – 3, автоматжуулалтын мэргэжилтэн, цахилгааны техникч, эдийн засагч буюу нийт 18 хүнээр тооцоолсон/, давс, лагийг халдваргүйжүүлэх шохой, лаг үсгүйжүүлэх полимерийн ашиглалтын хэрэглээний сарын дундаж зардлын тооцоог гарган Баян-Өлгий аймгийн ашиглалт, үйл ажиллагааны жилийн зардлыг 729,273,930 төгрөгөөр, Говьсүмбэр аймгийн ашиглалт, үйл ажиллагааны жилийн зардлыг 661,343,980 төгрөгөөр, Завхан аймгийн ашиглалт, үйл ажиллагааны жилийн зардлыг 692,311,290 төгрөгөөр, Увс аймгийн ашиглалт, үйл ажиллагааны жилийн зардлыг 692,311,290 төгрөгөөр тооцож 2025.11.28-ны өдрийн 317/2025 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд ажилчдын цалин болон цахилгааны зардал тухайн бүс орон нутгийн онцлогоос шалтгаалан өөрчлөгдөж болох юм. 4 аймгийн хаалтын төлөвлөгөө боловсруулалтын шатанд, туршилт, тохируулгын төлөвлөгөө баталгаагүй байгаагаар холбогдуулан хүлээгдэж байна.	44.4
4.2.3	Төслийн хэрэгжилт, үр ашгийг үнэлэн, төслийн хаалтын тайланг холбогдох журамд заасан хугацаанд Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх	Хаалтын тайлан-1	Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын маягт-14, маягт-16 дагуу төслийн хэрэгжилтийн эцсийн тайланг 2025 оны байдлаар боловсруулсан ба цэвэрлэх байгууламжуудыг ашиглалтад оруулснаар Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасны дагуу цэвэрлэх байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг	100

			жил байх бөгөөд дээрх хугацаанд технологийн тоног төхөөрөмж, системийн 2026 онд хийгдэх тохируулга, зүгшрүүлэлтийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамааран төслийн эцсийн үр ашиг тодорхойлогдох боломжтой болно.	
--	--	--	--	--

Төслийн нэгжийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар хэрэгжилт “хангалтгүй” 70-аас доош хувьтай үнэлэгдсэн 8 арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.1.14. Ашиглалтад хүлээлгэж өгөх /Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс/;
2. 2.1.15. Туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг эхлүүлэх /Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс/;
3. 2.1.17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох газруудаар батлуулах /Дорнод/;
4. 2.1.19. Гэрээт ажлын цар хүрээг тодорхой болгох /Дорнод/;
5. 2.1.20. Магадлалын нэгдсэн дүгнэлт гарснаар барилга угсралтын ажил эхлэх бэлтгэл хангагдаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх /Дорнод/;
6. 2.1.21. Тоног төхөөрөмжийн захиалга хийх, үйлдвэрлэх /Дорнод/;
7. 4.1.1. Төслийн аймгуудын НАА байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах болон цэвэрлэх байгууламж дээрх технологийн болон дотоод сургалт;
8. 4.2.2. Төсөл дуусгавар болохоос өмнө төслийн хүрээнд бий болох үр дүн болон бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн тогтвортой, үр ашигтай ашиглах төлөвлөгөө (удирдлага, хуний нөөц, санхүүгийн чадавх), түүнд шаардагдах төсвийн тооцоог гүйцэтгэгчээс гаргуулах, хаалтын төлөвлөгөөг боловсруулах;

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Төслийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн төслийн хэрэгжилтийн нийт түвшин 84.28 хувь, 2025 оны төлөвлөгөөний биелэлт 87.4 хувьтай “бүрэн хангалттай” гэж дүгнэв.

2. Тухайн төсөл арга хэмжээ нь 5 аймгийн цэвэрлэх байгууламжаас Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр 4 аймгийн цэвэрлэх байгууламж ашиглалтад бүрэн орсон байна. Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын хоцрогдлоос шалтгаалан жилийн төлөвлөгөөний биелэлтийн гүйцэтгэл буурах шалтгаан болж байна.

3. Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсөв эцэслэгдэн батлагдсан байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төслийн нэгж /Ц.Ариунтуяа/-д үүрэг болгох:

1. Төслийн нэгж нь гүйцэтгэл дууссан 4 аймгийн зүгшрүүлэлтэд анхаарах, данс тооцоо, өмч хүлээлцэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран яаралтай шийдвэрлэх;

2. Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн 2026 оны барилга угсралтын ажлын нэгдсэн төлөвлөгөө болон календарьчилсан төлөвлөгөөг гаргуулж төслийн нэгжийн төлөвлөгөөнд тусган дахин хойшлуулахгүйгээр төслийг хугацаанд нь дуусгах;

3. Барилгын талбайд ажиллах хүн хүч, машин механизмын хүчин чадал, тоног төхөөрөмжийн татан авалт, бараа, материалын нөөцлөлт, барилгын талбайн зохион байгуулалтын үйл ажиллагааг сайн оновчтой төлөвлөн зохион байгуулж, барилга байгууламжийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах ажлын төлөвлөгөө, графикийг холбогдох байгууллагуудтай хамтран гаргаж батлуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллах;

4. Төслийн 2026 онд дуусгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар /М.Ням-Очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ц.Ариунсанаа/, Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Бат-Эрдэнэ/-уудтай нягт уялдаатай ажиллах.

“ДАРХАН ХОТЫН ЦЭВЭР УСНЫ ШУГАМ СҮЛЖЭЭГ ӨРГӨТГӨХ, ШИНЭЧЛЭХ, УХААЛАГ
ТООЛУУР НЭВТРҮҮЛЭХ ТӨСӨЛ”- ИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.31

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт өгч, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, удирдлагыг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”- ыг үндэслэл болгов.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх “AUS 239 885” төсөл
Төслийн зорилго:	Усны нөөцийг хамгаалахад бодит хувь нэмэр оруулж, усны зүй зохистой хэрэглээг дэмжин, Дархан хотын усны алдагдлыг бууруулж, ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг сайжруулан хэрэглэгчдийг эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаат ус хангамжийн үйлчилгээгээр хангах нөхцөлийг бүрдүүлэх, Дархан хотын усны хэрэглээнд ухаалаг систем нэвтрүүлж, монголын анхны ухаалаг хэрэглээтэй цахим хот болгоход оршино.
Хүрэх үр дүн:	Дархан хотын цэвэр усны магистрал шугам сүлжээний зарим хэсэг шинэчлэгдэж, усны алдагдал буурах, хүн амын ус хангамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, усны зарцуулалт, хэрэглээг ухаалгаар хянаж, эдийн засгийн хэмнэлт бий болно
Хугацаа:	2023-2025.12.31. Зээлийн ашиглалтын хугацааг ЮниКридет банкнаас 2026.06.30 хүртэл сунгасан.
Санхүүжилтийн эх үүсвэр:	Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, БН Австри Улсын ЮниКридет Банкны нөхцөлт зээл. Гадаад зээл
Төсөвт өртөг:	Нийт: 7.5 сая ЕВРО:
Ерөнхий захиалагч:	- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам. - Сангийн яам
Захиалагч:	Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгж. (Сангийн сайдын 2023 оны 113 дугаар тушаал)
Гүйцэтгэгч:	Ерөнхий гүйцэтгэгч: БН Австри У-ын “Ти Ар Эм” компани Туслан гүйцэтгэгч: “Эм Ти Юу” ХХК
Гэрээний нөхцөл, огноо, дугаар:	Түлхүүр гардуулах; 2022.09.07; №2022/455;
Төслөөр гүйцэтгэх ажил:	- Шугам сүлжээ, барилга, байгууламжийн зураг төсөл; - 13.3км цэвэр ус дамжуулах уян ширмэн шугам хоолойг шинэчлэн солих, шинээр барих; - Усны зарцуулалтыг хэмжих ухаалаг системийг байгуулах. (нэгдсэн удирдлагын төв, сервер, программ хангамж, мэдээлэл дамжуулах байгууламж, 15000ш усны тоолуур суурилуулах);

	- Дархан хотын НАА, усны аж ахуйн хүний нөөцийг чадавхжуулах; - Барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээн авах - Төслөөр гүйцэтгэсэн ажлыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх; - Туршилт тохируулга хийх
--	---

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн 2025 оны барилгын ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг ХББОСЯ-ны НААБЗГ, төсөл хэрэгжүүлэх нэгж, ерөнхий гүйцэтгэгч хамтран баталж нэг удаа тодотгон шинэчлэн баталсан байна.

Шинэчлэн тодотгож баталсан барилгын ажлын календарчилсан төлөвлөгөө, төслөөр хэрэгжүүлэх 6 төрлийн ажилбарын хүрээнд төлөвлөсөн зорилт, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2025 оны төлөвлөгөөний биелэлт 68.9 хувь, төслийн хэрэгжилтийн нийт түвшин 80.6 хувь буюу төслийн хэрэгжилтийг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

Хүснэгт-1: Төслийн хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Арга хэмжээний нэр		Нийт хувь
	Ажлын нийт түвшин 2024 онд		66.6
	Ажлын нийт түвшин 2025 онд		80.6
	2025 оны төлөвлөгөөний биелэлт		68.9

Хүснэгт-2: Төслийн үр дүнд хүрэх түвшний хэрэгжилт:

№	Ажил, үйлчилгээ	Эзлэх хувь	Тоо хэмжээ			Хэрэгжилт		
			Нийт төлөвлөсөн	2023-2024 оны гүйцэтгэл	2025 онд төлөвлөсөн	2025 оны гүйцэтгэл	2025 оны хэрэгжилт /хувь/	Нийт төслийн хэрэгжилт /хувь/
1	Усны шугам хоолой өргөтгөх шинэчлэх	50	13.3км	9.4км	3.9км	3.9км	100	100/50
2	Цахим тоолуур	40	15000	4409	10591	5576	52.6	66.6/26.6
3	Чадавхжуулах сургалт	4	2	1	1	1	100	100/4
4	Хүлээн авах комисс	3	2	-	2	2	0	0/0
5	Ашиглагчид хүлээлгэн өгөх	2	1	-	1	0	0	0/0
6	Туршилт тохируулга	1	1 багц	-	Хугацаа болоогүй			0/0
	БҮГД	100					68.9	80.6

Төслийн хүрээнд 2025 онд усны шугам хоолойн угсралтын ажил 100%, ухаалаг тоолуур суурилуулах ажил 10%, ИТА-ыг чадавхжуулах сургалт 100%, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, ашиглагчид хүлээлгэн өгөх ажлууд хийгдээгүй 0% тай, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай” 10 хувьтай нэг арга хэмжээ байна. Үүнд:

1. Төслөөр хийж гүйцэтгэх 15000ш цэвэр усны ухаалаг тоолуурын үлдэгдэл 5000 тоолуурыг төлөвлөсөн бүсүүдэд суурилуулах,

“Үр дүнгүй” төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй 0 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. Төслийн хүрээнд угсралт, суурилууллагдсан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулж, байнгын ашиглалтад оруулах

2. Ашиглалтад оруулсан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг ашиглагч, эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгөх, Төслийн хаалтын тайлан боловсруулах, тайлагнах,

Хугацаа болоогүй 1 арга хэмжээ байгаа нь ухаалаг цахим системийн үйл ажиллагаа, шинээр болон өргөтгөсөн ус хангамжийн шугам сүлжээний туршилт тохируулгын ажил байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтээ жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 90.5 хувьтай үнэлж ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 80.6 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

Төслийг 2025 онд дуусгах төлөвлөгөөтэй байсан боловч III ээлжийн 5000ш цэвэр усны ухаалаг тоолуур (хэмжих хэрэгсэл)-ыг Хэмжил зүйн тухай хуульд зааснаар загварын туршилтад хамруулж, тохирлын гэрчилгээ олгож “хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт” хийх байгууллага 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл тодорхойгүй байжээ.

Төслийн гэрээний хугацаа дуусахаас 1 хоногийн өмнө буюу 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Стандарт хэмжил зүйн газрын даргын А/257 тоот “Хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээ олгох тухай” тушаал гарч төслийн 3 дахь ээлжийн 5000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуурыг Хэмжил зүйн мэдээллийн Улсын нэгдсэн санд бүртгэх, тохирлын гэрчилгээ олгох, баталгаажуулалт хийх боломж бүрджээ. Улмаар хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийгдэж 2025 онд багтаан нийт 500ш тоолуурыг суурилуулсан байна.

Үүнээс шалтгаалан төслийн барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах комисс зохион байгуулж ажиллах, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх ажлууд хийгдэх боломжгүй болж хойшлогдсон байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Бүгд Найрамдах Австри Улсын нөхцөлт зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх “AUS 239 885” төслийн 2025 оны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээгээр дараах зөвлөмжийг Төсөл хэрэгжүүлэх нэгж (А.Пүрэвсүрэн)-д гаргаж байна. Үүнд:

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “ажлын хэсэг байгуулах тухай” 01-А/579 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулж холбогдох байгууллагуудтай хамтран 17 байршилд төслийн хүрээнд өргөтгөл, шинэчлэлт, суурилуулалт хийгдсэн цэвэр усны магистрал шугамыг ашиглалтад оруулах комиссыг ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах, оролцох;

2. Төслийн III ээлжийн ухаалаг тоолуурыг суурилуулах ажлыг хугацаа алдахгүй хийлгэхэд анхаарч гүйцэтгэгч байгууллагыг зөвлөмж чиглэлээр хангах, шаардлагатай байгууламжуудад ашиглалтад оруулах комиссыг эрх бүхий болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

3. Төслийн хүрээнд бий болсон өмч хөрөнгийг шилжүүлэх, ашиглагч, эзэмшигч байгууллагад актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

4. Техникийн болон холбогдох бусад баримт бичгийн бүрдлийг архивын баримт бичгийн стандартад нийцүүлэн бэлтгэн бүрдүүлж улсын архивт хүлээлгэн өгөхөд хяналт тавьж ажиллах;

5. Төслийн эцсийн тайланг гарган тайлагнаж гэрээг дүгнэх.

“НОГООН НУУР 1008 АЙЛЫН ОРОН СУУЦ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026.01.20

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжсэн 1008 айлын орон сууцны хотхон” төслийн хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, яамны удирдлага болон холбогдох газруудыг мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР.ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО: Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1008 айлын орон сууцны хотхоныг барьж ашиглалтад оруулснаар хүн амын орон сууцны хангамж, хүртээмж нэмэгдэж, гэр хорооллын оршин суугчдын ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэж, байгаль орчны бохирдол багасан, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХББОСЯ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн ЗДТГ

Хэрэгжих хугацаа: 2019-2025

Хөрөнгө оруулалтын хэмжээ: Нийт 347,4 сая юань, үүнээс БУА-ын зардал – 336,0 сая юань, Хятадын талын төслийн менежментийн зардал - 11,4 сая юань.

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД:

ЗОРИЛТ-1. “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн барилга угсралтын ажлыг барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, норм нормативын баримт бичиг, батлагдсан зураг төслийн дагуу чанартай гүйцэтгүүлэх;

ЗОРИЛТ-2. Төслийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллах

ЗОРИЛТ-3. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг цаг тухайд нь холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг хангаж ажиллах.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА :

Энэхүү төслийг дараах шийдвэрүүдийг үндэслэн хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичиг;

- Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2016 оны 07 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай” хэлэлцээр;

- Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулагдсан “Солилцох захидал”;

- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Засгийн газар болон Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яамны хооронд 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр байгуулагдсан “УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх протокол”.

Төслийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр УБ хотын Сүхбаатар дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 3,8 га газарт 1008 айлын 8 блок орон сууцны барилгыг авто зогсоол, гадна дотор инженерийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, дэд өртөөний хамт барина.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайд болон БХБСайдын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан 27/30 дугаар тушаалаар, нэгжийн дүрмийг БХБСайдын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 70 дугаар тушаалаар тус тус батлуулан ажиллаж байна.

ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төслийн хэрэгжилтийн түвшин 2025 оны жилийн эцсийн байдлаар 98,8 хувь, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 98.2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

Төслийн хэрэгжилтийн түвшинг харуулбал:

Төслийн хэрэгжилтийн үнэлгээ /хувь/	Хэрэгжилт /хувь/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	2025 оны төлөвлөгөөний биелэлт 98.2%	3	100	100	97
	Төслийн хэрэгжилтийн түвшин - 98.8%				

2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 50 арга хэмжээг дүгнэхэд хэрэгжилт 96.5 хувьтай байна. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт

№	2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн үр дүн	Үнэлгэ
1	2	3	4	5
ЗОРИЛТ 1: “НОГООН НУУР 1008 АЙЛЫН ОРОН СУУЦ” ТӨСЛИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ, БАТЛАГДСАН ЗУРАГ ТӨСЛИЙН ДАГУУ ЧАНАРТАЙ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ;				
1.1	Барилгын ажил гүйцэтгэх 2025 оны календарчилсан төлөвлөгөөг боловсруулах, ХББОСЯ-нд батлуулахаар хүргүүлэх	ШҮ1: төлөвлөгөө	Төслийн 2025 оны барилгын ажлын график төлөвлөгөө ХББОСЯ-ны ББМБЗГ-ын Д.Гантулга даргаар 2025.01.05-нд батлуулсан. График төлөвлөгөөний хүрээнд ажлууд гүйцэтгэгдэж байна. График төлөвлөгөөний дагуу батлуулсан сар сарын төлөвлөгөөг СХОСБЗГ-ын дарга Э.Батболд даргаар батлуулан биелэлтийг 14 хоног тутмаар гаргуулан авч хяналт хийж хуралд танилцуулан ажиллаж байна.	100%
1.2	“Ногоон нуур-1008 орон сууц төсөл”-ийн Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг сунгуулсан байх.	ШҮ1: зөвшөөрөл	Хот байгуулалт, хөгжлийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр 157/2022 дугаартай олгосон “Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ”-ний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон. 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр А/492 дугаартай албан бичгийг хүргүүлж 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааны сунгалт” гэрчилгээг гаргуулж хугацааг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл сунгуулсан. Дээрх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд сунгуулах хүсэлт гаргаж 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр БАЗГ/2025/0566 дугаартай “Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ”-г 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаагаар сунгалт хийлгэсэн.	100%
1.3	Техникийн нөхцөл сунгуулах /Дулаан, ЦБУ, Цахилгаан, Холбоо дохиолол/	ШҮ1: техникийн нөхцөл	1. Холбоо дохиолол: “Мэдээлэл сүлжээ холбоо” ТөХК-ийн 2025 оны 04 сарын 07-ны өдрийн D-U 2025/ 131 тоот Гадна холбооны ажлын техникийн нөхцөлийг сунгуулсан -“Мэдээлэл сүлжээ холбоо” ТөХК-ийн “Гадна холбооны барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл”-ийг 2025.06.04-ний өдөр авсан. 2. Дулааны техникийн нөхцөл: 2025.06.09-нд хугацаа дууссан бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн №11/2025 дугаартай дулаан хангамжийн техникийн нөхцөлийг 2027 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаагаар сунгуулсан. /4.30 Гкал/цаг/ 3. УХАТ: УСУГ-ын техникийн нөхцөл олгох комиссын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн зөвшөөрсөн усны хэрэгцээний 216/22	100%

			дугаартай Техникийн нөхцөлөөр 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 1 жилийн хугацаатай сунгасан хугацаа дууссан тул, 2025.06.05-ны өдөр А/285 тоот бичгээр УСУГ-д сунгуулах хүсэлтээ өгч УСУГ-аас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр №399/25 дугаартай Техникийн нөхцөлийг 2 жилийн хугацаагаар сунгуулсан.	
1.4	Барилгын ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын материалын сорил шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэж зохих дүгнэлтийг гаргуулах.	ШҮ1: дүгнэлт	-2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 тоот албан бичгээр “Онцгой байдлын ерөнхий газар”-ын Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн аюулгүй байдлын үнэлгээний нэгдсэн төвд 8-н блок барилгын ариун цэврийн өрөөний таазанд ашиглах ПВС хавтанг галын лабораторын сорилт хийлгүүлэх хүсэлт өгсний дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12/44 тоот бичгээр сорилтын дүнг ирүүлэв. - Төслийн гадна авто замын ажилд “Босгот өв инженер консалтинг” ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр лабораторын туршилт шинжилгээний ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар барилгын талбайд 6-н удаагийн ирэлтээр авто замын суурийн доод үе болон буталсан чулуун суурийн ажлуудад 15-н шинжилгээ туршилт хийн ажилласан .	100%
1.5	Барилгын ажлын үе шатны ажлуудад хөндлөнгийн хяналтыг бусад холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, тэдгээрийн зөвлөмжийг авах	ШҮ1: зөвлөмж	1. ХББОСЯ-ын Салбарын хяналтын газрын холбогдох улсын байцаагч 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр төслийн талбайд ажиллаж орон сууцны 8-н блок барилгуудын 16-н лифтний угсралттай танилцаж хугацаатай албан даалгаврыг ЕГ-д ирүүлэхээр болсон. Ег албан даалгаврын дагуу ажиллаж, биелэлтийг гаргаж цаг тухайд нь хүргүүлсэн. 2. Холбоо, дохиоллын ажлын зургийн зохиогч “Анод катод” ХХК-ийн холбооны зургийн инженер н.Пүрэвзагд 2025 оны 02 сарын 17-ны өдөр ирж давхрын холбооны самбар руу холбоо, дохиоллын кабелийг оруулах чиглэл, зөвшөөрлийг өгч энэ дагуу ажил хийгдсэн. 3. ХББОСЯ-ын Салбарын улсын ерөнхий байцаагчдын хамтарсан шалгалт 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр төслийн талбайд барилга угсралтын ажилд үзлэг шалгалт хийж, зураг төсөл холбогдох баримт бичигтэй танилцан 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02-00-00/001/81 тоот “Дутагдал арилгах тухай” хугацаатай албан шаардлагыг ирүүлсэн. Албан шаардлагын дагуу илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан хариуг ХББОСЯ-нд хүргүүлсэн.	100%
1.6	Барилгын ажлын үе шатны ажилд зохиогчийн хяналт хийлгэх	ШҮ1: тайлан-8	2025 оны зохиогчийн хяналтын №45/24 тоотоор ирүүлсэн графикийн дагуу үе шатны ажил бүрд зохиогчийн хяналт хийж хамтран ажиллаа. Долоо хоног бүрийн Лхагва гаригт зургийн зохиогч компанийн чиглэлийн найман инженер барилгын талбайд ирж зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан. -Зургийн өөрчлөлттэй холбогдолтой асуудлыг тухай бүрт нь зөвшилцөн ажилласан: Үүнд: ХАС: 1.Барилгын 1-8 блокуудын зоорны давхар, 1 дүгээр давхраас 21 дүгээр давхруудад “АТТАЧР”ХХК , “Сэртэн констракшн”ХХК-уудын хийж байгаа ф25-80мм-н халаалтын ган хоолойнууд, халаах хэрэгслийн угсралт болон ф100-350 мм-н салхивчийн цайрдсан хоолойнуудын угсралтад ЕГ-н сантехникийн хяналтын инженер н.Уул, Э. Бат-Эрдэнэ болон зургийн зохиогч Бат-Өлзийтэй хамтран 16 удаа үзлэг хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд тус угсралтын ажил 100% -тай хийгдсэн.	100%

			2. Төслийн 1-8 дугаар блокуудын агаар сэлгэлтийн системийн блокуудын дээвэр дээрхи агааржуулалтын хоолойнуудын гаргалгаа шахты өрлөгүүд дээрх агаар сорох диффлекторын суурилуулалтад угсралтад ЕГ-н сантехникийн хяналтын инженер н.Уул, Э.Бат-Эрдэнэ болон зургийн зохиогч Бат-Өлзийтэй хамтран 8 удаа үзлэг хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд тус угсралтын ажил 100% -тай хийгдсэн. УХАТ: 3. Зохиогчийн хяналтыг 7 хоног тутамд “Интеллект таур” ХХК-ын ус хангамж, ариутгах татуургын инженер Г.Мөнхзултай хамтран 56 удаагийн хяналтыг гүйцэтгэсэн. Дотор усан хангамж, ариутгах татуургын системийн ажилд холбогдох норм дүрэм, стандартын дагуу хийгдээгүй ажилбар тус бүр дээр илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухай бүрд нь ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн инженерт техникийн ажилчдад мэдэгдэж барилгын тэмдэглэлийн дэвтэрт тогтмол бичилт хийж шаардлагатай зүйлүүд дээр хурал зохион байгуулж ажилласан байна. Шаардлагатай тохиолдолд зургийн зохиогчийн ИТА нар ирж ажиллаж байна. Үүнд, гадна зам талбайн тохижилтын ажилтай холбоотой зургийн тодруулга хийлгүүлэх, ажлын хүрээнд замын трасст байгаа нэгж талбаруудад арга хэмжээ авхуулах талаар НГЗБА, НЗХГазар зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.	
1.7	Төслийн ИТА нарын байрладаг түр байрны барилгын ашиглалтыг зогсоож, буулгаж, холбогдох газарт хүлээлгэн өгсөн байх		Түр байрны Буулгалтын ажлын гүйцэтгэгчээр Канда ХХК шалгарч, 2025/153 тоот гэрээ байгуулан 100% гүйцэтгэн дууссан бөгөөд ТХН-ийн хяналтын доор дараагийн ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн. №1 дугаартай гүйцэтгэл болон захиалагч гүйцэтгэгч, хүлээн авагч талуудын хооронд хүлээлцсэн акт, фото зургийн хамт баталгаажуулсан.	100%
1.8	Барилгын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах.	ШҮ1: Гүйцэтгэл-3	2025 онд: төслийн ажилд 3 удаагийн 75,545,735.6 юанийн үнийн дүнтэй гүйцэтгэл бичиж ирүүлснийг хянаж баталгаажуулсан -2025 оны 4- сарын 15-нд ерөнхий гүйцэтгэгч компаниас БУА-ын 6-р гүйцэтгэлийг төслийн нэгжид хянуулахаар ирүүлсэн. Төслийн нэгж хянан баталгаажуулан ХББОСЯ-нд 4-р сарын 16-ны А/165 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХББОСЯ хянан баталгаажуулан 2025 оны 4-р сарын 21-нд 48,836,239 юанийн үнийн дүн бүхий БУА-ын 6-р гүйцэтгэлийг ХББОСЯ-наас Төслийн менежментийн компанид 3/1397 тоот албан бичгээр хянан баталгаажуулан хүргүүлсэн. -БУА-ын 7 дахь гүйцэтгэлийг хянан баталгаажуулан 2025.09.08 А/443 тоот албан бичгээр ХББОСЯ-нд хүргүүлсэн. Худалдааны яамнаас санхүүжилт 2025.10.22-нд Ерөнхий гүйцэтгэгчийн дансанд шилжсэн.	100%
1.9	Дээвэр, гадна засал, гадна шатны ажил гүйцэтгэх	ШҮ1: Дээвэр, гадна засал, гадна	Туслан гүйцэтгэгч “Канда” ХХК нь нэгдсэн гарааш, 1-8 дугаар блокуудын дээврийн хучлагын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Ерөнхий гүйцэтгэгч “Хятадын хоёр дахь металлурги групп корпораци” ХХК нь орон сууцны 8 блокуудын орцны өмнөх гадна хашлага, хайс, нэгдсэн гараашууд руу гарах, буух гарцын шат, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, хашлаганы	100%

		шатны ажил	ажлуудыг хийж дуусгаж, барилгын ажлуудын ил, далд ажлын актуудыг баталгаажуулсан. Мөн НГ-А,Б гараашуудын гадна хана, налуу замын ханыг будах, блокуудын дээврийн хашлага ханын дотор талын хэсгийг гөлмөн төмрөөр өнгөлөн бэхлэх ажлууд 100% хийгдсэн.	
1.10	Дотор заслын ажил хийх /дотор засал, хана, хамар хана, цонх, хаалга, шалны ажил/	ШҮ1: Дотор засал-50 хувь	Дотор заслын туслан гүйцэтгэгч 1-р багц буюу 1, 2, 3 дугаар блок дээр “Хос Энх хөгжил”, 2-р багц буюу 4-8 дугаар блокууд дээр “Баам Электрик” ХХК ажилласан. Дотор заслын ажил: Дотор заслын ажлууд БНБД-ийн дагуу чанартай хийгдсэн байна. Нэгдсэн гарааш, 1-8 дугаар блок – 100%	100%
1.11	Гадна инженерийн шугам сүлжээний ажлуудыг /холбоо дохиолол/ дуусгах	ШҮ1: Гадна инженерийн шугам сүлжээний ажлууд	Хотхоны гадна холбооны трасс Мэдээлэл холбоо, сүлжээ ТөХК-ийн харьяаны эхнийх нь 36м -ийн урттай, дараагийнх нь 11 м-ийн урттай трассаар дамжин Нэгдсэн гараж Б-гийн баруун хойд булангаар орж ирж холбооны хэвтээ тавиураар дамжин 1-р болон 4-р блокийн харуулын өрөөнд байрлах холбоо, дохиоллын төгсгөлийн төхөөрөмжүүдтэй холбогдох техникийн шаардлагыг бүрэн хангасан ба холбооны шугамын нөөц шугамыг үүсгэх шаардлага гарсан тохиолдолд 1 ба 2-р блокуудын хооронд шинээр хэвтээ тавиур хийж, ханыг цоолж гарц гаргасан 2 ш 100 мм -ийн сувагчлалыг ашиглах боломжтой хийгдэж дууссан.	100%
1.12	Дотор инженерийн шугам сүлжээний ажлуудыг дуусгах	ШҮ1: Дотор инженерийн шугам сүлжээний ажлууд	Холбоо дохиоллын ажлын хүрээнд: Ерөнхий гүйцэтгэгчийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан айлын самбар, давхрын самбар, галын дохиоллын утаа соролт, утаа өгөлт, интернэтийн дотор сүлжээ, чанга яригч, камержуулалтын сувагчлал 100 % дууссан. -Дулаан: ХАС 1.Ерөнхий гүйцэтгэгч компаниас “Магадалшгүй ажлын тухай” 2025 оны №75 тоот ирүүлсэн албан бичигт дурдсан “Нэмэлт өөрчлөлтөөс үүссэн нэмэлт зардал”-ыг шийдвэрлэхэд шаардлагатай 8-н заалт бүхий 2025 оны 03 сарын 11-ний өдрийн №А/89 тоот “Танай 2025 оны №75 тоотын хариу” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлсэн. 2. Барилгын 2-р багцын туслан гүйцэтгэгч “АТТАЧР” ХХК-ийн гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан тус компанийн гүйцэтгэсэн цахилгаан. Халаалт, цэвэр усны шугам хоолойнуудын угсралтын актуудыг баталгаажуулан ирүүлэх талаар 2025 оны 03 сарын 10-ний өдрийн №А/85 тоот “Шаардлага хүргүүлэх тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлсэн. 3.Төслийн 1-8-р блокуудын халаалтын системүүдийн угсралтад хяналт хийхэд зарим өрөөнүүдийн халаах хэрэгслүүдийн холболтыг засварлахаар 2025 оны 02 сарын 05-ний өдрийн №А/50 тоот “Халаах хэрэгслийг засварлах тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлэн тухайн халаах хэрэгслийн холболтыг засварлуулан биелэлтийг хангуулан ажилласан. 4..Төслийн 3,5,6-р блокуудын зоорины давхруудын агааржуулалтын шугам хоолойнууд болон тоноглолуудын угсралтын ажлуудыг яаралтай хийлгүүлэхээр 2025 оны 02 сарын 19-ний өдрийн №А/69 тоот “Агааржуулалтын ажлыг хийх тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан. 5. Төслийн 1-8-р блокуудын халаалтын системүүдийн угсралтын гүйцэтгэл №5 хяналт тавихад санхүүжилт	100%

			авсан боловч өнөөдрийн байдлаар огт болон дутуу хийгдсэн 5-н ажилбарыг хийлгэхээр 2025 оны 04 сарын 07-ний өдрийн №А/145 тоот “ Шаардлага хүргүүлэх тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан бөгөөд 1-8 дугаар блокуудын халаалтын системүүдийн угсралтын ажил 100%-тай байна. 6. Төслийн хэрэгжүүлэх нэгж болон Менежментийн багийн ИТА болон ажилчид 5 дугаар блокийн 2 дугаар давхарт нүүж орохын өмнө тус байранд ИТА нар хамтарсан үзлэг, хяналт хийгээд эрүүл ахуйн хэвийн нөхцөлийг хангуулахаар 2025 оны 04 сарын 21-ний өдрийн №А/172 тоот “ Шаардлага хүргүүлэх тухай” 7-н заалт бүхийн албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан. 7.Төслийн НГ-А.В гаражуудын агаар сэлгэлтийн системийн угсралтын ажлыг эрчимжүүлэхээр 2025 оны 04 сарын 24-ний №А/184 тоот “ Шаардлага хүргүүлэх тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан бөгөөд өнөөдрийн байдлаар НГ-А,В гаражуудын агаар сэлгэлтийн системийн угсралтын ажил 100% -тай хийгдсэн байна. УХАТ: Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам угсралтын ажил батлагдсан зураг төсөл, ажил гүйцэтгэх аргачлал мөн холбогдох норм дүрэм, стандартын дагуу хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгуулж явцын хяналтыг өдөр тутам гүйцэтгэн ажиллаж байна. 1-8 дугаар блок НГ А, Б дотор хэрэгцээний халуун, хүйтэн ус, гал эсэргүүцэх ердийн системийн шугам угсралтын ажил хийгдэн шугам сүлжээг шалгах мөн зэврэлтээс хамгаалах будаг зэргийг хийж гүйцэтгэх ажлууд үргэлжилж байна. НГ А Б гал эсэргүүцэх автомат болон энгийн системийн угсралтын ажил 100% гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 1-8 дугаар блок дотор ариутгах татуургын системийн шугам угсралтын ажил хийгдэн шугам сүлжээг шалгах мөн ариун цэврийн өрөөний тоноглолуудыг суурилуулах ажлууд дээр захиалагч болон зургийн зохиогчоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах хүрээнд давхар тус бүрээр шалган засвар үйлчилгээг гүйцэтгэсэн.	
1.13	Барилгажих талбайн буцаан дүүргэлт, авто зам, гадна тохижилтын ажил	ШҮ1: Барилгажих талбайн буцаан дүүргэлт, авто зам, гадна тохижилтын ажил	Барилгуудын эргэн тойрон дахь буцаан дүүргэлтийн ажил ажлын зургийн түвшин хүртэл, авто замын суурийн доод үеийн нягтаршуулалтын ажил тус тус хийгдсэн. Авто замын суурийн доод үеийн нягтаршуулалтыг хийж нягтыг хөндлөнгийн лабораторийн байгууллагаар сорилт шинжилгээ хийлгүүлсэн.	100%
1.14	Барилга угсралтын ажлын үед хөтлөх, бүрдүүлэх	ШҮ1: АГА ШҮ2: Хянал	ТХН-ийн инженерүүд барилгын дууссан ажлуудын ил, далд ажлын ажлуудыг баталгаажуулан хувийг Ерөнхий гүйцэтгэгчид хүргүүлэн ажиллалаа. ТХН дээр хавтаслан архивын иж бүрдлийг хангуулж ажилласан.	100%

	шаардлагатай холбогдох баримт бичгийн бүрдлийг хангуулж ажиллах	тын хуудас	УХАТ: Дотор усан хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажлын үед хөтлөх, АКТ явцын хяналт, хүлээж авах хяналтын хуудаснуудыг бүрдүүлэн цаасаар болон fail-аар хадгалан ажиллаж байна. Гал эсэргүүцэх ердийн 1-8 дугаар блок 8 хяналтын хуудас, 1 дүгээр блок-9 хяналтын хуудас, 2 дугаар блок-8 хяналтын хуудас, 3 дугаар блок-9 хяналтын хуудас, 4 дүгээр блок-9 хяналтын хуудас, 5 дугаар блок-8 хяналтын хуудас, 6 дугаар блок-7 хяналтын хуудас, 7 дугаар блок-4 хяналтын хуудас, 8 дугаар блок-6 хяналтын хуудаснуудыг баталгаажуулан ажилласан. 1-8 дугаар блок барилгын улаан дэвтэр, ил далд ажлын акт болон хяналтын хуудаснуудаар баталгаажуулан барилгын өдөр тутмын ажилд хяналт тавин ажиллаж, хөтлөлтийн бүрдлийг ханган ажилласан. ХАС: 1. НГ-А,В гаражууд болон 3,6-р блокуудыг дулаанаар хангахаар “УБДС”ТӨХК-тай гэрээ хийгээд зөвшөөрөлгүй 4-н ширхэг блокийг дулаанд холбосон зөрчлийг арилгуулахаар 2025 оны 01 сарын 06-ны №А/05 тоот “ 2025 оны №01 тоотын хариу” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгчид хүргүүлэн биелэлтийг хангуулсан. 2.Төслийн 1-8-р блокуудын халаалтын системүүдийг даралтат хий болон усаар шахаж шалгасан актуудыг ирүүлэх тухай 2025 оны 01 сарын 21-ний өдрийн №А/26 тоот “Халаалтын системийн тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлсэн бөгөөд 24 ширхэг явцын хяналтын хуудас болон акт ирүүлэн биелэлтийг хангуулан ажилласан. 3. Төслийн 1-8-р блокуудын агаар сэлгэлтийн системүүдийн угсралтын шахаж шалгасан актуудыг ирүүлэх тухай албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлсэн бөгөөд 36 ширхэг явцын хяналтын хуудас болон акт ирүүлэн биелэлтийг хангуулан ажилласан. Холбоо дохиолол: Интернэт, галын дохиоллын сувагчлал, тавиур, айлын хайрцаг, босоо шугам, утаа өгөлт, утаа соролт, чанга яригч хийгдэж баталгаажсан.	
1.15	Барилгын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажиллуулах.	ШҮ1: тайлангууд ШҮ1: - Сургалт	- Барилга угсралтын өдөр тутмын ажилд ХАБЭА-г мөрдүүлж ажилласан. - 2025 оны байдлаар ТМК, ТХН, ЕГ болон туслан гүйцэтгэгч нартай хамтран 4 удаагийн ХАБЭА-н хамтарсан шалгалтыг барилгын талбайд хийсэн. -ЕГ-ийн ХАБ-ийн инженер Ван Ши Мин-д 7 хоног тутмын 1 дэх өдрийн хурлаар зааварчилгаа, зөвлөмж өгч байсан. ХАБЭА-ийн тайланг өдөр тутам болон сар, улирлаар хүлээн авч хяналт тавьсан. -Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан бөгөөд, 2025.03.27-нд 16:00 цагт орон даяар явагддаг газар хөдлөлт гамшгаас сэргийлэх сургалтыг төслийн барилгын талбай дээр зохион байгуулсан. Нийт талбайд ажиллаж байсан 265 ажилтан хамрагдсан.	100%
1.16	Барилгын ажлын сар бүрийн төлөвлөгөө гарган	ШҮ1: төлөвлөгөө	Барилгын ажлын 2025 оны календарчилсан төлөвлөгөөтэй уялдуулан сарын төлөвлөгөөг Ерөнхий гүйцэтгэгчээр гаргуулан ТХН-ийн инженерүүд хянаж ХББОСЯ-нд хүргүүлэн Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын Орон	100%

	батлуулах, тайлагнах		сууцжуулалтын хэлтсийн дарга бөгөөд төслийн захирал Э.Батболдоор батлуулан төлөвлөгөөний дагуу ажилласан. Хувийг ХББОСЯ, Менежментийн компани, ЕГ-д тус тус хүргүүлсэн. ТХН, ЕГ-ийн инженерүүд хамтран ажлын 7 хоногийн 2 өдөр барилгын ажлын чанар, явцын талаар хуралдаж, тус төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар санал солилцон дүгнэж ажиллаа. 100%	
1.17	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Комиссийг ажиллуулах		Нэгдсэн гарааш, 1-8 дугаар блокуудын барилгын ажил дууссан. Хийгдэж дууссан 2025.11.14-ний өдөр Техникийн комисс ажиллаж зөвлөмж гаргаж ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн дагуу барилгын зарим ажлуудыг засварлаж 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр ТК ажиллаж ашиглалтад хүлээн авах шийдвэр гарсан бөгөөд, улсын комисс ажиллуулах хүсэлтээ ХББОСЯ-нд хүргүүлсэн.	100%
ЗОРИЛТ-2: ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ.				
2.1	Зөвлөх баг барилгын ажлын шатны ажлуудад зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллана.	ШҮ1: тайлан	1. НГ-А-ийн ашиглалтай дээвэр болон гражийн дээвэрт дээрх авто зогсоол,явган зам,тохижилтын ажлын сууринд зургийн автортай хамтран зөвлөх үйлчилгээ тухай бүрд үзүүлж ажилласан. 2. Төслийн 1-4 болон 7-8 дугаар блокуудын агаар сэлгэлтийн системийн угсралтын ажлын лифтний хонгилын болон нийтийн эзэмшлийн талбайн агаар өгөх хоолойнуудын техникийн давхар дахь хонгилын хананд байрлах 500х800мм болон 500х700 мм-н хэмжээтэй нүхнүүдийг гаргах ажлыг хийгээгүй тул 2025 оны 05 сарын 21-ний өдрийн №А/242 тоот “Агааржуулалтын нүхнүүд гарах тухай” албан бичгийг Ерөнхий гүйцэтгэгч компанид хүргүүлэн зөвлөгөө өгч, биелэлтийг хангуулан ажилласан агаар сэлгэлтийн системийн угсралтын ажил 100% -тай хийгдсэн. 3. Төслийн 1-8 блокуудын 1-21 давхруудад барилгын угсралтын ажлын АГА-г боловсруулж туслан гүйцэтгэгчид “Сэртэн констракшн”ХХК, “АТАЧР” ХХК-иудад өгч, ажил гүйцэтгэх аргачлалын дагуу хийж байгаа ажил үйлчилгээний явцад кабель шугам татах, татсан кабель шугамууд алдагдах гэх мэт ажлууд дээр Ерөнхий гүйцэтгэгчид угсралтад зөвлөх үйлчилгээ, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн. 4. Дотор усан хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажлын явцад Барилгын тухай хууль, холбогдох хууль БНБД, стандартууд, норм нормативын баримт бичгийн бүрдлийг хангах тал дээр өдөр тутам тогтмол зөвлөгөөг өгч ажиллаж байна. Үүнд: Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга БНБД 40-05-16*/20 Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төсөөлөх ба угсрах БГ 40-102-06 Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10 5. Ариун цэврийн өрөөнд ерөнхий гүйцэтгэгч гипсэн тааз хийнэ гэхэд нь дээд айлын цэвэр бохир усны шугам доод айлын таазаар явж байгаа тул засвар үйлчилгээ хийхэд авах зориулалттай дүүжин тааз хийхийг зөвлөсөн. Зөвлөсний дагуу 30х30см хэмжээтэй металл дүүжин тааз хийгдсэн байна. 6. Гадна болон дотор заслын ажлын үе шатны ажлуудад зөвлөх үйлчилгээг тухай бүрд үзүүлэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл болон хяналтын хуудсанд үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан 100% баталгаажуулалт хийн ажилласан.	100%

2.2	Барилгын үйлдвэрлэлийн чанарын хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах	ШҮ1: журам	Хяналтын хуудас: 2025 оны Гадна тохижилтын ажлын хяналтын хуудас /QA-71-04/ боловсруулагдаж ЕГ-д хүлээлгэн өгсөн байна. Зөрчлийн хуудас: 2025 оны барилгын ажлын туршид дараах 24 төрлийн зөрчлийг үүсгэн ЕГ-чид хүлээлгэн өгч, үүссэн зөрчлийг арилган хариу тайланг ирүүлснийг инженерүүд шалган баталгаажуулсныг хүлээн авсан. Үүнд: 1. №1 Дээвэр болон гадна фасадны ажил дээр №1 CF-02-27-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-02-27-04 дугаартай хариу тайланг 2025.06.06-нд ирүүлсэн. 2. 4-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №2 CF-01-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-01-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 3. 5-р блокийн ус хангамж, ариутгах татуургын ажил дээр дээр №3 CF-02-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-02-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 4. 4-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №4 CF-03-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-03-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 5. 5-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №5 CF-04-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-04-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 6. 6-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №6 CF-05-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-05-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 7. 7-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №7 CF-06-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-06-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 8. 8-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №8 CF-07-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-07-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 9. 1-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №9 CF-08-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-08-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 10. 2-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №10 CF-09-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-09-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 11. 3-р блокийн дотор ус хангамж, ариутгах татуургын системийн босоо шахт бүхий бүх нийтийн эзэмшлийн ажил дээр №11 CF-10-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-10-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 12. 6-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №12 CF-11-31-04	100%
-----	--	------------	---	------

			зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-11-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 13. 7-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №13 CF-12-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-12-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 14. 8-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №14 CF-13-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-13-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 15. 3-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №15 CF-14-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-14-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 16. 2-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №16 CF-15-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-15-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 17. 1-р блокийн ус хангамж, ариутгах татуургын системийн угсралтын ажил дээр №17 CF-16-31-04 зөрчлийг үүсгэсэн ба зөрчлийг арилгасан CFR-16-31-04 дугаартай хариу тайланг 2025.08.25-нд ирүүлсэн. 18. 2,4,5,7-р блокийн дотор заслын ажил дээр -№18 CF-03-212-04 зөрчлийг үүсгэсэн. 19. 1-3-р блокуудын агаар сэлгэлтийн системийн угсралтын ажил дээр №19 CF-01-43-04 зөрчлийг үүсгэсэн. 20. 2,5-р блокийн Дээврийн ажил болон гадна фасадны металл рамын ажил дээр №20 CF-03-27-04 зөрчлийг үүсгэсэн. 21. 2,5,7-р блокийн дотор заслын ажил дээр №21 CF-04-212-04 зөрчлийг үүсгэсэн. 22. НГ-А дээвэр дээрх гадна тохижилтын ажил дээр №22 CF-01-71-04 зөрчлийг үүсгэсэн. 23. НГ-В ашиглалттай дээврийн ус зайлуулах ажил дээр №23 CF-02-71-04 зөрчлийг үүсгэсэн. 24. Гадна тохижилтын талбайд №24 CF-03-71-04 зөрчлийг үүсгэсэн. Тайлан: Чанарын хяналтын журмын дагуу барилгын ажлын өдөр тутмын тайланг 2025.01.02-ны өдрөөс авч эхэлсэн. DR-665-04-өөс DR-848-04 хүртэл нийт 184 өдрийн тайлан, ажлын долоо хоног тутмын тайланг 2025.01.02-ны өдрөөс эхлэн WR-091-04-өөс WR-129-04 хүртэл нийт 33 долоо хоногийн тайлан, MR-023-04-өөс MR-030-04 хүртэл нийт 8 удаагийн сарын тайлан ирүүлснийг бүртгэн цаасаар болон файлаар хадгалж архивын нэгж үүсгэж байна. Хурал: ИТА нарын шуурхай хурал 2025.01.03-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн 1 дэх, 5 дахь өдрийн 10:00 цагаас нийт 59 удаа хуралдаж байна. Долоо хоног бүрийн хурал 2025.01.08-ны өдрөөс эхлэн нийт 24 удаа, онцгой хурал 15 удаа болсон байна. Сарын хурал 2025.03.12-нд, 2025.04.09-нд, 2025.05.14-нд нийт 4 удаа болсон байна.	
2.3	Барилгын болон мэргэжлийн чиглэлийн сургалтад Төсөл хэрэгжүүлэх нэгжийн	ШҮ1: Сургалтанд хамрагдсан	- Бүх төрийн байгууллагууд 2025.01.01-ээс Монгол бичгийг албан бичигтээ хослуулан хэрэглэх болсонтой холбогдуулан “Эрдмийн эхлэл гүүр” ТББ-аас “Монгол бичиг”-ийн сургалт авсан. Нийт 2 сарын хугацаанд суурьгүй анхан шат, суурьтай анхан шатны сургалтыг төслийн нэгжийн бүх ажилчдадаа долоо хоног бүрийн лхагва, пүрэв гарагуудад 09:30 цагаас эхлэн 2 цагаар	100%

	ажилтануудыг хамруулах		авах ажлыг зохион байгуулсан ба сургалтдаа амжилттай хамрагдсан байна. -2025.02.24-26-ны өдрүүдэд Архивын Ерөнхий Газраас зохион байгуулсан “Баримт бичгийн стандарт, баримт бичиг зохион бүрдүүлэх арга зүй” сэдэвт 3 өдрийн сургалтад цахимаар хамрагдсан.	
ЗОРИЛТ 3: ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАГ ТУХАЙД НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХҮРЭЭНД ТАСРАЛТГҮЙ ХЭВИЙН ЯВУУЛАХ НӨХЦӨЛИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАХ				
3.1	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, ХББОСЯ-нд батлуулахаар хүргүүлэх	ШҮ1: төлөвлөгөө	2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Төслийн удирдах хороо хуралдсан бөгөөд, 2025.02.28-ний өдрийн 03 тоот ТУХ-ны тогтоол албажин гарч, 2025 оны Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан.	100%
3.2	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан тус бүрийн хийх ажлын төлөвлөгөөг сар, улирал, жилээр гарган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	ШҮ1: төлөвлөгөө ШҮ2: улирлын төлөвлөгөө	ТХН-ийн 16 ажилтнуудын төлөвлөгөөг улирал, хагас жилээр гаргуулан, Төслийн зохицуулагчаар батлуулж, биелэлтийг хянан ажилласан. Сангийн яамны PIMIS системд ажилтнууд 1,2,3-р улирлын төлөвлөгөө биелэлтийг оруулж, илгээсэн байна.	100%
3.3	Сангийн яамны төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан www.odamis.mof.gov.mn сайтад мэдээллийг цаг тухай бүрт оруулж шинэчлэх	ШҮ1: тайлан	1. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ТУХ-ны тогтоолууд, 2. 2025 оны 1-р улирлын батлагдсан төсөв, 2025 оны санхүүжилтийн төлөвлөгөө 3. ТХН-ийн ажилтнуудын батлагдсан гэрээ тус тус ODAMIS мэдээллийн санд оруулсан.	100%
3.4	Харуул хамгаалалтын ажлын явцад байнгын хяналт тавьж, 7 хоног, сар, улиралд тайлан гаргуулж хянаж ажиллах	ШҮ1: тайлан-6	“Харуул хамгаалалтын журам”, болон Шалган нэвтрүүлэх журмуудыг барилгын талбайд мөрдлөг болгон хэвшүүлж ажиллаа. Бумбат зүрх компанийн харуулын өдөр тутмын, 7 хоногийн сарын, улирлын тайланг авч, хянаж зөвлөмж өгч ажиллаа. Март, цэргийн баяр, цагаан сар, гэх мэт нийтээр амрах өдрүүдэд эргүүл шалгалт хийж ажиллаа. Бумбат зүрх ХХК төслийн талбайд нэвтрэх бараа материал, тээврийн хэрэгслийн жагсаалтыг өгч барилгын талбайн дүрэм, харуул хамгаалалтын журам, шалган нэвтрүүлэх журмын дагуу хяналт тавин ажиллаж байна.. Төслийн талбайд ерөнхий гүйцэтгэгчийн ХАБЭА-ийн ажилтантай гэнэтийн шалгалтыг тодорхой хугацааны давтамжтайгаар хянаж, гүйцэтгэгч байгууллагуудын ажилтан алба хаагч нарыг дотогш нэвтрэх үед нь бичиг баримтыг шалган, нүүр таниулах болон үнэмлэх шалгах, мөн алкотест авч нэвтрүүлж ажиллалаа.	100%

			-Ерөнхий гүйцэтгэгчийн ХАБЭА-ын багт хяналт тавьж тайланг өдөр, сар, улирлаар авч хяналт тавьж ажилласан. ХАБАЭ-н зөвлөлийн хурал 7 хоног бүрийн даваа гарагт 14:00 цагаас хуралддаг бөгөөд жилийн байдлаар 22 удаа хуралдаж , төслийн талбайд илэрсэн аюул, үл тохирлыг засаж сайжруулах хэрхэн арга хэмжээг аван ажиллах талаар хэлэлцэн шийдвэрлэж ирсэн. Тухайлбал төслийн хүрээнд "Үйлдвэрийн хурц хордлогыг судлан бүртгэх комисс" байгуулсан. СБД-ийн цагдаагийн 1-р хэлтсийн зөвлөмжийн дагуу ХАБЭА-н хамтран ажиллах тухай гэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажилсан. Барилга угсралтын ажлын явцад тавих хяналтын 3 шатны үзлэг өдөр тутмын шалгалтыг графикайн дагуу хяналт тавин мөрдлөг болгон ажилласан. Төслийн хэрэгжилтийн явцад бүх оролцогч талууд нь Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, норм ба стандартын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн орчныг бүрдүүлж, аливаа осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтвортой хэрэгжүүлж ажилласан. Ажилтан бүр ХАБЭА-н шаардлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэгдүгээрт тавьж, ажлын байрны эрсдэлийг таньж мэдэх, мэдээлэх, арилгах үйл явцад идэвхтэй оролцон, байгууллагын аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан. ХАБЭА-н бодлогын хэрэгжилтийн хүрээнд дараах таван үндсэн чиглэлд төвлөрч ажилласан: 1. Орчин: Барилгын талбайн дотоод зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдал 2. Хүмүүс: Ажиллагсад болон ойролцоох оршин суугчдын аюулгүй байдлыг хангах 3. Тоног төхөөрөмж: Машин механизм, өргөгч төхөөрөмж, цахилгаан тоноглолын аюулгүй ажиллагаа 4. Материал: Барилгын материал, химийн бодисын хадгалалт, шошгололт, хэрэглээний аюулгүй байдал 5. Удирдлагын тогтолцоо: Баримт бичиг, дотоод журам, зөвшөөрөл, тайлангийн бүрдэл Ногоон нуур 1008 айлын орон сууцны төсөл нь Монголд анх удаа ХАБЭА-н аюулгүй ажиллагааг хангаж барилга угсралтын ажлын үед “Па-жиа” барилгын гадна хамгаалалтын шатыг ашиглаж 2023 оны ХББОСЯ-наас тодруулсан аюулгүй ажиллагааг хангасан шилдэг төслөөр шалгарсан. ПАЖИА шат нь барилга угсралтын ажлын үед барилгын гадна хэв хашмалыг угсрахад зориулагдсан ажлын байр болох аюулгүйн шат тавцан юм. ПА ЖИА- (pá jià - 爬架) гэдэг нь авирах гэсэн үгийн үндэстэй хятад үг бөгөөд өгсөх, мөлхөө шат гэсэн утгатай үг юм. Сүүлийн жилүүдэд БНХАУ-д олон давхар, өндөр барилга барихад өргөн ашиглагдаж байгаа бөгөөд нэгэн төрлийн барилга угсралтын хамгаалалтын шинэ шат, тавцан юм. Шинэ гэдгийн утга нь барилга угсралтын ажлын үед барилгын гадна ханын дагуу дээш доош авирдаг, өндрөөс унах аюулаас хамгаалагдсан хаалт хашлагатай, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ажлын тавцан болж чадах, уламжлалт шатны хийцийг ихээхэн өөрчилсөн, шатны иж бүрдэл бүхий барилгын ажлын тавцант тоног	
--	--	--	--	--

			төхөөрөмж гэдгээрээ онцлогтой. Барилга угсралтын өргөх шатыг тодорхой өндөрт босгож, барилгын гадна хананд бэхлэн, өөрийн өргөх төхөөрөмж, тулаас дээр тулгуурлан, инженерийн байгууламжийн тусламжтайгаар дээш өргөх, авирч, уруудах зарчимтай бөгөөд ингэхдээ өндрөөс унах, нурах аюулаас хамгаалагдсан юм.	
3.5	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд улирлын давтамжтайгаар хяналт-шинжилгээ хийж, Сангийн сайдын баталсан “Төслийн хяналт-шинжилгээний тайлангийн загвар” маягтын дагуу хяналт-шинжилгээний тайланг боловсруулан Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд ТУХ-нд хагас жил тутам танилцуулна.	ШҮ1: тайлан мэдээлэл ШҮ2: төлөвлөгөө	1.Төслийн хэрэгжилтэд улирлын давтамжтайгаар хяналт шинжилгээ хийсэн бөгөөд, 2025 нэгдүгээр улирлын ХШҮ хийсэн тайланг ХББОСЯ-нд 2025.04.03-ний өдөр А/141 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2. 2025 хоёрдугаар улирлын ХШҮ-ний тайланг ХББОСЯ-нд 2025.06.06-ний өдөр А/286 тоот албан бичгээр хүргүүлсэн. 3. Сангийн сайдын баталсан Төслийн хяналт-шинжилгээний тайлангийн загвар” маягтын дагуу хяналт-шинжилгээний тайланг боловсруулан ТУХ-н улирал тутам танилцуулж, Удирдлагын мэдээллийн системд оруулсан байна.	100%
3.6	Төслийн явцын үнэлгээг гаргах	ШҮ1: үнэлгээний тайлан	2025.12.05-ны байдлаар барилгын ажил 100%тай, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 96.5% хувьтай байна.	90%
3.7	Барилгажих талбайн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэх /Гадна инженерийн шугам сүлжээ, авто замын трасс, Сургууль цэцэрлэгийн барилгажих талбайн газар чөлөөлөлт-3 айл/	ШҮ1: 56 нэгж талбар	2024 онд “Жагсаалт батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайд /хуучнаар/-ын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 56 дугаар тушаалд БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “1008 айлын орон сууц барих төсөл”-ийн Монголын талын хөрөнгө төсөл, арга хэмжээний жагсаалтад “Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн зардалд 2,8 тэрбум төгрөг тусгагдсан. Төслийн нэгжээс 2024 онд 9 нэгж талбар чөлөөлөхөөр төлөвлөж “Хөрөнгийн үнэлгээний эрх бүхий” “Вендо” ХХК-иар нөхөх олговор олгох хөрөнгийн үнэлгээг 2024 оны 03 сард хийлгэж иргэдэд танилцуулсан. Үнэлгээтэй танилцсан нэгж талбаруудаас СБД, 9-р хороо, Чингэлтэйн 17-117 тоот хаягт байршилтай иргэн Л.Одхүү 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 2024/88 дугаартай гэрээг, СБД, 9-р хороо, Чингэлтэйн 19-456 тоот хаягт байршилтай иргэн Ч.Урантүлхүүр 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 2024/130 дугаартай ХББОСЯ, НОСБГ, ТХН, Иргэн зэрэг 3-н талт гэрээг тус тус байгуулан үнэлгээг зөвшөөрч газраа бүрэн чөлөөлсөн. Үлдсэн иргэд үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй нөхцөл байдал үүсч Төслийн талбайн эргэн тойрны нийслэлээс чөлөөлж буй газар чөлөөлтийн явцтай танилцан Нийслэлийн Засаг дарга,	100%

			холбогдох албаны төлөөлөлтэй явж байх үед Төслийн зохицуулагч Төслийн газар чөлөөлөлтийн талаар мэргэжил арга зүйн дэмжлэг хүсч хүсэлт тавьсан. Тус хүсэлтийн дагуу НГЗБАлбанд холбогдох мэдээллийг хүргүүлж, НГЗБАлбанаас үлдсэн нэгж талбаруудад дахин үнэлгээ хийлгэж 4 нэгж талбар буюу СБД, 9-р хороо Чингэлтэй 19-108а тоот хаягт байршилтай Н.Алтанчулуун, СБД, 9-р хороо Чингэлтэй 19-108б тоот хаягт байршилтай Н.Оюунчулуун, СБД, 9-р хороо Чингэлтэй 18-424 тоот хаягт байршилтай Ц.Шижир, СБД, 9-р хороо Чингэлтэй 19-107 тоот хаягт байршилтай Т.Мөнхцэцэг нар үнэлгээг хүлээн зөвшөөрч газраа чөлөөлөх болсон талаар НГЗБАлбанаас холбогдох материалыг ХББОСЯаманд 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01-10/7568, 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01-10/8311 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн. Төслийн нэгжээс дээрх нэгж талбарын өмчлөгчтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2024/253, 2024/254, 2024/255, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 2024/297 тоот гэрээнүүдийг ХББОСЯ, НОСБН, ТХН, Иргэн зэрэг 3-н талт гэрээг байгуулж баталгаажуулан. Дээрх 4 нэгж талбарын урьдчилгаа 70%-ийн санхүүжилтийг 2024 онд олгож 2025 оны 1, 2 сард 3 нэгж талбарыг нь бүрэн чөлөөлж 100% санхүүжилтийг нь олгосон. 70%-ийн санхүүжилт авсан, үлдсэн 1 нэгж талбар буюу СБД, 9-р хороо Чингэлтэй 19-107 тоот хаягт байршилтай Т.Мөнхцэцэг газраа бүрэн чөлөөлсөн бөгөөд Нийслэлийн Засаг даргын газрын эрх хүчингүй болгох захирамж гаргуулахаар холбогдох материалыг НГЗБА-нд өмчлөгч иргэнээр хүргүүлсэн болно. Газрын эрх хүчингүй болгох захирамж гарсан. Нөхөх олговор 100% олгогдсон. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/556 тоот албан бичгээр ХББОСЯам руу гэрчилгээжүүлэх нэгж талбарын холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Газар чөлөөлөлтийн ажил хууль тогтоомжийн хүрээнд хэвийн үргэлжлэн явагдаж дууссан. 2025 онд газар чөлөөлөлтийн зардалд 837,141,405 төгрөгийн санхүүжилтийг Сангийн сайдын барьцаа дансанд байршуулсан. Дээрх ажлын хүрээнд 3 айлын үлдэгдэл санхүүжилт болох 377,067,900 төгрөг, 1 айлын 70% санхүүжилт болох 293,254,500 төгрөгийн санхүүжилт нийт 2025 оны 3 дугаар сарын 31-ны байдлаар нийт 4 айлын 670,322,400 төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. -СБД, 9-р хороо Чингэлтэй 19-108а тоот хаягт байршилтай Н.Алтанчулуун, -СБД, 9-р хороо Чингэлтэй 19-108б тоот хаягт байршилтай Н.Оюунчулуун, -СБД, 9-р хороо Чингэлтэй 18-424 тоот хаягт байршилтай Ц.Шижир, -СБД, 9-р хороо Чингэлтэй 19-107 тоот хаягт байршилтай Т.Мөнхцэцэг Төслийн нэгжээс 2025 онд газар чөлөөлөлт нэмж хийхгүй болно.	
3.8	ТУХ-г төлөвлөгөөт болон цаг үеийн шаардлагаар хуралдуулахад шаардлагатай холбогдох	ШҮ1: тогтоол -7	2025 онд Төслийн удирдах хороо 3 удаа хуралдсан бөгөөд: 2025.03.13 Төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2025.06.09	100%

	баримт материалыг бэлтгэн ТХБ-д хүргүүлж, тогтоол болон зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.		-Төслийн хугацаа /Төсөл хэрэгжүүлэх протокол, Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа/ сунгуулах; 3. 2025.10.03 -Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчдын Хөлсөөр ажиллах гэрээг сунгуулах -Чанарын баталгаат хугацаанд 3 айлын орон сууцыг ерөнхий гүйцэтгэгчид ашиглуулах тухай; -Төслийн ашиглагч байгууллагыг тогтоолгох тухай хуралдуулж тогтоол шийдвэрүүдийг гаргуулсан.	
3.9	Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу ТХН-ийн бичиг хэргийг явуулах, -бичгийн хэлний түвшинд төслийн нэгжийн баримт бичиг, яриа хэлэлцээрийг орчуулах./Хятад-Монгол/	ШҮ1: албан бичиг, яриа хэлэлцээр, тайлан хурлын тэмдэглэлүүд:	Ирсэн бичиг: 2025 оны 12 сарын 01-ний өдөр хүртэл нийт ирсэн 403 албан бичиг байна. Ирсэн бичгүүдээс ХББОСЯ-аас 32, ерөнхий гүйцэтгэгчээс 246, Төслийн менежментийн компаниас 17, Зургийн зохиогчоос 56, бусад байгууллагаас 49 албан бичиг, иргэнээс 5 өргөдөл тус тус ирсэн байна. Явсан бичиг: 2025 оны 11 сарын 30-ны өдөр хүртэл явуулсан нийт 433-551 албан бичиг байгаагаас барилгын ажилтай холбоотой 196-221, санхүүгийн үйл ажиллагаа тай холбоотой 31, газар чөлөөлөлттэй холбоотой 13, НӨАТ, гаальтай холбоотой 32, ажиллах хүчинтэй холбоотой 116-157, бусад үйл ажиллагаатай холбоотой 45 албан бичиг тус тус явсан байна. Үүнээс ХББОСЯ руу 103, Ерөнхий гүйцэтгэгч рүү 159, төслийн менежментийн компани руу 10-12, зохиогч руу 46, ГИХГ болон ХХҮЕГ руу 151, бусад байгууллага иргэн рүү 78 албан бичиг тус тус явсан байна. -албан бичгийн орчуулга: Төслийн нэгжийн инженер техникийн ажилчид, Ерөнхий гүйцэтгэгчийн инженер техникийн ажилчидтай өдөр бүрийн 7 хоногийн Даваа, Баасан гаригт өглөө бүрийн 10:00-11:00 цагийн шуурхай хуралд ажлын явцын талаар ярилцах орчуулга хятад хэл дээр хийгдсэн. -Барилгын, талбайн инженертэй барилгын талбайд орчуулга хийж ажиллахаас гадна дараах хурал, төсөлд оролцогч талууд төслийн талбайд аман орчуулга -ТХН, ЕГ, Менежментийн хамтарсан хуралд 7 хоног бүрийн 14:00-14:40 цагийн хурал Дээрх хурал уулзалтын хятад хэлний орчуулгыг төрийн албан хэрэг хөтлөлтийн дагуу бичгийн хэлний түвшинд баримт бичиг, яриа хэлэлцээрийн орчуулга хийгдсэн байна.	100%
3.10	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн архивын нэгжийг тухайн онд бүрдүүлэн ажиллах.	ШҮ1: Архивын нэгж	2025 оны ТХН-ийн дотоод захиргаа, санхүү, бичиг хэрэг, ХШҮ, ХАА-ны 105 төрлийн нийт 423 ширхэг хадгаламжийн нэгж материалыг архивлаж, 2025.06.04-нд ХББОСЯ-ны архивт хүлээлгэн актаар хүлээлгэн өгсөн байна. Техникийн комисс, улсын комисст хүлээлгэн өгсний дараа барилгын ажлын архивын материалуудыг ХББОСЯ-нд архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.	100%
3.11	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг төлөвлөн батлуулах, тайлагнах	ШҮ1: төсөв	2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийн саналыг Төслийн нэгжийн ажилтануудаас саналын авч,боловсруулан Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 1 дүгээр сарын 06-ны А/03 тоот албан бичгээр хүргүүлсэн. 1-р улирлын төсөвт 472,888,559 төгрөг батлагдсан. -ТХН-ийн 2-р улирлын төсвийг 2025 оны 04 дүгээр сарын 02 ний өдрийн А/ 138 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100%

			ТХН-ийн 3-р улирлыг төсвийг 2025 оны 06-р сарын 23-ны өдрийн А/319 тоот албан бичгээр хүргүүлсэн -ТХН-ийн 4-р улирлыг төсвийг 2025 оны 09-р сарын 30-ны өдрийн А/484 тоот албан бичгээр хүргүүлсэн. ТХН-ийн 2025 оны улирлын урсгал үйл ажиллагааны зардалд 1,929,963,600 төгрөгийн төсөв батлагдсан байна	
3.12	Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох журмын дагуу өмчлөлийг шийдвэрлэхэд шаардлагатай баримтыг бүрдүүлж ажиллах	ШҮ1: хөрөнг ийн бүртгэл	-ХББОСЯ-нд ашиглалтыг бүртгэж авах талаар 2025.01.09-ны А/08 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХББОСЯ-ны эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэж авсан. Төслийн хүрээнд бий болж буй барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний хөрөнгийн жагсаалтыг гарган 2025.12.04-ны А/557 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн ТХН-ийн ажилчдын ашиглаж буй техник хэрэгсэл, тавилга эд хогшилийн жагсаалтыг гарган хүлээлгэж өгөхөөр 2025.11.04-ны А/534 тоот албан бичгээр хүргүүлсэн.	90%
3.13	2026 оны үйл ажиллагааны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн санал боловсруулж, хүргүүлэх /ТХН нь ТУХ-оор батлагдсан үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн төсөл, арга хэмжээний ирэх жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8.4.2-т заасны дагуу боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх/.	ШҮ1: урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн санал	ТХН-ийн 2026 оны үйл ажиллагааны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн саналыг Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 176-р тогтоол болон холбогдох хууль журмын дагуу боловсруулан.2026 оны улсын төсвийн саналыг Хот байгуулалт,барилга орон сууцжуулалтын яаманд 2025.07.08 өдрийн А/362 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: - Урсгал үйл ажиллагааны зардалд 0.2 тэрбум, - БУА-ын чанарын баталгаа 16,4тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн.	100%
3.14	Үйл ажиллагааны зардлын санхүүгийн тайлан тэнцлийг хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах, аудитын	ШҮ1: тайлан-2 ШҮ2: Аудитын тайлан-1	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж 2025 оны 01 дүгээр сарын 25-ны А/32 тоот албан бичгээр БХБЯ, Сангийн яам А/31, Үндэсний аудитын газарт А/33 тус тус хүргүүлэн, сангийн яамны Э-тайлангийн программд оруулан тайланг илгээсэн. 2024 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас Сангийн яам нь дээр шалгалт хийн зөрчилгүй санал дүгнэлт хүлээн авсан. Аудитын өгсөн албан шаардлагын биелэлтийг 2025 оны 09-р сарын 29-ны А/481 тоот албан бичгээр үндэсний	90%

	дүгнэлт хийлгэн баталгаажуулах		аудитын газарт хүргүүлсэн. Сангийн яамруу цахимаар хүргүүлсэн.	
	Шилэн дансны мэдээллийг сар бүрийн 8-ны өдрөөс өмнө цахим хуудсанд тогтмол оруулах	ШҮ1: мэдээ	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн гүйлгээний болон худалдан авалтын талаарх мэдээллийг сар бүр, тогтмол шилэн дансны мэдээллийн санд сар бүр оруулах нийт 33 мэдээлэл, тухай бүрт оруулах 2 бүлгийн 103 мэдээлэл нийт 136 мэдээллийг хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна. 1,2,3 дугаар улирлын шилэн дансны тайланг хуулийн хугацаанд илгээн ХХБОСЯ-ны шилэн дансны мэргэжилтэнд мэдэгдсэн.	100%
3.16	Татварын болон нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	ШҮ1: Татварын тайлан-2 ШҮ2: нийгмийн даатгалын тайлан-6	1-11 дүгээр сарын ирцийн бүртгэлд үндэслэн 2025 оны 4-р улиралд ТХН-ийн 18 ажилтнуудын цалин хөлсөнд 1,039,421,945.82 төгрөг олгож, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлд 125,686,651.01 төгрөг шилжүүлсэн. 1-11 дүгээр сарын нийгмийн даатгалын тайланг шинэчлэгдсэн https://portal.ndaatgal.mn/#/landing цахим системд ажилчдын мэдээллийг оруулан илгээсэн. 2025 оны татварын 1,2,3 дугаар улирлын тайланг илгээн баталгаажуулсан. Нийгмийн даатгал болон татварын газарт өр болон авлага байхгүй.	100%
3.17	Тухайн жилийн төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянан батлуулахаар хүргүүлэх	ШҮ1: төлөвлөгөө	Сангийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 38 дугаар тушаалаар МТХ хөрөнгөд 9,731,000,000 төгрөг батлагдсан. Үүнээс 2025 онд газар чөлөөлөлтийн зардалд 837,141,405 төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 122,378,000 төгрөгийн санхүүжилтийг тус тус Сангийн сайдын барьцаа дансанд байршуулсан. Дээрх ажлын хүрээнд 3 айлын үлдэгдэл санхүүжилт болох 418,206,405 төгрөг, 1 айлын 100% санхүүжилт болох 418,935,000 төгрөгийн санхүүжилт нийт 2025 оны 9 дугаар сарын 30-ны байдлаар нийт 4 айлын 837,141,405 төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Мөн 2019/216 дугаартай гэрээт ажлын хүрээнд барьцаанд суутгасан 3,952,848 төгрөгийн чанарын баталгааг чөлөөлүүлэх хүсэлтийг ХББОСЯ-ны 2025 оны 02 дугаар сарын 25-ны 03/744 тоот дугаар албан бичгээр, 2021/79 дугаартай гэрээт ажлын барьцаа 5,774,456 төгрөгийг хөрөнгийг чөлөөлүүлэх хүсэлтийг 2025.07.08 А/360 тоот албан бичгээр ХББОСЯ руу хүргүүлэн санхүүжилт шилжсэн.	100%
3.18	Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг хянаж, баталгаажуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэх. Гадаад тусламжийн тооцоог холбогдох яамдтай нийлж баталгаажуулах	ШҮ1: гүйцэтгэл-3 ШҮ2: акт-1	2024 онд нийт 35,382,006,346.17 төгрөгийн буцалтгүй тусламжийн санхүүжилт шилжсэн. Гадаад тусламжийн ашиглалтын тооцоо нийлэн, ХББОСЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газраар хянуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын ахлах мэргэжилтэнтэй тооцоо нийлэн баталгаажуулсан. -ХББОСЯ-нд 2025 оны 01 дүгээр сарын 09-ны А/08 байдлаар 35,382,006,346.17 төгрөгийн ашиглалтыг бүртгэж авах талаар албан бичгээр хүргүүлэн, тусламжийн ашиглалтыг ХББОСЯ бүртгэж авсан. 2025 оны 4- сарын 15 нд ерөнхий гүйцэтгэгч компаниас БУА-ын 6-р гүйцэтгэлийг төслийн нэгжид хянуулахаар ирүүлсэн. Төслийн нэгж хянан баталгаажуулан ХББОСЯ-нд 4-р сарын 16-ны А/165 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХББОСЯ хянан баталгаажуулан 2025 оны 4-р сарын 21нд 48,836,239 юанийн үнийн дүн бүхий БУА-ын 6-р гүйцэтгэлийг ХББОСЯ-наас Төслийн менежментийн компанид 3/1397 тоот албан бичгээр хянан баталгаажуулан хүргүүлсэн.	100%

			-БУА-ын 7 дахь гүйцэтгэлийг хянан баталгаажуулан 2025.09.08 А/443 тоот албан бичгээр ХББОСЯ-нд хүргүүлсэн. Худалдааны яамнаас санхүүжилт 2025.10.22 нд Ерөнхий гүйцэтгэгчийн дансанд шилжсэн. 2025 оны 11 сарын 30 ны байдлаар нийт 258,358,013.60 юань буюу -2022 онд 40,374,443,594.51 төгрөг -2023 онд 8,223,363,452.25 төгрөг -2024 онд 35,382,006,346.17 төгрөг -2025 онд 40,019,121,673.13 Нийт 123,998,935,066.07 төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. 2025 оны 11-р сарын 30-ны байдлаар төслийн тусламжийн ашиглалт 258,358,013.60 юань буюу 79 хувийн ашиглалтай байна. Тусламжийн ашиглалтын хагас жилийн байдлаар тооцоо нийлэн баталгаажуулсан.	
3.19	Төсөлд ажиллах гадаад ажиллах хүчнийг ажлын байрны хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулах, оруулж ирэх, гаргах	ШҮ1: Тогтоол-1 /252 ажилтан/	ЕГ-ээс Төслийн барилгын ажилд ажиллах гадаад ажиллах хүчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлт ирсний дагуу 2025 онд Ажлын байрны төлбөрөөс нийт 372 ажилтныг 100% чөлөөлүүлсэн байна. Үүнд: 1. Монгол улсын ЗГ-ын 2025.01.11-ний өдрийн 31 дүгээр тогтоолд-252 ажилтан 2. Монгол улсын ЗГ-ын 2025.03.26-ний өдрийн 155 дугаар тогтоолд-120 ажилтан Өнөөдрийн байдлаар 372 гадаад ажилчдаас хасалт хийлгэх ажил хийгдэж байгаа бөгөөд 2025.12.05-ны өдрийн байдлаар 37 ажилтан хасалт хийлгэхээр хүлээгдэж байна.	100%
3.20	ТХН-ийн ажилтнуудын "Хөлсөөр ажиллах гэрээ"-г сунгуулах, жилийн эцэст үнэлүүлэх, цахим системд оруулах	ШҮ1: гэрээ - 20 ШҮ2: үнэлгээ -20 мэдээлэл-20	Хөлсөөр ажиллах гэрээ 2025 онд 3 удаа сунгагдсан байна. 1. 2024.12.20-ны өдрийн ТУХ-ын 42 дугаартай зөвлөмжөөр 2025.01.01-2025.07.01 хүртэл 2. 2025.06.19-ний өдрийн ТУХ-ны 13 дугаартай зөвлөмжөөр 2025.07.01-2025.09.30 хүртэл 3. 2025.10.03-ний өдрийн ТУХ-ны 16 дугаартай зөвлөмжөөр 2025.09.30-2025.12.31 хүртэл тус тус сунгагдсан байна. -ТУХ-ны хурлаар үнэлгээ хийлгэхээр хүлээгдэж байна.	90%
3.21	Иргэд ААН, байгууллагаас ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг шийдвэрлэх	ШҮ1: Өргөдөл гомдол	-2025 онд ТХН-д нийт 4 өргөдөл гомдол ирсэн байна. Үүнд: ХББОСЯ-аас 2025.02.26-ны өдрийн 03/766 тоот бичгээр туслан гүйцэтгэгчийн гомдлын асуудлыг шийдвэрлэх тухай албан бичиг ирсний хариуг бэлтгэн зохицуулагчид танилцуулан 2025.03.11-ний өдөр А/88 тоот бичгээр ХББОСЯ-ны ТНБД-н албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү рүү явуулсан. 2025.03.13-нд төслийн Материалын технологийн инженер Ц.Байгалмаа ажлаас гарах өргөдөл өгснийг тухайн өдрийн А/94 тоот бичгээр уламжилж өргөдлийг шийдвэрлүүлсэн. 2025.04.07-нд иргэн Р.Эрдэнэбат-с газар чөлөөлөлтийн гэрээний хугацаа сунгах талаар өргөдөл ирүүлснийг 2025.05.16-нд А/233 тоот бичгээр ХББОСЯ руу уламжилсан. 2025.04.24-нд иргэн Даваа-гаас газар чөлөөлөлтийн гэрээний хугацаа сунгах талаар өргөдөл ирүүлснийг 2025.05.16-нд А/233 тоот бичгээр ХББОСЯ руу уламжилсан.	100%

3.22	ТХН-ийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахаар ХББОСЯ-нд хүргүүлэх, тайланг хагас жилээр гарган хэрэгжилтийг хангаж ажиллах.	ШҮ1: төлөвлөгөө-1 ШҮ2: тайлан-1	2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн ТУХ-ны хурлаар ТХН-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг танилцуулан ТУХ-ын 09 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан. Уг төлөвлөгөөнд дараах 3 төсөл арга хэмжээ тусгагдсан. Үүнд: ➢ "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн барилгажих талбайн харуул хамгаалалтын үйлчилгээ ➢ Буулгалтын ажил /Түр байр/ ➢ Барилгажих талбайн түр КТПН 630кВа буулгах зөөх ажил 1 ажил нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 1 ажил харьцуулалтын аргаар зарлагдах тул www.tender.gov.mn цахим системд төлөвлөгөө үүсгэж, ХББОСЯ-ам руу илгээж төлөвлөгөө батлагдсан. Барилгажих талбайн түр КТПН 630кВа буулгах зөөх ажил нь шууд гэрээний аргаар явах тул төсөл хэрэгжүүлэх нэгж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад яаманд ирүүлэх үүрэг өгөгдөж 100% ажлууд хийгдэж дууссан.	100%
3.23	ИТА 8 блок Барилгын ажил гүйцэтгэсэн архивын нэгж бүрдүүлж, архив хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх	ШҮ1: Архив	ИТА 8 блок Барилгын ажил гүйцэтгэсэн архивын нэгж бүрдүүлж, архив хариуцсан ажилтанд хүлээлгэн өгсөн байна.	100%
3.24	Төсөл арга хэмжээний үр нөлөөг хөндлөнгийн бие даасан мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үнэлгээний тайланг Одамис удирдлагын нэгдсэн системд оруулах.		-ЗГ-ын 2016 оны 176 дугаар журмын 25.2, 25.3-д заасан, Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөл дууссанаас хойш 1 жилийн дотор "Төсөл арга хэмжээний үр нөлөөг" хөндлөнгийн бие даасан мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үнэлгээний тайланг Одамис удирдлагын нэгдсэн системд оруулах -Сангийн сайдын 2021.01.04-ий 4-р журмын 11.17.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөл хэрэгжиж дууссанаас хойш хоёр жилийн дараа төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээ хийж, тайланг цахим системд оруулна... гэж тус тус заасан байна.	100%
3.25	Төслийн эцсийн тайланг гаргаж, Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, мөн БНХАУ-ын Бугат хотын буцалтгүй тусламжийн газарт хүргүүлэх.		ТХН Хаалтын тайлан гаргасан. ТУХ-ны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	90%
3.26	Төслийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах, Төсөл	ШҮ1: дүгнэлт	ҮАГ/АА2025-119 Гэрээ байгуулагдсан "Аккаунт траст Аудит" ХХК 2025 оны ТХН-ийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг хийж байна.	90%

	хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлж, удирдлагын нэгдсэн системд оруулах.			
3.27	Төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлэх	ШҮ1: шийдвэр	Төсөл арга хэмжээний хүрээнд бий болж буй, Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хөрөнгийн жагсаалтыг гарган 2025.12.04-ний А/557 тоот албан бичгээр хүргүүлсэн.	90%
3.28	Төсөл арга хэмжээтэй холбоотой архивын баримт бичгийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын архивт хүлээлгэн өгөх	ШҮ1: Архив	-Төсөл дуусаж байгаа тул 2019-2024 оны архивын 105 төрлийн нийт 423 баримт материалыг бэлтгэн акт үйлдэж, Үүнд: -Захиргаа, гэрээ, эрхзүй - санхүү, ХШҮ, -ХАА-ны баримт -бичиг хэрэг ажилтнуудын архивын материалыг хүлээн авч 2025.06.05-нд ХББОСЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. -Улсын комисс ажилласны дараа 2025 оны баримтыг хүлээлгэн өгнө.	90%
3.29	ТХН-ийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг дүгнэн, дуусгавар болгож, үнэлгээг цахим системд оруулсан байх	ШҮ1: гэрээ - 9 ШҮ2: Үнэлгэ э-9	ТУХ хуралдахаар хүлээгдэж байна.	90%
3.30	2025 онд барилгын ажилд хэрэглэгдэх импортоор орж ирэх, дотоодын зах зээлээс худалдан авах барилгын материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, татан авалтын төлөвлөгөө гаргуулан хянан батлуулж, гааль НӨАТ-аас чөлөөлүүлэх ажлыг зохион байгуулна.	ШҮ1: жагсаалт ШҮ2: төлөвлөгөө	2025 онд импортоор оруулж ирсэн бараа материалын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх 18 удаагийн хүсэлтээр нийт 16,077,705.83 / Арван зургаан сая далан долоон мянга долоон зуун таван юань наян гурван моо/-ийн үнийн дүн бүхий цахилгааны материал, холбоо дохиоллын материал, хаалга, хана шалны плита, гантиг чулуу, обой, паркет, сантехникийн тоноглол, дотор модон хаалга зэрэг бараа материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлсэн байна.	100%
Хэрэгжилтийн дундаж хувь				98.2%

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2025 оны жилийн эцсийн байдлаар төслийн хэрэгжилтийн түвшин 98,8 хувь, төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 98,2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

Төлөвлөгөөнд тусгасан нийт 50 арга хэмжээнээс 100 хувьтай-41 арга хэмжээ, 90 хувьтай-9 арга хэмжээ тус тус байна. Тасарсан арга хэмжээ байхгүй.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төсөл хэрэгжүүлэх нэгж /Д.Од/-д үүрэг болгох нь:

Төслийн 2025 оны төлөвлөгөөнд туссан боловч хэрэгжилт бүрэн дуусаагүй 90%-9 арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгах.

“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026.01.20

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэхэд, энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ “ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” Монгол Улсын засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг баримталсан.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл
Төсөл хэрэгжих хугацаа:	2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр
Захиалагч байгууллага:	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
Гүйцэтгэгч байгууллага:	БНХАУ-ын “Чайна тисижу сивил инженеринг групп” ХХК ба “Бээжин констракшн инженеринг групп” ХХК-уудын хамтарсан консорциум
Зураг төсөл:	БНХАУ-ын Шанхай хотын инженерийн зураг төслийн институт
Хүчин чадал:	250,000 м³/хоног бохир ус цэвэрлэх байгууламж, Бохир усыг МУ-ын Хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх усны стандарт /MNS:4943-2015/-ын шаардлагад нийцүүлэх
Зээлийн эх үүсвэр:	БНХАУ-ын Засгийн газраас 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл
Төслийн нийт өртөг:	262.7 сая ам.доллар
Төслийн санхүүжилт:	Монгол улс: 5% буюу 13.1 сая ам.доллар; БНХАУ: Хөнгөлөлттэй зээл 95% буюу 249.6 сая ам.доллар.
Ажлын ерөнхий тоо хэмжээ:	Үндсэн байгууламж 10
	Туслах байгууламж 23
	Лаг боловсруулах байгууламж 10
	Инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн байгууламж 12
	Нийт 55
Туслан гүйцэтгэгчийн тоо:	Олон улсын 6, дотоодын 20

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотод шинээр баригдах цэвэрлэх байгууламж нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ба хуучин цэвэрлэх байгууламжийн баруун талд био-цөөрмийг шинэчлэхээр төлөвлөсөн талбай дээр 17.6 га газарт баригдаж байна.

Төслийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь хоногт 250,000 м³ ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг Монгол Улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой ба цэвэрлэх байгууламжаас гарах гаргалгааны усыг байгальд нийлүүлэхээс өмнө чанарын шаардлагыг хангуулахын тулд хэт ягаан туяаны UV төхөөрөмжөөр халдваргүйжүүлэгдэнэ. UV систем нь гаргалгааны усыг Туул голд нийлүүлэх, дахин ашиглагдахаас өмнө түүнд агуулагдах колиформ урсцыг нэмэгдүүлэх эх үүсвэр болно.

- Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр баригдана;
- Байгууламжаас гарах лаг багасах бөгөөд гарсан лагийг исгэлтийн аргаар тогтворжуулна;
- Гуравдагч цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт нь бохир усыг дахин ашиглах, Туул голын усны нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Байгууламжаас ялгарах эвгүй үнэр үнэртэхгүй;
- Байгууламжийн ойролцоо амьдарч буй оршин суугчдад дуу чимээ сонсогдохгүй;
- Байгууламжийг бүрэн автоматжуулснаар ашиглалтын зардлыг оновчтой болгож, эрчим хүчний хэрэглээг бууруулна;

- Лагийг мезофил зарчмаар био хий гарган авах технологийг нэвтрүүлэх;

Төв цэвэрлэх байгууламжид лагийн боловсруулалтад дэлхийн тэргүүлэгч технологийг хэрэглэхээр сонгосон. Лагийг мезофил зарчмаар био хий гарган авах замаар эрчим хүч ба дулаан гаргаж авснаар үйлдвэрлэлийн дотоод хэрэгцээний дулааныг ханган цэвэрлэх байгууламжийн ашиглалтын зардлыг нөхөж, цаашлаад эрчим хүч үйлдвэрлэдэг цэвэрлэх байгууламж болох эхлэл тавигдах юм.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлан, мөн журмын 6 дугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ хийх арга зүйн хүрээнд үнэлгээг гаргасан болно.

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл" нь 2025 онд 4 зорилтын хүрээнд 75 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **94.52** хувьтай, **"ҮР ДҮНТЭЙ"** гэж үнэлэв.

Төслийн хүрээнд 2025 онд **75** арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс **100** хувь хэрэгжсэн **65** арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

№	Ажил үйлчилгээ	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь			Биелэлт хувь
				85 хувиас дээш хувь "Бүрэн хангалттай"	70-85 хувь "Хангалттай"	70 хүртэлх хувь "Хангалтгүй"	
1	Нийт арга хэмжээ	4	75	69	1	5	94.52%

Хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр нь хавсралт 1 дүгээр хүснэгтэд тусгав.

Уг төслийн хувьд бүр дуусаагүй тул хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа гэж ангилж дараах зорилт арга хэмжээнүүдийн үнэлгээг бууруулан дүгнэв. Үүнд:

1. 1-р зорилт: Барилга угсралтын ажлын хүрээнд хийгдэх 1.24 Био хий хадгалах сав (DC26) ажлын зорилтод түвшин 100% байхаар төлөвлөгөөндөө тусгасан боловч “Технологийн шалтгаанаар хий гарахад угсарна” гэж биелэлтээ ирүүлснийг барилга угсралтын ажил хийгдээгүй;

2. 4-р зорилт: Дотоод ажлын хүрээнд хийгдэх “4.4 Төслийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хагас, бүтэн жилээр гаргах” арга хэмжээний биелэлтийг хугацаандаа гаргаагүй тул хангалтгүй буюу ирүүлээгүй;

3. 4.6 Шилэн дансны тайлангийн мэдээллийг 2 удаа хугацаа хоцорч мэдээлсэн; /1.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт тайлангуудыг 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдөрт багтаан илгээх байсныг 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хугацаа хоцорч илгээсэн байна/

4. 4.11 Төсөл, хөтөлбөрийн хаалтын төлөвлөгөөг боловсруулах арга хэмжээний биелэлт “Төслийн бүх барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, гадна зам талбай, тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, Улсын комиссТ байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. /2025 оны 09 сарын 29-ны өдөр Техникийн комисс ажиллаж 05/205 дүгнэлтээр хүлээн авсан. Улсын комисс ажиллах бэлтгэл ажил хангагдсан” гэж гарсан тул бүрэн дуусаагүй;

5. 4.12 Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн жагсаалтыг нэгтгэж ХББОСЯ-д хүргүүлэх арга хэмжээний биелэлт “Төслийн бүх барилга байгууламжийн өртгийг төрөлжүүлэн нэгтгэж, ХББОСЯ-д төслийн хөрөнгийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. Өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад хандсан” гэж гарсныг бүрэн хэрэгжээгүй;

6. 4.13 Төслийн хүрээнд ашиглагдсан Монгол талын хөрөнгө оруулалтыг нэгтгэж, төслийн нийт өртгийн бүртгэлд оруулах арга хэмжээ төлөвлөснөөс хөрөнгийн жагсаалт гарган нэгтгэсэн шилжүүлэх ажил ажил хийгдээгүй;

7. 4.17 УСУГ-ын инженер техникийн ажилчдыг чадавхжуулах дотоод сургалт зохион байгуулж хамруулах ажил төлөвлөхдөө тоо мэдээлэл байхгүй, төлөвлөгөөний биелэлт хангалтгүй;

8. 4.18 ХАБЭА-н дотоод болон гадаад ажилтнуудын урьдчилан сэргийлэх сургалтад 100 хувь хамруулахаар төлөвлөсөн боловч биелэлт ирүүлээгүй зэргийг харгалзан үзэж дүгнэв.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн 2025 онд төслийн нийт хэрэгжилтийн түвшин 99 хувь, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94.52 хувь буюу “үр дүнтэй” гэж дүгнэж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

"Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн нэгж /Чулуунбат/-д зөвлөмж болгох нь:

1. Төслийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан “хангалтгүй” буюу 70 %-аас доош үнэлэгдсэн 5 арга хэмжээг 2026 оны төлөвлөгөөндөө тусган бүрэн хэрэгжүүлж ажиллах;

2. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн бүртгэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулан, Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;

3. Био хий хадгалах сав байгуулах барилга угсралтын ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган хангуулах;

4. Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламж ашиглалтад орсны дараа түүний ашиглалтын хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажиллах инженер техникийн ажилтнуудыг төсөл хэрэгжих хугацаанд бэлтгэх, дагалдуулан сургах, давтан сургах сургалтуудыг 2026 оны төсөв, төлөвлөгөөндөө тусган үе шаттай зохион байгуулах;

5. Цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахад хяналт тавих, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, инженер техникийн ажилтнуудыг чадвахжуулах

сургалтад хамруулан ажиллахыг Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар /М.Ням-Очир/-т, Төслийн хүрээнд үүссэн хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ц.Ариунсанаа/-т тус, тус даалгасугай.

**“СОЛОНГО 1 (MON-18), СОЛОНГО 2 (MON-19) ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ
ХОРООЛОЛ БАРИХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026.01.09

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

“Солонго 1 (MON-18), Солонго 2 (MON-19) орлогод нийцсэн орон сууцны хороолол барих” төслийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэхэд энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам”, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

ХОЁР. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Төслийн зорилго:

- Хүн амыг хямд орон сууцаар хангах замаар гэр хорооллыг бууруулж, Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах;
- Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын амьдрах орчныг сайжруулах;
- Төслийн хүрээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудыг ажлын байраар хангахад чиглэнэ.

2. Зээлийн хэмжээ, нөхцөл:

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас олгох зээлийн хэмжээг төслийн техник эдийн засгийн үндэслэл, судалгааны үр дүнд тооцоолон 266,885,535 ам. доллароор тогтоосон байна. Зээлийн нөхцөл: хугацаа - 40 жил, зээлийн хүү - жилийн 0.15 %.

3. Төслийн цар хүрээ, хүчин чадал:

Төлөвлөлт: 5,002 айлын 66 блок 17.19 га талбай /337,186.2 м²/

Солонго 1 – 13.54 га /182,033.6 м²/, Солонго 2 – 3.65 га /155,152.6 м²/ талбайд баригдаж байна.

Нийт санхүүжилт: 266.8 сая ам.доллар

Байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 21-р хороо

Гүйцэтгэгч: “Колон Глобал” корпораци

Солонго 1 – 2,712 айл, 36 блок

Солонго 2 – 2,290 айл, 30 блок

Барилгажих талбай: Нийт 337,186.2 м², Солонго 1 – 182,033.6 м², Солонго 2-155,152.6 м²

Зогсоол – нийт 2,722, ил - 1,133, зоорины давхрын - 1,589

Ногоон байгууламж: 45,060 м²

Барилгын өндөр – 8-9 давхар, 8 давхар – 3 блок, 9 давхар – 63 блок

Өрөөний зохион байгуулалт – 2 өрөө – 41 м², 42 м², 46 м²; нийт 4,195 (84%), 3 өрөө-47 м², 49 м², 52 м²; нийт 807 (16%)



ГУРАВ. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Солонго 1 (MON-18), Солонго 2 (MON-19) орлогод нийцсэн орон сууцны хороолол барих” төсөл нь төлөвлөлтийн дагуу хэрэгжиж байгаа бөгөөд эхний ээлжид 2026 онд ашиглалтад оруулах 2042 айлын 27 блок барилга угсралтын ажил 75 хувьтай хэрэгжиж байгаа талаар төслийн дэлгэрэнгүй тайланд тусгасан байна. Мөн орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт хэрэгжилт 87.5 хувьтай байна.

“Солонго 1 (MON-18), Солонго 2 (MON-19) орлогод нийцсэн орон сууцны хороолол барих” төслийн 2025 оны төлөвлөгөөний 4 зорилт, 23 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төслийн нийт хэрэгжилт 61 хувь, 2025 оны төлөвлөгөөний биелэлт 92.6 хувь, төслийн хэрэгжилтийг “бүрэн хангалттай” гэж үнэлэв. Үүнд:

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Арга хэмжээний нэр	Нийт хувь
	Төслийн хэрэгжилт	61
	2025 оны төлөвлөгөөний биелэлт	92.6

Төслийн нэгж нь 2025 онд 23 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92.6 хувьтай буюу “бүрэн хангалттай” үнэлэв. Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 20 арга хэмжээ, 70-85 хувь хүртэлх 1 арга хэмжээ, 0-70 хүртэлх хувьтай хэрэгжсэн 2 арга хэмжээ байна.

2025 оны төлөвлөгөөний биелэлт

№	Ажил үйлчилгээ	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь			Биелэлт хувь
				85-100	70-85	0-70	
1	Нийт арга хэмжээ	4	23	20	1	2	92.6

Төлөвлөгөөний биелэлтийг арга хэмжээ бүрээр харуулбал:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилт т түвшин	Биелэлт	Хувь
Зорилт 1: Төслийн барилга угсралтын ажлын хүрээнд				
1	“Солонго 2-3” талбайн 3 блок барилгын ажил эхлүүлэхтэй холбоотой төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлэж, ажил эхлүүлэх зөвшөөрөл авах.	3 блок барилгын зөвшөөрөл авч, барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Солонго 2-3 талбайн 3 блок барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл 2025 оны 05 сарын 14-ний өдөр гарсан боловч барилгын талбайн зохион байгуулалттай холбоотой туслан гүйцэтгэгч компаниудын түр байрыг зөвшөөрлөх газар шийдэгдээгүйн улмаас барилга угсралтын ажил хойшилж, 2025 оны 06 сарын 10-нд барилга угсралтын ажил эхэлсэн. Түр байрыг Солонго 2-2 төслийн талбайн урд “ТОСК” ТӨХХК-ийн эзэмшил бүхий 5,4 га газарт 2025 оны V сард байршуулан, барилгын ажлыг эхлүүлэх зохион байгуулалтыг хийж ажилласан. Солонго 2-3 талбайн хойно байрлалтай иргэн Уянгын барилга кадастртай тулгаж барьсантай холбоотойгоор орц гарцын төлөвлөлт өөрчлөгдсөн. Тус асуудлаар Иргэн Уянгатай зөвшилцөж 2 эгнээ авто зам болон авто замын 2 талд явган зам төлөвлөн гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэн ажилласан. Мөн	90

			2-3 талбайн урд талд шинээр гарц нэмж гаргах талаар “Мүүн Си Эм” төлөөний газартай зөвшилцөж санал өгч, “Интеллект Тауэр” ХХК-руу тухайн хүсэлтийг илгээн, зөвшөөрөл авч ажилласан. Тус ажил нь нийслэлтэй зөвшилцөх зураг, төсөл боловсруулах хэрэгжилтийн шатанд байна. Энэ өөрчлөлтийг хэрэгжүүлснээр 45 авто машины ил зогсоол төлөвлөснөөс 58 болгон, шинэчлэн төвлөх саналыг хүргүүлсэн. Солонго 1,2 төслийн талбайн газар шорооны ажил гүйцэтгэх явцад аж ахуй нэгж газруудын одоо ашиглагдаж байгаа цахилгаан, холбоо, дулаан, цэвэр бохир ус хангамжийн шугам сүлжээний трасс давхцах гэмтэл учруулах зэрэг эрсдэл үүссэн тул Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран ажиллах хүсэлт илгээж шийдвэрлэсэн байна. Тус талбайн барилгын ажлыг чанартай гүйцэтгэлтэй хийхэд төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерүүд чанарын хяналт тавьж 3 төрлийн хяналтын хуудсаар 4 талбайн даалгавраар үүрэг даалгавар өгч, 4 удаагийн албан бичгийг холбогдох байгууллагууд руу илгээж барилгын зураг төсөл зохиогч, ерөнхий гүйцэтгэгч, зөвлөх байгууллага, ХББОСЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан. Солонго 2-3 талбайн 2 блок барилга 4 давхар, 1 блок барилга зоорины давхрын ажил хийгдэж байна.	
2	Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар ээлжийн 31 блок барилга угсралтын ажлын гүйцэтгэлд захиалагчийн техникийн хяналт тавих.	2 дугаар ээлжийн 31 блок барилгын угсралтын ажлын 60%-д хүргэх	Батлагдсан төлөвлөгөөний дагуу 31 блок барилга угсралтын ажил 67,5%-ийн гүйцэтгэлтэй, үлдсэн 33%-ийн ажил нь барилгын сууриас 5-р давхар хүртэл каркас угсралтуудын ажил гүйцэтгэж байна. Солонго 1,2 төслийн зүүн талд байрлах 1200 хүүхдийн 163-р сургууль, 240 хүүхдийн 290-р цэцэрлэгийн зөөврийн бохир усны илүүдэл зайлуулах худаг барилгын голд байрлаж, сургууль, цэцэрлэгийн бохирын худагас бохир ус барилгын суурь руу хальдаг асуудлыг шийдвэрлэж үндсэн бохирын худагт холбох асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Солонго 1 төслийн талбайн барилга угсралтын ажлыг хэвийн төлөвлөлтийн дагуу үргэлжлүүлэхэд барилгын ухлагын шороон овоолго саад учруулж байсныг түргэн шуурхай чөлөөлж барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх нөхцөлийг хангаж ажилласан. Нийслэл Улаанбаатар хотын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, Нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний чиг хандлага-2030-д тус тус заасны дагуу Солонго 1,2 төслийн баруун талд 6 эгнээ авто зам төлөвлөсөн боловч Зэвсэгт хүчний 303-р цэргийн анги, Үндэсний аюулгүй байдлын газар, Иргэний нисэхийн ерөнхий газруудтай кадастрын маргаан гарч төслийн 207 автомашины ил зогсоол, сагсны талбай, 2 дэд өртөө, үерийн далангийн 2 гүүрэн гарц зэргийн төлөвлөлтөд өөрчлөлт орох эрсдэл үүссэн тул тус газруудтай уулзалт хийн урьдчилсан байдлаар зөвшилцөлд хүрч зураг төсөлд заасны дагуу тус ажлуудыг хэвийн үргэлжлүүлэх нөхцөлийг хангуулан ажилласан. Эхний ээлжийн 35 блок барилгын талбайн барилгын ажлыг чанартай гүйцэтгэлтэй хийхэд төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерүүд чанарын хяналт тавьж 3 төрлийн хяналтын хуудсаар 58 үл тохирол, 69 зөрчил, 95 талбайн даалгавар, 407 албан бичиг зэрэг техникийн тодруулгуудыг өгч илгээж барилгын зураг төсөл зохиогч, ерөнхий гүйцэтгэгч, зөвлөх байгууллага, ХББОСЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилласан.	100

3	Улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж буй инженерийн дэд бүтцийн угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх	Төслийн гадна инженерийн дэд бүтцийн угсралтын ажил 85%-д хүргэх	Улсын төсвийн хөрөнгөөр Солонго-1,2 орон сууцны хорооллын дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын гүйцэтгэгч “Эс энд Эй трейд” ХХК нь 2024 онд 47.21 хувьтай гүйцэтгэж 2025 оны 04 сарын 25-ны өдрийн гэрээ сунгалтаар инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэн өнөөдрийн байдлаар 87,5% -ийн гүйцэтгэлтэй ажил үргэлжилж байна. Гадна цахилгаан хангамж, холбооны шугам угсралтын ажил Улсын төсвийн хөрөнгөөр Солонго-1,2 орон сууцны хорооллын ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖ ГАДНА ХОЛБООНЫ (эхний ээлж) ажлын гүйцэтгэгч “Саруул Өргөө Констракшн” ХХК 2024 онд 53.51 хувьтай гүйцэтгэж, 2025 оны 5 дугаар сарын 5-ны өдөр ГИШС эхлүүлж гэрээ сунгалтаар өнөөдрийн байдлаар 99 хувьтай үргэлжилж байна. Сунгасан техникийн нөхцөлд “МХС” ХХК-ний эхлэл болон төгсгөлийн худгийн дугаар өөрчлөгдөж, зарим худгуудын хооронд өргөтгөл хийх шаардлага үүссэн тул уг өөрчлөлтийг зураг төслийн зохиогч “Ялгуун баян” ХХК-тай зөвшилцөн гүйцэтгэлийн зургаар баталгаажуулахаар тохиролцон шийдвэрлэсэн байна. Тус талбайн барилгын ажлыг чанартай гүйцэтгэлтэй хийхэд төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерүүд чанарын хяналт тавьж 3 төрлийн хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг үл тохирол, зөрчлийн хуудас талбайн даалгавраар үүрэг даалгавар өгч, барилгын зураг төсөл зохиогч, ерөнхий гүйцэтгэгч, компани, зөвлөх байгууллага, ХББОСЯ болон бусад холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлж, хамтран ажилласан.	90
4	Төслийн эхний ээлжийн 980 айлын орон сууцны барилгыг улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангах	980 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг 100% хангах	Төслийн батлагдсан 41 сарын барилга угсралтын төлөвлөгөөний дагуу 2024 онд барилга угсралтын ажил 25.06 хувьтай, 2025 оны 12 сарын байдлаар 61%-тай үргэлжилж байна. 2025 оны 12 сард 980 айл ашиглалтад орохоор төлөвлөсөн боловч ерөнхий гүйцэтгэгч компанийн барилгын талбайн буруу зохион байгуулалтын улмаас хойшилсон. Иймд төлөвлөгөөнд өөрчлөлт орж 2026 оны VII сард 2042 айлын 27 блок орон сууц ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж, өнөөдрийн байдлаар барилгын ажлын явц 75.14%-ийн гүйцэтгэлтэй байна. Төслийн техникийн бичиг баримт болох Төслийн гарын авлагад заасны дагуу загварын байрыг захиалагч, зөвлөх байгууллага, ерөнхий гүйцэтгэгч нар зөвшилцөн баталгаажуулсан заслын материалуудыг ашиглан Солонго 2-2 төслийн талбайд 42м2 бүхий 2 өрөө байранд зураг, төсөлд заасны дагуу дотор интерьерийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Төсөлд төлөвлөгөөний дагуу хяналт тавьж, шаардлагатай зөвлөмж, үүрэг даалгавар, албан бичгүүдийг хугацаанд нь хүргүүлж ажилласан байна.	70
5	Эхний ээлжийн 980 айлын орон сууцны барилгын гадна зам талбай, тохижилт, инженерийн дэд бүтцийн	Тохижилтын ажил, гадна зам талбай, инженерийн дэд бүтцийн ажлыг 100%-д хүргэх	Гадна зам талбайн ажил 80 хувь, тохижилтын ажил 20 хувь, инженерийн дэд бүтцийн ажил 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Эхний ээлжинд ашиглалтад орох 2042 айлын 27 блок барилгын гадна, дотор заслын ажил, гадна болон дотор инженерийн шугам сүлжээ, зам талбайн тохижилтын ажлуудад захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх явцад тендерийн үе шатанд боловсруулагдсан “SAMOO” түншлэлийн зураг төсөлд “Солонго-1, 2” төслийн авто замын борооны ус	90

	ажилд хяналт тавих		зайлуулах системийн ажил тусгагдаагүй зөрчил илэрсэн. Уг асуудлаар тендерийн шатанд тодруулга авсан бөгөөд тухайн ажлыг “ТОСК” ТӨХХК хариуцах тухай албан ёсны хариу ирүүлсэн. Үүний дагуу зураг төслийн байгууллагуудын харилцан зөвшилцлийн үндсэн дээр “Инж байгууламж” ХХК авто замын борооны ус зайлуулах системийн ажлын иж бүрэн зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийлгэж батлуулах ажлыг үнэ төлбөргүй гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Захиалагчийн техникийн хяналтын гэрээнд заасны дагуу “ТОСК” ТӨХХК нь “Зураг төсөл, төсвийн иж бүрдлийг хангуулах” саналаа 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Мөн “Колон Глобал” корпорациас авто зам, талбайн борооны ус зайлуулах системийн ажлыг 4.1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэх санал ирүүлсэн. Одоогийн байдлаар “Инж байгууламж” ХХК-ийн боловсруулж буй зураг төсөл, төсөв 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн төслийн орц, гарцын авто замын асуудлаар нийслэлийн удирдлага, холбогдох байгууллагуудтай зөвшилцөж, зарим авто замын зургийн даалгаврыг нийслэлээс гаргуулан, бусад замуудын зураг төсөв, санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	
6	“Солонго-1, 2” төслийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах.	35 ширхэг техникийн баримт бичгийн бүрдэл хангагдах	2025 онд 2 Цахилгаан хангамж, 1 Гадна холбооны техникийн нөхцөл шинээр, 2 гадна холбооны, 2 Дулааны техникийн нөхцөлүүдийг тус тус сунгуулж ажилласан байна. Солонго 2-3” талбайн 3 блокийн, “Солонго-1, 2” төслийн гадна шугам сүлжээний ажил эхлүүлэх зөвшөөрлүүдийг тус тус батлуулан барилга угсралтын ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Захиалагчийн техникийн хяналтын гэрээний дагуу Монгол улсын стандарт, БНБД-ийг мөрдүүлэх мөн үйлдвэрлэл, барилгын ажлын явцад (талбайд болон нийлүүлэгч байгууллага) материал, хийцийг шалгах, хэмжих, турших, үйлдвэрлэлийн материалын явцыг шалгах эрхийн хүрээнд 60 технологийн карт, 66 үе шатны ажил шалгах хяналтын хуудас, 60 ажил эхлүүлэх зөвшөөрөл тус тус боловсруулж мөрдөж ажилласан. Барилга угсралтын явцыг хянаж баримтжуулах хүрээнд төслийн нэгж 3 төрлийн хяналтын хуудсаар нийт 58 үл тохирол, 69 зөрчил, 95 талбайн даалгавар болон техникийн тодруулгын хуудсаар үүрэг даалгавар өгч, хариу мэдэгдэх хуудсаар илэрсэн зөрчил дутагдлыг засварлуулан ажилласан. Төслийн хэмжээнд дагаж мөрдөх гэрээнүүдэд заасны дагуу Монгол талын хариуцан гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд техникийн нөхцөл авах, холбогдох зөвшөөрлүүдийг батлуулах, Монгол Улсад мөрдөгдөж буй норм, дүрэм, стандартын шаардлагыг бүрэн ханган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.	100

7	ХАБЭА ажлын хүрээнд Менежментийн тогтолцоо, Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж, сургалт зохион байгуулах	18 ширхэг баримт бичгийн бүрдэл хангагдах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон “Үйлдвэрийн осол, хурц хордлогын судлан бүртгэх, тогтоох, дүгнэлт гаргах орон тооны бус байнгын комисс байгуулах тухай” А/114 дугаартай захирлын тушаал “Солонго-1, 2” төслийн талбайд мөрдөх ХАБЭА-н журам холбогдох норм, стандартыг мөрдлөг болгон ажилласан. ХАБЭА-н зөвлөлийн хурал 7 хоног бүр 2025 онд нийт 160-н удаа хуралдаж, төслийн талбайд учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллаа. Барилгуудын хаалт хашилт хамгаалах ажиллагаа, хүйтний нөхцөлд бетон цутгалтын үед галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгч хяналт тавин ажилласан. Барилгын талбайд нийт ажил гүйцэтгэж буй 211 туслан гүйцэтгэгч компани, ерөнхий гүйцэтгэгч, зөвлөх байгууллага, төслийн нэгжүүдийн 500-1400 ажилчдад ажил гүйцэтгэхэд шаардлагатай хувийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, эрсдэлийг тооцоолж давтан зааварчилгааг тогтмол өгөхийг анхааруулж, ажилласан. Төслийн хүрээнд ХУД-ийн 21-р хороотой хамтран үерийн далангийн хог хаягдлыг зайлуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Уг ажлын хүрээнд 3 дахь шатны үзлэг шалгалтыг 1558 удаа явуулж нийт 7 н үл тохирол болон 4 зөрчил 12 талбайн даалгавар боловсруулан үүрэг даалгавар өгч, хариу арга хэмжээ авхуулж ажилласан.	100
Зорилт 2: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд				
8	Төслийн ерөнхий гүйцэтгэгч Колон глобал корпораци компанийн ажлын тайлан, гүйцэтгэлийн нэхэмжлэхийг хянаж, хүсэлтийг эрх бүхий байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх	Ирүүлсэн 5,6,7,8,9 дүгээр гүйцэтгэлийг хянаж баталгаа жуулах	Төслийн ерөнхий гүйцэтгэгч “Колон глобал” Корпорацийн барилга угсралтын 41 сарын хугацаанд 21 удаагийн гүйцэтгэл авахаас 2025 онд 5, 6, 7, 8, 9-р гүйцэтгэлийн 31,680,000.0 долларын санхүүжилтийн хүсэлт, нэхэмжлэх ирүүлснийг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс гэрээний дагуу хянаж баталгаажуулан, 9 удаагийн албан бичгээр Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Үүнээс: Сангийн яам болон Эксим банк баталгаажуулснаар 23,454,000 доллар буюу 76,785,941,587.20 төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг www.odamis.mof.gov.mn системээр илгээж, шийдвэрлэсэн. Үлдэгдэл 8, 9-р гүйцэтгэлийн төлбөр 8,226,000 долларын нэхэмжлэх нь Монгол Улсын гадаад зээл, өрийн бодлоготой уялдан Сангийн яам баталгаажуулаагүй тул хүлээгдэж байна. 10 дугаар гүйцэтгэл төслийн нэгж дээр хянагдаж байна.	100
9	Төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх Мүүн Си Эм төлөөний газрын ажлын тайлан, гүйцэтгэлийн нэхэмжлэхийг хянаж, ирүүлсэн хүсэлтийг эрх бүхий байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх	Ирүүлсэн 4,5,6,7 дугаар гүйцэтгэлийг хянаж баталгаа жуулах	Зөвлөх үйлчилгээний 41 сарын хугацаанд 3-р үе шатны 4, 5, 6, 7, 8, 9-р гүйцэтгэлийн 2,194,476 долларын санхүүжилтийн хүсэлт, төлбөрийн нэхэмжлэх ирүүлснийг төслийн нэгжийн зүгээс гэрээний дагуу баталгаажуулж, 4 удаагийн албан бичгээр Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Сангийн яам болон Эксим банк баталгаажуулснаар 2,194,476 доллар буюу 6,353,605,719.60 төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг www.odamis.mof.gov.mn системээр илгээж, шийдвэрлэсэн.	100

	х ажилд дэмжлэг үзүүлэх			
Зорилт 3: Төслийн дотоод зохион байгуулалтын ажлын хүрээнд				
10	Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэх төлөвлөгөө батлуулах, биелэлтийг тайлагнах, тулгамдаж буй асуудлыг тухай бүр илтгэж, холбогдох шийдвэрийг гаргуулах	Төслийн удирдах хороог 3 удаа хуралдуулсан байх	Төслийн удирдах хороо 2025 онд зохион байгуулсан гурван удаагийн хурлаар төслийн төлөвлөлт, санхүүжилт, гэрээний удирдлага болон үнийн өсөлтийн зохицуулалттай холбоотой үндсэн чиглэлийн асуудлуудыг цаг тухайд нь хэлэлцэж шийдвэрлэсэн. 2025 оны 10 дугаар сарын 06-ны хурлаар тусгайлсан зээлийн хэлэлцээрийн хугацааг нийт 41 сараар сунгуулах асуудлыг хэлэлцэж, Сангийн яам болон БНСУ-ын Экспорт-Импортын банканд зөвлөмж хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Мөн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй гадна инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч хоёр байгууллагын гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл сунгаж, зөвлөх байгууллагад үнийн өсөлтийн эх үүсвэрийг тооцох аргачлал боловсруулах чиглэл өгч шийдвэрлэсэн байна. Нийт 2025 онд гурван удаагийн хурлаар есөн асуудлыг хэлэлцсэн байна.	100
11	Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх инженерүүдийг ажилд авах	Төслийн хяналтын инженерэ эр 13 хүн ажилд авсан байх	Гүйцэтгэх захирлын 2025 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн А/23 дугаар тушаалаар Солонго төслийн нэгжид Инженер техникийн болон захиргааны нийт 26 ажилтан, албан хаагчдыг сонгон шалгаруулан авч төслийн нэгжийн өдөр тутмын ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөлийг ханган ажиллаж байна.	100
12	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж холбогдох тендер шалгаруулалтыг гүйцэтгэх, гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлийг хангуулах, дүгнэх, холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллах	ШҮ-1 холбогдох хууль, журмын хүрээнд 11 тоног төхөөрөмж авсан байх ШҮ-2 холбогдох хууль, журмын хүрээнд 20 хүний ХАБЭА-н хувцас авсан байх	Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үзэхэд анх нийт 804.3 сая төгрөгийн өртөг бүхий 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тайлант үеийн байдлаар 358.8 сая төгрөгийн өртөгтэй 11 арга хэмжээг зохион байгуулж, тэдгээрээс 168.9 сая төгрөгийн 9 худалдан авалт амжилттай хийгдсэн, харин 2 худалдан авалт амжилтгүй болсон байна. "ТОСК" ТӨХХК нь "Эрчист Монгол" ХХК-ийн харьяанд шилжсэнтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар шийдвэрээр 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголоор төсөв танаж 476,022,900 төгрөг болж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө шинэчлэгдэж 476.0 сая төгрөгийн өртөгтэй 17 арга хэмжээ батлагдсан бөгөөд үүнээс 346.9 сая төгрөгийн өртөг бүхий 13 тендерийг зохион байгуулсан байна. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн худалдан авалт хийгдээгүй байна.	50
13	Төслийн хүрээнд БНСУ-с ирж ажиллах гадаад иргэдийн виз, оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Төслийн хүрээнд 18 хүний хөдөлмөр эрхлэх, Монгол улсад оршин суух зөвшөөрлийг шийдвэрлэсэн байх.	Монгол Улсын Засгийн газрын 2025.01.2-ны өдрийн Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 31 дүгээр тогтоол батлагдсан бөгөөд Солонго 1,2 төсөлд ажиллах 18 иргэний Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Төслийн хүрээнд БНСУ-с ирж ажиллах гадаад иргэдийн виз, оршин суух зөвшөөрөлтэй үйл ажиллагааг зохицуулахад захиргааны туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 2025 онд Ерөнхий гүйцэтгэгч "Колон Глобал" Корпорацийн БНСУ-н 8 иргэн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх "Саму Жи Ви" түншлэлийн Мүүён Си Эм төлөөний газрын БНСУ-н 14 иргэний "Хөдөлмөр эрхлэх урьдчилсан зөвшөөрөл хүсэх тухай" 8 удаа, ажиллах хүчний виз 4 удаа, оршин суух зөвшөөрөл 9	100

			удаагийн албан бичгээр тус тус холбогдох газруудад хүргүүлж, шийдвэрлэсэн байна.	
14	Монголын талын 9-н аж ахуй нэгжийн гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх.	Гадаадаас худалдан авах бараа материалын татварын хөнгөлөлт авах кодыг 9 ААН-дээр авахад дэмжлэг үзүүлэн ажиллах	Ерөнхий гүйцэтгэгч “Колон Глобал” корпорациас 2024–2025 онд импортоор худалдан авах бараа, материалын жагсаалтыг Солонго-1 төсөлд 1,347, Солонго-2 төсөлд 1,336 нэр төрөл бүхий байдлаар боловсруулан ирүүлснийг холбогдох баримт бичгийн дагуу хянан баталгаажуулж, 2025 оны 4 дүгээр сард ХББОСЯ-д хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд нийт 58 хүсэлтийг Сангийн яамны ODAMIS системд шивж, холбогдох төрийн захиргааны байгууллагуудаар дамжуулан хянуулж шийдвэрлүүлсэн байна. Мөн төслийн туслан гүйцэтгэгч есөн байгууллагаас 2025 онд дотоодын зах зээлээс худалдан авах бараа материал, ажил үйлчилгээний жагсаалтыг 2025 оны 11 дүгээр сарын 18-нд ирүүлсэн бөгөөд уг жагсаалтыг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний 1/1231 тоот албан бичгээр ХББОСЯ-д уламжилж хүргүүлсэн байна.	100
15	Төслийн ерөнхий гүйцэтгэгч “Колон глобал” корпорацийн ажил үйлчилгээний НӨАТ-аас чөлөөлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх.	Төслийн хүрээнд хийгдэх 4 төрлийн ажилд татварын хөнгөлөлт авахад дэмжлэг үзүүлсэн байх	Төслийн хүрээнд хэрэгжих ажил, үйлчилгээнд татварын хөнгөлөлт авах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлт, зөвшөөрлийн процессыг зохион байгуулж, холбогдох байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцоо, баталгаажуулалтын үйл явцыг тогтмол дэмжин ажилласан байна. Ерөнхий гүйцэтгэгч “Колон Глобал” корпорациас ирүүлсэн 2025 онд дотоодын зах зээлээс худалдан авах ажил, үйлчилгээний жагсаалт, үнийн дүн, гэрээний мэдээллийг хянан баталгаажуулж, Сангийн яамны ODAMIS системд нэвтрүүлэхэд шаардсан засварыг тодорхойлуулан төсөл тус бүрээр (Солонго-1, Солонго-2) нарийвчилсан байдлаар засварлуулж дахин баталгаажуулан ХББОСЯ-аар батлуулсан.	100
16	Төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх “Мүүён Си Эм” төлөөний газрын НӨАТ-аас чөлөөлүүлэх зөвшөөрөл авах ажилд дэмжлэг үзүүлэх.	Зөвлөх үйлчилгээний гэрээний хүрээнд ажил үйлчилгээний 1 код авахад дэмжлэг үзүүлсэн байх	Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Мүүён Си Эм” төлөөний газрын 2025 онд дотоодын зах зээлээс худалдан авах ажил, үйлчилгээний жагсаалтыг дахин засварлаж ирүүлснийг 2025 оны 11 сарын 04-ний өдрийн 1/1158, 1/1159 дугаартай албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хянан баталгаажуулан хүргүүлэн сангийн яам руу илгээж хянуулах шатанд явагдаж байна.	90
17	Зээлийн болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн явц, хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан мэдээ мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл,	Төслийн хүрээнд холбогдох мэдээллийг 22 удаа цахимд оруулсан байх	Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Мүүён Си Эм” төлөөний газраас 2025 онд дотоодын зах зээлээс худалдан авах ажил, үйлчилгээний жагсаалтыг албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хянан баталгаажуулж хүргүүлсэн. Мөн төсөл хэрэгжүүлэгч “Колон Глобал” корпорациас 5, 6, 7-р гүйцэтгэл, “Самуу” түншлэлийн 4-9-р гүйцэтгэл нийт 18 удаагийн санхүүжилтийн хүсэлт, зээлийн тусгайлсан хэлэлцээр сунгалт, төслийн удирдах хорооны зөвлөмж, тогтоол, мөн туслан гүйцэтгэгч 9 компанийн 2025 онд импортоор худалдан авах бараа материалын батлагдсан 2 жагсаалт зэрэг 24 мэдээллийг ODAMIS системд байршуулж, хянан тайлагнасан.	100

	тусламжийн удирдлагын мэдээллийн Одамис систем, шилэн дансанд байршуулах.			
18	“Солонго 1, 2” төслийн борлуулалтын менежментийн төлөвлөгөө, түрээслэх, түрээслээд өмчлөх, иргэдийг сонгон шалгаруулах журмын төсөл боловсруулж батлуулах.	Холбогдох 4 төрлийн журмын төслүүд батлагдсан байх	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу түрээсийн орон сууцтай холбоотой бодлого, зохицуулалтын багц журмуудыг цогцоор нь шинэчлэх үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шаардлагатай арга хэмжээнүүдийг тасралтгүй авч ажилласан. Уг чиглэлийн хүрээнд ажлын хэсэг байгуулан, эрх зүйн орчныг иж бүрэн судалж, төрийн өмчийн орон сууцны бүртгэл, сонгон шалгаруулалт, зорилтот бүлгийн иргэдийг хамруулах механизм, дахин төлөвлөлтийн үед үүсэх эрх зүйн харилцаа болон түрээсийн орон сууцыг өмчлүүлэх, борлуулах процессын бүх үе шатыг нарийвчлан хамарсан зохицуулалтын төслүүдийг боловсруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1/1180 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	50
19	Төслийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллах.	Санал гомдлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах	2025 онд “Солонго 1,2” төслийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 206 албан бичиг ирүүлж, хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлэсэн. Байгууллагын албан ёсны фэйсбүүк пэйж хуудас болон бусад цахим сувгаар нийт 331 иргэн санал хүсэлтээ илэрхийлсэн байна. 2025 онд “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 7288-7788 утас, ТОСК болон “Солонго 1,2” төслийн ажлын байранд биечлэн ирж мэдээлэл авах хүсэлтэй нийт 216 иргэнд төслийн мэдээлэл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас зохион байгуулагдсан “Барилгачдын өдөр” үйл ажиллагаанд, “Засгийн газрын цом-2025” спортын их наадмын үеэр төрийн албан хаагчдад “Солонго 1,2” орлогод нийцсэн орон сууцны хороолол төсөл хөтөлбөрийг танилцуулах ажлыг зохион байгуулан ажилласан.	100
20	Төсөл арга хэмжээг тайлагнах	Нийт 14 тайлан	Төслийн батлагдсан үйл ажиллагааны тайланг гэрээнд заасны дагуу тухай бүр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлэн ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний 4 тайлан, зохиогчийн хяналтын тайлан 4, ерөнхий гүйцэтгэгчийн 5, зөвлөх байгууллагын 6 удаагийн тайлангуудыг тус тус хянаж, холбогдох заавар зөвлөгөөг өгч, засварлуулан ХББОСЯ-нд гэрээний хугацаанд хүргүүлэн ажилласан.	100
Зорилт 4: Төслийн санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд				
21	Сангийн яамны төслүүдийн нэгдсэн мэдээллийг www.odamis.mof.gov.mn цахим системд тайлагнаж, мэдээлнэ.	Цахим системд тайлангийн тоо www.odamis.mof.gov.mn цахим системд 21 мэдээлэл оруулах	Төслийн ерөнхий гүйцэтгэгч “Колон глобал” корпорацийн 5, 6, 7-р гүйцэтгэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Самуу Жи Ви” түншлэлийн 4–9-р гүйцэтгэлийн нийт санхүүжилтийн 18 удаагийн хүсэлтийг шалган баталгаажуулж, www.odamis.mof.gov.mn системд байршуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь тайлагнасан. Санхүүжилтийн баримт бичгийн бүрдүүлэлт, системд байршуулалтын чанар, хугацаа хэвийн байсан боловч хяналт-шинжилгээний явцад мэдээллийн баталгаажуулалтын зарим үе шатанд гүйцэтгэгч талаас шаардлагатай тодруулга хоцорч ирснээс шалтгаалан баталгаажилтын хугацаа удааширсан.	100

			Мөн Зээлийн тусгайлсан хэлэлцээрийн сунгалтын 1 баримт, Төслийн удирдах хорооны 1 зөвлөмж, 2 тогтоол, туслан гүйцэтгэгч 9 компанийн импортын бараа материалын 2 батлагдсан жагсаалт зэрэг нийт 24 мэдээллийг системд бүрэн байршуулж тайлагнасан. Туслан гүйцэтгэгч 9 консерциум байгууллагын гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэхтэй холбоотой 388 хүсэлтийг системд шивж, хянан баталгаажуулж, ХББОСЯ болон Сангийн яаманд хүргүүлсэн байна.	
22	Шилэн дансны тайлан мэдээ, мэдээллийг тайлагнаж ажиллана.	Засгийн газрын www.shilendans.gov.mn 155 мэдээ, мэдээлэл байршуулж тайлагнаж ажилласан байх.	Шилэн дансны www.shilendans.gov.mn системд мэдээлэх 138 нэр төрлийн 189,5 тэрбум төгрөгийн , батлагдсан төсөв дүн бүхий мэдээллийг бүрэн оруулсан. Хугацаа болоогүй 17 мэдээлэл байна. 55,300,245,191.6 төгрөгийн зарлагын шууд төлбөрийн гүйцэтгэлийг мэдээлсэн.	100
23	Төслийн батлагдсан Санхүүгийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагаа, үйл ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яамны www.odamis.mof.gov.mn цахим системд байршуулсан байна.	Сангийн яамны www.odamis.mof.gov.mn цахим системд 1 төлөвлөгөө байршуулсан байх	Төсөл хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж, Сангийн яам болон бусад холбогдох байгууллагад мэдээлэн ажилласан байна. Төслийн удирдах хорооны 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн хурлын 04 тогтоолоор батлагдсан Солонго-1,2 төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө -1, санхүүжилтийн төлөвлөгөө-1, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-1 нийт 3 төлөвлөгөөг www.odamis.mof.gov.mn цахим системд байршуулан ажилласан байна.	100
	Дундаж хэрэгжилт			92.6

50 хувийн хэрэгжилттэй дараах 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. /12/ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж холбогдох тендер шалгаруулалтыг гүйцэтгэх, гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлийг хангуулах, дүгнэх, холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллах;

Зоритот түвшин: ШҮ-1 холбогдох хууль, журмын хүрээнд 11 тоног төхөөрөмж авсан байх.

ШҮ-2 холбогдох хууль, журмын хүрээнд 20 хүний ХАБЭА-н хувцас авсан байх.

2. /18/ “Солонго 1, 2” төслийн борлуулалтын менежментийн төлөвлөгөө, түрээслэх, түрээслээд өмчлөх, иргэдийг сонгон шалгаруулах журмын төсөл боловсруулж батлуулах.

Зорилтот түвшин: Холбогдох 4 төрлийн журмын төслүүд батлагдсан байх.

70 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. Төслийн эхний ээлжийн 980 айлын орон сууцны барилгыг улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангах;

Шалгуур үзүүлэлт: Ашиглалтад оруулах айлын тоо

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Төслийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 92.6 хувьтай “бүрэн хангалттай” гэж дүгнэв.

2. Төслийн нэгжийн 2025 оны төлөвлөгөөнд эхний ээлжийн 980 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэгч байгууллагын зохион байгуулалтаас шалтгаалан хойшилж 2026 онд 980 айлыг 2042 айлын орон сууц болгон нэмэгдүүлж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна.

3. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Солонго 1, 2” төслийн борлуулалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах, түрээслэх, түрээслээд өмчлөх, иргэдийг сонгон шалгаруулах журмын төсөл боловсруулж батлуулах гэж төлөвлөсөн нь үнэлгээ буурах нөхцөл болж байна.

4. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээг хэт ерөнхий төлөвлөсөн, төслийн барилга угсралтын ажлыг бүрэн төлөвлөөгүй байна. Барилга угсралтын ажлыг календарчилсан төлөвлөгөө, бусад төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан төслийн явцыг хэмжиж болох үзүүлэлт, арга хэмжээгээр төлөвлөн бүрэн тайлагнах шаардлагатай байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төслийн нэгж /Б.Лхагва-Очир/-д үүрэг болгох:

1. Тус төсөл арга хэмжээ нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 440-д тусгагдсан бөгөөд 2025 оны зорилтот түвшин 980 айлын орон сууц, 2026 оны зорилтот түвшин 3255 айлын орон сууц ашиглалтад оруулсан байхаар төлөвлөгдсөн байх тул боломжит байдлаар хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах;

2. Төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч барилгын талбайд ажиллах хүч, машин механизмын хүчин чадал, бараа, материалын нөөцлөлт, хадгалалт, барилгын талбайн зохион байгуулалтын үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, барилга угсралтын ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, баримт бичгийн бүрдлийг ханган, мөрдүүлж ажиллах;

3. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм, журам, БНБД, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”, “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг хэрэгжүүлэн мөрдөж ажиллах;

4. Төслийн нэгж 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулахдаа дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанаас гадна барилга угсралтын үйл ажиллагаанд хяналтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ төлөвлөх, мөн барилга угсралтын үйл ажиллагааны хийгдэх ажлуудын бүлэг бүрээр суурь түвшин, хүрэх түвшинг тодорхойлон төлөвлөж, тайлагнах;

5. Дэлгэрэнгүй тайланд төслийн хэрэгжилтийн хувийг тодорхой байхаар нэгтгэн тооцож тайлагнадаг байх, үг үсгийн алдаа, агуулгыг хянан тайланг хүргүүлдэг байх;

6. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг батлагдсан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан товч тодорхой, нотлох баримтын хамт тайлагнаж ажиллах талаар зөвлөмж болгож байна.

9.4. Хавсралт-4

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ
ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР 2025 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2026.01.02

НЭГ. ЗОРИЛГО

Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчтай 21 аймаг, Нийслэлийн Засаг дарга нарын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар 2025 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт

тавих нийтлэг журам”-ын баримтлан хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Нийслэл, 21 аймгийн Засаг дарга нар Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлсэн талаар 2025 оны гэрээний хэрэгжилтийг гаргаж ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, аймаг, бүс тус бүрээр үнэлгээг гаргалаа.

1. Архангай

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 22 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 12, 50 хувьтай 5, 0 хувьтай 4, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж 69.05 хувьтай байна.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Үнэлгээ %
			100%	50%	0%	ХБ	
1	Хот байгуулалтын чиглэлээр	8	5	2	1	-	75.00
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	5	2	1	1	1	62.50
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	6	4	-	2	-	66.67
4	Орон сууцны чиглэлээр	3	1	2	-	-	66.67
Дүн		22	12	5	4	1	69.05

Хэрэгжилт хангалтгүй 0 хувьтай арга хэмжээ 4 байна. Үүнд:

1. Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартуудыг аймагт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах /MNS ISO 37100:2024, 37101:2024, 37120:2024, 37122:2024, 37123:2024/;
2. Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллах хүрээнд томоохон төсөл хөтөлбөрийг BIM-ээр хэрэгжүүлэх;
3. Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг хянах, барилга угсралт, ашиглалтын явцад хяналт тавих, цэвэрлэгдээд гарч буй усанд хяналт тавих, нэгдсэн удирдлага, хяналтын тогтолцоо бий болгох чиг үүрэг бүхий ажилтанг аймгийн Засаг даргын тамгын газрын бүтцэд бий болгон ажиллах;
4. ШУТИС-БАСургуулийг түшиглэн Нийтийн аж ахуйн салбарын ажилтныг чадавхжуулах, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тэтгэлэгт хөтөлбөртэйгээр байгуулж байгаа ангид аймаг, суманд ажиллах 1 хүнийг сургаж бэлтгэх талаар хамтран ажиллах.

ДҮГНЭЛТ:

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Архангай аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2025 оны гэрээний хэрэгжилт 69.05 хувьтай үнэлэв.
2. “Ногоон барилгын үзэл баримтлалыг хэрэгжүүлэн ажиллах” арга хэмжээ нь эрх зүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаа бэлэн болоогүйгээс хэрэгжих боломжгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Архангай аймгийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжилт хангалтгүй 4 арга хэмжээний биелэлтийг хангахад анхаарч 2026 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

2. Ялангуяа Төрийн албан хаагчдын орон сууцны төсөл хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй байх, орон нутгийн мэдлийн газартай байх, тэдгээрийг инженерийн шугам сүлжээнд холбох бэлэн байдлыг хангах, техникийн нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах.

3. ХББОСЯ-ны хувьд гэрээнд заасан арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж хэрэгжүүлэх нөхцөлийг бодлого, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах. Үүнд:

- Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн болон Хот байгуулалтын кадастрын цахим системийн хэрэглээ, мэдээллийн сан бүрдүүлэлт, нөхөн бүрдүүлэлтэд зөвлөмж гаргах, ГЗБГЗЗЕГ, мэргэжлийн холбоодтой хамтран системийн хэрэглээнд үнэлгээ өгөх
- Ногоон барилгын стандартыг нэвтрүүлэхэд орон нутагт хэрэгжүүлэх боломжоор хангах,
- Тогтвортой ухаалаг хотын 5 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж, чиглэлээр хангах.

2.Баянхонгор

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 22 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 13, 50 хувьтай 5, 0 хувьтай 3, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж 73.81 хувьтай байна.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Үнэлгээ %
			100%	50%	0%	ХБ	
1	Хот байгуулалтын чиглэлээр	8	5	2	1	-	75.00
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	5	2	1	1	1	62.50
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	6	5	-	1	-	83.33
4	Орон сууцны чиглэлээр	3	1	2	-	-	66.67
Дүн		22	13	5	3	1	73.81

Хэрэгжилт хангалтгүй 0 хувьтай арга хэмжээ 3 байна. Үүнд:

1. Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартуудыг аймагт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах /MNS ISO 37100:2024, 37101:2024, 37120:2024, 37122:2024, 37123:2024/;

2. Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллах хүрээнд томоохон төсөл хөтөлбөрийг BIM-ээр хэрэгжүүлэх;

3. Орон нутгийн өмчит нийтийн аж ахуйн байгууллагын зардал нөхөх төлөвлөгөөг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороотой хамтран боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх.

ДҮГНЭЛТ:

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2025 оны гэрээний хэрэгжилт 73.81 хувьтай үнэлэв.

2. “Ногоон барилгын үзэл баримтлалыг хэрэгжүүлэн ажиллах” арга хэмжээ нь эрх зүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаа бэлэн болоогүйгээс хэрэгжих боломжгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Баянхонгор аймгийн хувьд гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжилт хангалтгүй 3 арга хэмжээний биелэлтийг хангахад анхаарч 2026 оны гэрээнд тусгаж хэрэгжүүлэн ажиллах.

2. Ялангуяа Төрийн албан хаагчдын орон сууцны төсөл хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй байх, орон нутгийн мэдлийн газартай байх, тэдгээрийг инженерийн шугам сүлжээнд холбох бэлэн байдлыг хангах, техникийн нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах.

3. ХББОСЯ-ны хувьд гэрээнд заасан арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж хэрэгжүүлэх нөхцөлийг бодлого, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах. Үүнд:

- Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн болон Хот байгуулалтын кадастрын цахим системийн хэрэглээ, мэдээллийн сан бүрдүүлэлт, нөхөн бүрдүүлэлтэд зөвлөмж гаргах, ГЗБГЗЗЕГ, мэргэжлийн холбоодтой хамтран системийн хэрэглээнд үнэлгээ өгөх
- Ногоон барилгын стандартыг нэвтрүүлэхэд орон нутагт хэрэгжүүлэх боломжоор хангах,
- Тогтвортой ухаалаг хотын 5 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж, чиглэлээр хангах.

3. Өвөрхангай

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу 22 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаас 100 хувьтай 12, 50 хувьтай 6, 0 хувьтай 3, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж 72.40 хувьтай байна.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Үнэлгээ %
			100%	50%	0%	ХБ	
1	Хот байгуулалтын чиглэлээр	8	4	3	1	-	68.75
2	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр	5	3	1	-	1	87.50
3	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр	6	4	-	2	-	66.67
4	Орон сууцны чиглэлээр	3	1	2	-	-	66.67
Дүн		22	12	6	3	1	72.40

Хэрэгжилт хангалтгүй 0 хувьтай арга хэмжээ 3 байна. Үүнд:

